

МОНГО АЖААЧИЙН АНД



АМЛАГЫН АНД...

**ШИДЭТ
ХҮҮРИЙН
ҮЛГЭР**

1

ШИДЭТ ХҮҮРИЙН ҮЛГЭР

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

www.kiebooks.com

Өмнөх үг

«Шидэт хүүрийн үлгэр» нь угийн энэтхэг гаралтай зохиол юм. Энэ үлгэр Энэтхэгийн санскрит болон бусад хэлээр «Виталийн хорин таван үлгэр» нэртэй байдаг ажээ. Энэтхэгийн ямар нэг хэлээс төвдөд орчуулсан бололтой. «Шидэт хүүрийн үлгэр» Монголд аль хэдийн дэлгэрч зарим бүлэг нь ардын аман зохиол болж хувирсан байна. Үүнд: «Цэцэн туулайн үлгэр»-ийг дурдаж болно. Энэ үлгэрийг Дорж мэйрэн найруулан засаад «Туулай, төлөг, чоно гурвын үлгэр» нэртэй бичгийн зохиол болгосныг бид бэлхнээ мэдэх билээ. Түүгээр үл барам монгол аман зохиолын түүвэрт Шидэт хүүрийн үлгэр»-ээс авсан бололтой зүйл олон байдаг.

Монгол шидэт хүүрийн 26 үлгэрийг 1928 онд Улаанбаатарт хэвлүүлжээ. Мөн энэ 26 үлгэрийг 1957 онд хуулан Хөх хотод хэвлэсэн байна. Бас манайд шидэт хүүрийн үлгэрийг орос хэлээр хоёр удаа (1923 онд Жамсраны Цэвээн, 1959 онд Бямбын Ринчен) хэвлүүлжээ.

Бээжингийн монгол бичгийн хорооноос Харчины Тэмээт «Шидэт хүүрийн цадиг» хэмээх нэрээр 14 үлгэр хэвлүүлсэн нь бий.

Орос болон Европт «Шидэт хүүрийн үлгэр»-ийг сонирхон орчуулж судлах хэвлэх ажил мөн л эрт эхэлжээ. Академич профессор Ц.Дамдинсүрэнгийн судалгаанаас иш татвал 1802–1803 оны үед В. Бергман «Шидэт хүүрийн үлгэр»-ийг халимагаас германд 1860 онд профессор Голстунский мөн үлгэрийг халимаг хэлээр тод үсгээр, 1866 онд Б. Юльг халимаг герман хэлээр, 1865–1868 онд Буриад лам Гомбын Галсан орос хэлээр орчуулж хэвлэсэн. 1868 онд Б.Юльг мөн үлгэрийн 9 бүлгийг герман хэлээр дахин хэвлэсэн ажээ. Эдгээр орчуулга болон хэвлэл бүрэн сайн болж чадаагүй олон дутагдалтай байжээ.

Харин 1923 онд алдарт эрдэмтэн Владимирцов Халимагаас орос орчуулж судалгааны оршил бичиж хэвлүүлсэн «Шидэт хүүрийн үлгэр» нь бүрэн сайн эхээс хамгийн нягт хийсэн орчуулга болжээ. Энэ орчуулга 1958 онд Москвад дахин хэвлэгдсэн байна. Энэ номд эрдэмтэн Г.Кара товч сонирхолтой шүүмж бичиж Мажарын эрдэм шинжилгээний хэвлэлд нийтлүүлжээ. Эдгээрээс гадна европын аль нэг оронд энэтхэгийн шинэ хуучин хэлний шидэт хүүрийн үлгэрийг уламжлуулан орчуулсан нь олон ажээ.

Энэтхэгт санскрит хэлээр «Шидэт хүүрийн» 25 үлгэрийн таван хувилбар байдаг гэнэ. Түүний хоёр хувилбарыг О.Шор 1939, И. Серебрякова 1959 онд Зөвлөлтөд орос хэлээр гаргажээ.

Академич профессор Цэндийн Дамдинсүрэн дээрх хоёр орчуулгыг монгол төвд шидэт хүүрийн үлгэртэй харьцуулан үзэж судалсан. Энэ тухай «...харьцуулан үзэхэд уг зохиолын хэлхээ хэлбэр төстэй боловч үлгэрүүд огт өөр байна» гэж тэмдэглээд Халимагийн эрдэмтэн Б. Бадма Шидэт хүүрийн 12 үлгэрийг хүнээр яриулан бичиж аваад Элст хотод хэвлүүлсэн. Энэ 12 үлгэр нь Шидэт хүүрийн үлгэрээс гаралтай боловч ард олны амаар дамжсаар яваад ардын зан суртахууныг шингээж жинхэнэ халимаг үлгэр болж хувирчээ» гэж бичжээ.

Манай улсын номын санд «Шидэт хүүрийн үлгэр»-ийн гурван өөр монгол хувилбар бий. Мөн Гандантэгчинлин хийдийн номын сан болон хүмүүсийн хувийн цуглуулгад монгол төвд хэлээр бичсэн олон хувилбар байж болох ажээ.

Энд хэвлэж байгаа 26 бүлэг төвд Шидэт хүүрийн үлгэр Булган аймгийн Шагжсэнгэ гэдэг хүнд байжээ. Эхний 13 бүлэг нь манай оронд төвд монголоор элбэг байдаг бөгөөд сүүлийн 13 бүлэг нь монголоос төвдөд орчуулсан үлгэрүүд юм. «Түүнийг 1924–30 оны үед Лувсанцэрэн гэгч лам заримыг монголоос төвд хэлэнд орчуулж зарим бүлгийг хянасан бололтой» гэж Ц. Дамдинсүрэн баримт дурдан иш татсан нь бий.

Эл номын 27 дугаар бүлэг буюу «Шатны арван гурван гишгүүрийн үлгэр»-ийг гүүш Цоржийн орчуулсан «Хөвгүүн ном»-оос авч бидний хэрэглэсэн эхэд оруулсныг буулгасан болно.

Энэ бүхнийг эс өгүүлэн өгүүлэх нь:

Уншигч танаа толилуулж байгаа энэ ном нь шинжлэх ухааны академийн хэл зохиолын хүрээлэнгийн ажилтан төвдөч Цэдэнбалжнр Алтангэрэл нарын орчуулж 1963 онд хэвлэсэн төвд монгол үсгийн номоос кирилл бичигт хөрвүүлсэн нь болно.

Монгол бичгээ сэргээн хэрэглэх сайхан эхлэл нэгэнт бий болсон боловч өвгөд дээдсийнхээ үлдээсэн үнэ цэнтэй өв их соёл ном судрыг энэхэн хооронд уншиж чадахгүй хоцрохоос нь болгоомжлон кирилл бичигт буулгахдаа төвд хэлээс монголд буулгасан эртний тансаг яруу найруулгыг алдагдуулахгүйг хичээхийн гадна, уншигч танаа ойлгомжтой болгон хүргэх гэж бага зэрэг найруулсан болохыг өчсү. Алдаа эндэл буй аваас уучлахыг эгээрмү.

Олон зүйл нуршин уншигч таныг чилээсэнд хүлцэл өчиж «Шидэт хүүрийн 27 үлгэрийг» уншигч танаа өргөн баръя. Таалан соёрхогтун.

А. ДАШДЭМБЭРЭЛ

ШИДЭТ ҮХДЛЭЭС БАЯНЫ ХӨВГҮҮНИЙ ЯВСАН ЭН ТЭРГҮҮН ЗҮЙЛ

Ялгуусны живангарид үзүүлсэн лусыг бүтээгч зүрхэн хэмээгч илт гадаад дотоод арилсан савын зүрхэн дундад үзлийг үзүүлэн үйлдэгч итгэл тэрхүү хоёрдугаар багшид мөргөм үү.

Тэр ч Наганжуна багш хийгээд Сайн амгалан явдалт хаан хоёр гайхамшиг тансаг болсон мэргэдийн үйлс хийгээд хотол ардын үйл ёсоор авахуй аливаа хэрэгтнийг оюундаа оруулж бүрүн. Номлохуй хийгээд сонсохуй ба урьсны төдийхнөөр ерийн шид болно хэмээх үгсийн язгуурыг үзүүлнэ. Түүнийг өгүүлэхийн шалтгаан нь Хутагтны улс дахь дунд газар ах дүү долоон илбэч хүн буй ажгуу. Түүн лүгээ хол бус нэгэн бээрийн газар одвоос нэгэн агуу хүчин төгссөн хаанд ах дүү хоёр буйгаас ах нь илбэчний илбэ сурахаар одож, долоон жил заалгаад илбэчний илбийн оньсыг үнэнээр эс сурчээ. Хэзээ нэгэн цагт дүү нь ахдаа хүнс хүргэж очихдоо хаалганы завсраар шагайж харах үе, илбийн оньсыг сураад, ахдаа хүнсээ өгөлгүй хоёул орд харшдаа харив. Тэндээс дүү нь ахдаа

– Илбэчин илбэ сурсныг маань мэдэх болуузай. Бидний хороонд нэг сайн морь бий. Чи түүнийг хөтлөөд долоон илбэчний зүгт бүү яв, өөр оронд одоод эд агуурсыг худалдаж аваад ир хэмээн өгүүлээд өөрөө тэр моринд хувилав.

Ах нь дүүгийнхээ үгээр болж,

– Би долоон жил болтол илбэ эс сурав. Дүү минь ийм сайн морь олжээ. Үүнийг хэрэглэхгүй байж яаж болох вэ гээд унав. Унах болоод илбийн авьяасаар морио залж эс чадаад, илбэчний гадна хүрэв. Тэндээс

– Зугтааваас үл гарна. Мөнхүү энэ илбэчинд худалдсугай! хэмээн сэтгээд,

– Миний дүү ийм нэгэн сайн морь олсон бүлгээ. Та үзнэ үү хэмээн асуухад тэдгээр илбэчин, илбийн морь байна гэдгийг мэдээд «энэ мэт илбийг бүгдээрээ сурваас бүрэн худалгүй болоод илбээр гайхамшигтай болохгүйн тулд үүнийг алсугай!» хэмээн сэтгэж, тэр морийг худалдаж үнийг нь хэлснээр өгч авлаа. Тэндээс илбэчин тэр морийг харанхуй хороонд уяад хэзээ алах цагтаа цус нь арвитахын тулд зарим нь толгой, дэл, сүүлийн үзүүр, гуянаас бариад алуулалгүй мөрний алсад хөтлөн одоход, тэр морь

– Аяа ах минь эс чадав. Өдгөө эдний гарт орлоо. Хувилган егүүтгэх ямарваа нэгэн амьтан ирээсэй гэж бодтол усанд нэгэн загас умбан хөвсөөр ирэхийг үзээд түүнд хувилав. Долоон илбэчин долоон цахлай болоод хөөв. Барих дөхсөнд огторгуйд нэгэн хүүрзгэнэ нисэж ирэхийг үзээд түүнд хувилав. Илбэчин долоон харцага болж уул голгүй үлдэн хөөж хүрэх үед өмнө зүгт Бидийн орны Цогт ууланд амирлуулагч нэрт хүлэмж хадны дотор Наганжуна багш сууж байхад өвөрт нь орж явчхав. Долоон харцага хүлэмжийн хаднаа ирээд долоон расванар болж хувилав. Багш гэгээн Энэ хүүрзгэнийг долоон харцага үлдэхийн шалтгаан нь юу билээ хэмээн бодоод,

– Хүүрзгэнэ ээ, энэ мэт айж зүдсэний учир юу вэ? гэж асуусанд тэр урьд шалтгааныг нарийн тоочиж, өдгөө бидний хүлэмжийн гадна долоон расванар бий. Тэд багшийн өмнө ирээд, багшийн барьсан эрихийг гуйна. Тэр цагт би эрихний толгойд хувилж орно. Багш эрихээ

соёрхохдоо толгойг нь амандаа үмхээд, эрихээ цацаж соёрх хэмээн хэлэв. Тэгтэл долоон расванар ирээд багшийн эрихийг гуйсанд толгойг нь амандаа үмхээд эрихээ гадагш нь цацтал нэгэн зуур хорхой болов. Долоон расванар долоон тахиа болоод нөгөө хорхойнуудыг идэв. Тэндээс багш даруй амнаасаа эрихний толгойг гаргасанд хүн болоод бэрээ барьж, долоон тахиаг алав. Алуулахын үед долоон хүний үхдэл болсонд багшийн сэтгэл маш их зовоод

– Би ганц чиний амийг авраад энэ долоогийн амийг үхүүлсэн нь маш сайн бус хэмээн зарлиг болсонд тэр хүн

– Би бол нэгэн хаан хүний хөвгүүн бөлгөө. Багш ганц миний амийг аврахын тулд эдгээр бүгдийг үхүүлэх нүглийг арилгахын тулд ав аль зарлигийг чинь илт магтсугай хэмээн өчсөнд багш:

– Тийм бол сэргэлэн ойтой үхээрт шидэт хүүр хэмээх бэлхүүснээс дээш нь алт, доод тал нь зэс, тэргүүнд лавай өнгөт бөлгөө. Түүнийг чи хатуужиж авч чадах уу? Чадах юм бол би түүгээр алт бүтээвэл эл замбутивийн хүн мянга насалж ерийн нэгэн гайхамшигт шид болох бөлгөө хэмээн зарлиг болсонд тэрээр тийн ам алдав.

– Миний явах зам болон үйлдэх арга, авч явах хүнс тэргүүтнийг зааж өгч соёрхтугай. Зарлигаар чинь больё гэж өчсөнд багш

– Тийм бөгөөс эндээс нэгэн бээрийн газар очиход маш харанхуй модтой аймаар хавцал, голд маш их үхдлүүдээр дүүрсэн байгаа. Чамайг тэнд очиход тэд бүгдээрээ босож ирнэ. Тэдний ихэнх үхдлүүдэд хала хала, суухаа! хэмээн эдгээр тарнидсан арвай цацаж, түүнээс цаахан нь голд өчүүхэн хүүр олон байгаа. Тэдгээрт өчүүхэн үхдлүүд хэмээвээс хулу хулу суухаа хэмээн цац! Түүнээс цаахан нь нялхсын үхдэл ри, Ри ч бид хэмээн цац. Тэдгээрийн дундаас шидэт хүүр цааш буруулж, Амир нэрт модонд авирч гараад сууна. Тэр цагт чи цагаахан сар нэрт сүхээрээ модны ёзоорыг манахын дүр үзүүлвээс бууж ирнэ. Түүнийг зуугаадыг багтаагч алаг уутандаа хийж зуун гурмасын эрээн дээсээрээ боож, идэж барагдашгүй тост гурилаа идээд, үүрч нэг ч үг дуугаралгүй яваад хүрч ир хэмээгээд амирлуулагч хүлэмж хаданд хүрч ирсний хойно Амгалан сайн явдалт хаан хэмээн нэр өгөөд, замыг зааж өгч явуулав. Тэр хаан багшийн зааж өгсөн аюулыг арилган явсаар хүрсэнд өнөө шидэт хүүр үзээд, амир нэрт модонд авирав. Тэр модны ёроолд очоод

– Багш минь Наганжуна мөн. Сүх минь цагаахан сар нэртэй буюу. Хүнс минь барагдашгүй тост гурил мөн. Сав минь зуугаадыг багтаагч алаг уут билээ. Дээс минь зуун гурамсан эрээн дээс бөлгөө. Би өөрөө Амгалан сайн явдалт буюу. Үхдэл чи бууж ир! Эс ирвээс модыг чинь огтолно хэмээн өгүүлсэнд

– Модыг минь бүү огтол. Би бууж очъё гээд бууж ирсэнд уутандаа хийгээд дээсээрээ боож тост гурилаа идээд үүрч олон өдөр явсанд шидэт хүүр өгүүлрүүн:

– Өдөр урт учир алжааж байна. Эсвэл чи, эсвэл би нэгэн хууль өгүүлье! гэхэд хаан дуугарахгүй явсаар л байв. Тэгэхэд хүүр

– Чи өгүүлэхгүй бол толгойгоо дохь гэсэнд хаан дуугарахгүй толгойгоо дохив. Тэгтэл шидэт

хүүр хууль өгүүллрүүн

– Тэндээс балар эрт нөгчсөн цагт баяны хөвгүүн, модчины хөвгүүн, эмчийн хөвгүүн, зураачийн хөвгүүн, тоочийн хөвгүүн, төмөрчний хөвгүүн зургуул эцэг эхээсээ оргон нэгдэж, хүнс аваад өөр нэгэн улс руу явжээ. Нэгэн голын бэлчирт хүрээд тэнд хүн бүр нэг нэг сүнсний мод босгоод өөр өөрийн голд идээ эрэхээр одож зургаан жил болоод эндээ уулзацгаая гэж болзоод хэрвээ хэн нэг нь эндээ ирэхэд бидний мод өнгө хувхайрсан болбоос түүний явсан зүгт явья хэмээн тогтжээ.

Баяны хүү нэгэн голыг өгсөж явахад тэр голын эхэнд ой, өлөн хоёрын уулзварт нэгэн жижигхэн байшин байх бөгөөд хаалганы нь дэргэд очив. Тэнд их өтөлсөн өвгөн эмгэн хоёр байжээ. Тэр хоёр

– Хүү чи хаанаас ирж хааг зорьж явна вэ? гэхэд Хүү

– Би холоос ирсэн билээ. Идээ эрэхийн тулд энд ирэв гэхэд өвгөн эмгэн хоёр

– Тийм бол чиний ирсэн чинь сайн байна! Бидэнд бие бялдар сайхан, гоо үзэсгэлэнтэй нэгэн охин бий. Чи түүнийг аваад миний хүү бол гэх үед тэр охин гадаа ирсэнд түүнийг үзээд «эцэг эхээсээ буруулж ирсэн минь зөвдлөө. Энэ тэнгэрийн охидоос ч үлэмж гайхамшиг үзэсгэлэнт буюу. Үүнийг аваад энд сууя» гэж бодов. Тэр охин:

– Хүү чи ирсэн чинь маш сайн гээд хэдэн үг солилцон ойлголцож гэртээ орж амраглан жаргаж суув. Тэр голын адагт нэгэн их хаан байдаг ажээ. Түүний зарц нь хавар усанд наадан явж байтал голын эхэнд баяны хүүгийн гэрийн элдэв зүйлээр үүдсэн бэлзэг усанд урсаж ирэхийг аваад тэр маш үнэтэй эдлэл тул хаандаа аваачиж өгөв. Хаан түүнийг үзээд ихэд гайхаж зарцдаа

– Энэ голын эхэнд энэ бэлзгийг зүүсэн нэгэн хатан буй ажээ. Түүнийг миний дэргэд авчир гэж илгээжээ. Тэр ирж түүнийг үзээд түүнийг үзэсгэлэнг үзэж ханашгүй сайхан юм гэж гайхан бодоод очиж

– Хаан чамайг авчир гэлээ гээд баяны хүүгийн хамт авчирч хаанд өгөв. Хаан үзээд

– Энэ бол тэнгэрийн охин буюу. Үүний дэргэд миний бусад хатад нохой гахайн адил хэмээн зарлиг болоод тэр охиныг үлэмж дотночлов. Охин хааныг бус гагцхүү баяны хүүг л сэтгэлдээ бодон сууна. Энэ байдлыг хаан ухааж мэдээд зарцдаа

– Энэ баяны хүүг үгүй болго хэмээн тушаав. Тэр хүүг наадамд авч яваад нэгэн мөрний хязгаар газар авчирч булаад дээрээс нь том хадаар дарж алав.

Тэндээс нөхөд нь зүг зүгээс нөгөө болзсон газраа цуглан ирж үзвэл баяны хүү байхгүй сүнсний мод нь хувхайрсныг хараад түүний явсан голд ирж эс олсонд тоочийн хүү тоолж үзээд тэр баяны хүү ийм нэгэн газарт их хаданд дарагджээ хэмээн мэдээд эрж олоод хадыг зайлуулах арга эс олсонд төмөрчний хүү алх авч тэр хадыг хэмхчин худаг малтаад хүүрийг нь гаргав. Эмчийн хүү үхснийг эдгээх эм найруулж аманд нь цуггаснаар амилан босож юу

болсныг асуулцан ярилцаад

– Чи ямар шалтгаанаар үхэв гэж асуужээ. Хүү болсон явдлыг нэгбүрчлэн өгүүлсэнд нөхөд нь

– Тийм гоо эм бөгөөс гайхамшигтай ажгуу. Одоо яаж түүнийг ямар аргаар авах вэ гэж зөвлөлдөж, модчийн хүү модоор гарди үйлдээд дотор нь орж дээш нь дэлдвээс дээшээ, доош дэлдвэл доошоо, хөндлөн дэлдвээс хөндлөн явах ийм унааг сэдэж хийв. Түүнийг зураачийн хүү элдэв будгаар будаад амьд мэт болгожээ. Түүний дотор баяны хүү ороод халин нисэж хааны орд харшийн дэргэд эргэн тойрон байхад хаан болон шадар түшмэд нь үзээд гайхаж

Энэ мэт шувууг урьд эс үзэв. Сонсоогүй юм байна гээд хатандаа хэлж орд харшийн давхар дээр элдэв зүйлийн идээг өг гэсэнд хатан нь идээ аваад орд харшийн дээр гарч суухад, тэр шувуу тэнд бууж ирээд үеийн хоёр модон гардийн хаалгаар золголдсонд хатан ихэд баясаж

– Чамтай золголдох сэтгэлийн дотор чи үгүй байтал өдгөө золголдох болжээ. Энэ хувилгаант шувууг яаж бүтээгээ вэ гэсэнд өнгөрсөн явдлыг бүгдийг нарийлан тоолж өгүүлээд

– Өдгөө хааны хатан болсоор сууна уу? Хоёул үнэн дураар гэргий бололцох аваас энэ модон гардийн дотор наашаа ор. Огторгуйгаар нисэж одвоос хор хомс үл болно гэсэнд хатан

– Чамтай баясалцъя, урьд учралдсан нөхрийн дээд хэмээн өгүүлээд тэр модон гардийн дотор ороод огторгуйгаар нисэж одоход хаан түшмэдийн хамт ирээд

– Аяа, сэтгэлд зохист тэр шувуунд идээ өгөхийн тулд хатнаа илгээсэнд хатныг минь огторгуйд авч одов хэмээн газарт хөрвөөн гашуудав. Тэндээс баяны хүү модон гардийн оньсыг доош дэлдээд, нөхдийнхөө дэргэд бугаад урьдаар өөрөө гарч ирсэнд нөхөд нь

– Хэрэг чинь бүтэв үү гэв.

– Хэрэг минь маш сайн бүтэв гэв.

Хатнаа гаргаж ир гэхэд хатан гарч ирэхэд нөхөд нь үзэж маш гоо үзэсгэлэнтэй тул сэтгэлээ ихэд тачаав. Тэндээс баяны хүү

– Та нар минь надад их тусаллаа. Намайг үхсэн байхад олж эдгээгээд, энэ гэргийг минь авах аргыг зааж өгөв. Одоо би ачийг чинь хариулна. Биднийг бүү хагацуул хэмээн өчсөнд Тоочийн хүү үл зөвшөөрөн:

– Чамайг байгаа үгүйг эс мэдэх тул миний тооцоолж мэдсэнээр түүнд шүтэж хатныг авсан болой. Хатныг надад өг хэмээсэнд уран хүний хүү

– Чи тооцоолж мэдсэн боловч их хадны доороос яаж авах бөлгөө. Хадыг хагачиж үхдлийг гаргаснаар хатныг авав. Хатан минийх гэсэнд эмчийн хөвгүүн

– Хадыг хагачиж үхдлийг гаргавч тэр үхдэл хатныг хэрхэн авах бөлгөө. Би үхснийг эдгээх эмээр эдгээсэн түүнд шүтэж авлаа. Хатныг би авна гэсэнд модчийн хүү

– Эмээр эдгээсэн ч, модон гарди үгүй бол хатныг яаж авах билээ та. Хаанд цэрэглэж үл чадах биз. Орд харшийн дотор хүн үл орохын тулд хатныг авах аргагүй. Миний модон гардиар авсан болой. Хатныг надад өг хэмээсэнд зураачийн хөвгүүн үл болон

– Чиний хувхай модон гарьдад хатан идээ өгөхөөр ирэхгүй. Би элдэв зүйл будгуудаар будаж, үзэх мэт болгосноор хатныг авсан буй хэмээн хоорондоо муудалцаж охиныг хутгаар цавчилж алав хэмээсэнд Хаан

– Хөөрхий, хайран охин хэмээн өгүүлсэнд, шидэт хүүр

– Заяагаа барсан хаан үг алдав. Сарвад үл сууна хэмээгээд алдуулан нисэж одов.

ҮГЭЭГҮЙ ХҮН ЯВСАН НӨГӨӨ ЗҮЙЛ

Тэндээс балар эрт нөгчсөн цагт сэрүүн ойт үхээрт шидэт үхдлийг авахаар зорчоод, амир модны ёзоороос огтлохын дүр үзүүлээд

– Үхдэл чи бууна уу? Модыг чинь огтолно хэмээсэнд модыг бүү огтол. Би бууя хэмээгээд бууж ирэв. Түүнийг уугандаа хийж, дээсээрээ боогоод, тосноос идэж, үүрч олон хоног явахад хүүр

– Өдрийн уртад уйдаж байна. Чи нэгэн сайхан тууль өгүүл. Эс бөгөөс би өгүүлье хэмээсэнд хаан дуугаралгүй толгой дохисонд тэрээр үлгэр хэлэв. Эрт урьд нэгэн их Бажира улсад нэгэн их хаан байжээ. Тэр голын эхэнд нэгэн их бүрд буй. Лусын хоёр мэлхий тэр бүрдний урсахыг хааж, тариачинд ус үл урсгахад, арга буюу тэр мэлхийд хүнээр идэш өгөх хэрэгтэй болов. Хэзээ нэгэн цагт хаанд хишиг хүүрч ирсэнд, эс зөрчвөөс хааны оронд хан хүү их хэрэгтэйн тулд, үл одохын аргагүй, одвоос хаан эцэг, хөвгүүн хоёроос өөр үгүйн тулд эцэг хөвгүүн үе хоёр хэн нь одъё хэмээн зөвшин, зовниж эцэг хаан нь:

Би насан болж буй тул юунд хайрлах билээ, би одъё, Хөвгүүн минь чи хан орноо номчлон мандуултугай хэмээн зарлиг болсонд хөвгүүн нь:

Ээ! тэнгэр минь юун, номчлон асрагч хаан эцэг минь. Ажрах ёст бус. Хаан хатан хоёр үгүй бөгөөс хөвгүүд ямар хэрэг болно. Мэлхийн идшинд би одъё хэмээгээд явахад улс иргэн нь бүгдээр уйлсаар үдэв.

Тэр хөвгүүн өчүүхнээсээ ханилсан нэгэн үгээгүй хүний хөвгүүнд

– Чи эцэг эхийнхээ үгээр өөрөө мэнд амгалан суу. Би хааны хан орон хийгээд хааны зарлигийг үл хариулахын тулд, мэлхийн идшинд одно хэмээсэнд үгээгүй хүн маш гашуудаад уйлан:

– Намайг өчүүхнээс хаан чи асарч хайрласан эцэг эх билээ. Чиний оронд би явья хэмээн өчвөөс хаан үгийг үл сонсон үнэн нөхөр үе хамтаар зорчиж, тэр бүрдний ойр хүрэхэд, бүрдний захад шар, хөх хоёр мэлхий өгүүлэлдэхийг сонсов. Тэр хоёр энэ хааны хөвгүүн нөхөр хоёулаа мэдэх бөгөөс бид хоёрын тэргүүнийг бэрээгээр нэжгээд дэлдээд, алтан мэлхий намайг хааны хөвгүүн залгиад, зэс мэлхий намайг үгээгүй хүний хөвгүүн залгиваас, энэ хоёрын бөөлжис бүгд, алтан хийгээд зэс эрдэнээр бөөлжөөд, энэ цээл дэх мэлхийд идэш өгч үл болох бөлгөө. Эд нар үл мэднэ хэмээн өгүүлэлдэхийг сонсоод тэр хааны хөвгүүн хамаг амьтны хэлийг мэдэгчийн тулд, түүнийг мэдээд ноён боол хоёулаа бэрээгээр толгойг нь цохиод нэжгээд нэжгээд залгисанд, алтан хийгээд оюу эрдэнэ хэдий хэрэглэснээр бөөлжих болов. Тэндээс боол нь

– Үе хоёр мэлхийг алаад, усыг урсгав. Гэртээ харья хэмээсэнд хааны хүү зөвшөөрсөнгүй. Өөрийн орондоо хариваас өөд босож ирэв хэмээх буй заа. Түүнээс хол өөр нэгэн оронд одвоос сайн хэмээгээд, нэгэн давааг давж явав, Тэр давааны оройд дарс худалдагч гуа үзэсгэлэнт эх, охин хоёрын гэрт хүрээд, дарс авья хэмээв. Дарсны үнэд юү өгөх бэ? хэмээхэд, алт хийгээд зэс бөөлжиж өгсөнд тэр хоёр улам амтшиж гэртээ оруулаад дарсыг ихэд өгч согтоож, алт хийгээд зэсийг бөөлжүүлж аваад, гадаа гаргаж орхив. Тэндээс сэрээд, яах аргаа

эс олж, цааш яваад нэгэн голын бэлчирт хүрвэл тэнд нэгэн далайн дунд олон хүүрийн чуулж тэмцэлдэн бүхийг үзээд

– Та нар юунд тэмцэлдэнэ вэ гэсэнд

– Бид бүхэн энэ нэг малгай олоод, түүнийг булаалдана гэсэнд

– Үүгээр юу хийнэ гэхэд хүүрүүд

– Энэ малгайг толгойдоо өмсвөөс тэнгэр, чөтгөр, хүн гуравт үл үзэгдэнэ гэв.

Тийм бөгөөс та бүгд энэ далайн захад очоод уралдаж ир. Малгайг би хадгалж байя. Хэн урьдаж ирсэнд нь өгсүгэй гэхэд тэр хүүрүүд далайн хязгаараас уралдаж ирэхэд, үгээгүй хүний хөвгүүн тэр малгайг өмсөж байсанд, тэд эс үзээд

Цугаар энд байв. Өдгөө үгүй хэмээн эрж эс олоод цурхиралдан уйлалдсаар харьж одов. Түүнээс цаана нэгэн их талд олон хөлчид тэмцэлдэн байв.

Та нар юунд тэмцэлдэнэ вэ хэмээсэнд, бид энэ гутлыг булаалдана гэв.

Түүгээр яадаг юм бэ гэхэд, үүнийг хөлдөө өмсвөөс аль сэтгэсэн газар хүргэдэг гэв.

Тийм бөгөөс та нар энэ замын адгаас нааш уралдаж ир, түрүүлж ирсэн тань автугай гэсэнд тэд уралдаж ирэхэд гутлыг өвөрлөөд, малгайг өмссөнд тэдгээр хөлчид эс үзэж олж ядаад харьж одов. Тэндээс ноён боол хоёр нэжгээд нэжгээд хөлдөө гутал өмсөж, нэгэн хаангүй улсад хан ор суулгах газар хүртүгэй хэмээн зорин ирээд унтав. Маргааш эрт сэрвэл, хан ор суулгах газар нэгэн их хөндий модны дотор хүрсэн байв. Тэр өдөр их чуулган чуулж заяач тэнгэр огторгуйгаас бэлгэ орхино. Тэр бэлэг хэний тэргүүнд тусвал түүгээр хан суулгана гэсэнд заяачийн бэлгэ хөндий модонд туссанд тэндээс бүгдээр

Энэ юү болов? Модоор хүний хан яахан болгох билээ хэмээлдээд зарим нь модны дотор байж магадгүй, үзтүгэй хэмээж үзвээс хааны хөвгүүн нөхөр хоёр гарав. Тэднийг эс итгэж энэ хязгаар улсын хүн буюу. Маргааш бөөлжүүлж дэнсье гэлцээд тархав. Маргааш зарим нь сүү уугаад цагаанаар бөөлжих, зарим нь ногоо идэж ногооноор бөөлжих тэргүүтэн өөр өөр зүйлээр бөөлжөөд хааны хөвгүүн алтаар, өлсгөлөн хүний хөвгүүн зэсээр бөөлжөөд хан улсын хаан түшмэл хоёр болов. Тэр улсын урьд хааны нэгэн үзэсгэлэнт охин ажгуу. Түүнийг гэргий суулгав. Хааны харшийн дэргэд нэгэн их өндөр харш буй. Түүнд тэр хатан өдөр бүр одоход нь түшмэл нь:

Энэ хатан юуны тулд энэ харш дотор өдөр бүр одно хэмээн сэтгэж малгайгаа өмсөөд хатны хойноос дагаж одвоос, хаалгыг нь тайлаад, улам улам шат тавьсаар, тэр харшийн үзүүрт хүртэл одов. Тэнд маш сайхан өндөр дэвсгэр дэвсээд, элдэв зүйл идээ ундааныг бэлдээд тэр гэрт хатан өөрийн хувцасны чимгүүдээ арилжиж, хив торгыг өмсөн, угаалга хийгээд, хүж сүрчиг тэрүүтнээр чимж, агар шатааж суухад, түшмэл түүний дэргэд, тэнгэр, хүн, чөтгөр гуравт үл үзэгдэх малгайгаа өмсөөд харж суутал, хоромхон болоод огторгуйгаас маш үзэсгэлэнт нэгэн шувуу сүрхэртэл нисэж ирэхэд тэр хатан хүж шатааж одсоноор тэр орд

харшийн дэргэд маш зөөлөн хавтгай хүр дээр тог тог дуун гаргаж буугаад шувуун гэрийн дотроос тэнгэрийн хөвгүүн сэтгэлт хэмээх орны жишгээс нөгчсөн гуа үзэсгэлэнт гарч ирээд, нэг нэгнээ тэврэлдээд хив торгон зөөлөн олбог дэвсгэр дээр сууж, элдэв зүйл идээ ундаанаар тахин үйлдэв. Тэндээс тэнгэрийн хөвгүүн

– Маргааш үдэш чамд заяасан гэрийн эзэн буй буюу. Тэр ямар хэмээн асуусанд, хатан

– Хойно ямар болохыг эс мэдэв. Өчүүхэн наст буюу, үүнээс гэм эрдэм хоёр нь эс ухагдав хэмээгээд тэр өдөр тарав. Хатан урьдын адил чимгүүдээ өмсөөд хааны дэргэд очив. Түүний маргааш нь урьд ёсоор одоход, түшмэл бас дагаж одов. Тэр өдөр тэнгэрийн хөвгүүн

– Маргааш эрт чиний гэрийн эзнийг үзсүгэй. Нэгэн бялзуухайд хувилж ирсүгэйг хэмээсэнд хатан

– Таныхаар болтугай хэмээгээд тэр өдөр тарав. Түшмэл нь хаандаа

– Тэр орд харшийн дотор тэнгэрийн хөвгүүн Дамба Дүгэр Сүглэгэт хэмээх маш гуа үзэсгэлэнт бүхий суух шалтгааныг тоолж өгүүлээд, тэр чамайг үзэхийн тулд маргааш эрт бялзуухайд хувилж ирнэ. Маргааш суух газар нэгэн хэсэг их гал түлүүлнэ. Би тэр бялзуухайн сүүлний өднөөс аваад галд хийнэ. Хаан даруйд илдээр ал хэмээн өгүүлэв. Маргааш хаан хийгээд хатан бүгд зэрэгцэн суун бүхүйд тэнгэрийн хувилгаан өчүүхэн эрээн бялзуухай шувуу болж, шатны дээр ирээд суухад, хатны сэтгэл ихэд баясаж хяламхийж үзэхэд, түшмэл үл үзэгдүүлэгч малгайгаа өмсөөд, гэнэт бялзуухайн сүүлнээс барьж аваад галд хийв. Илдээр хаан цавчин завдахад, хатан нь хааны гараас барьснаар илдэнд эс оногдвоос, галд жигүүр нь хярвайтал түлэгдээд огторгуйд нисэн одов. Хатан ай хөөрхий хэмээгээд үхэтхийх төдий зовлонт болов. Түүний маргааш бас одоход түшмэл бас л дагаж явав. Урьдах мэт дэвсгэр бэлдэж өнө уртад уриваас эс ирж, маш зовниж, ямагт огторгуй өөд ширтсээр сууна. Тэндээс хэзээ хойно тэр шувуу урьдахаас муужирч, салгалан ирээд, шувуун гэр дотроос хулгана хавдраар боогдсон, өөх цус нь цуварсан тийм нэгэн хүн болж ирсэнд хатан түүнийг үзээд уйлав. Тэнгэрийн хөвгүүн

Бүү уйлтугай, чиний тэр эзэн маш цог жавхлантай буюу. Би галд түлэгдэв. Одоо бие минь халсны тулд чам руу ирж үл чадна хэмээсэнд, тэгж бүү зарлиг бол. Урьд ёсоор ир хэмээгээд үеийн хоёр янаглав. Сар бүрийн арван таванд золголдох болов. Тэндээс тэнгэрийн хөвгүүн огторгуйд нисэж одов. Хатан хаандаа үлэмж маш сүсэг бишрэл төрүүлж авай. Тэндээс бас түшмэл нь малгайгаа өмсөөд нэгэн бухар хийдэд хүрээд, хаалганы завсраар үзвээс тэр бухар хийдийг хадгалагч хүн нэгэн эвхсэн цаасанд, илжигний бие зурсныг дэлгээд, түүний дээр хөрвөөж нэгэн их илжиг болж босоод, их дуун гарган өөд уруу гүйж, жич бас хөрвөөгөөд мөн хүн болчхов. Тэндээс цаасаа эвхэж, бурхны гарын завсарт хийж гадагш гарч одсоны хойно, түшмэл орж тэр цаасыг аваад, урьд сайн эс хийсэн дарс худалдагч эх охин хоёрын дэргэд очоод, та хоёр сайн хийсний тулд ажиллах гэж ирэв, би хэмээн аргадаж гурван цэн алт өгсөнд тэр хоёр

– Чи сайн хүн ажгуу. Чамд энэ мэт элбэг алт олдох шалтгаан юу вэ хэмээсэнд, Миний эдгээр алт бол энэ эвхсэн цаасанд шүтэж олсон буй хэмээв.

– Тийн бөгөөс бид хоёрыг хөрвүүлтүгэй хэмээсэнд хөрвүүлбээс хоёр илжиг болов. Түүнийг хааныхаа дэргэд авч очоод чулуу хийгээд шороо зөөгчид өгч гурван үд болтол чулуу шороо зөөлгөсөнд нуруу нь дайртаж өөх цус хийгээд шар ус нь гоожив. Хааныг үзэх тутам нүднээсээ нулимс асгаруулсанд хаан түшмэлдээ өгүүлрүүн.

– Хилэнт энэ хоёр илжгэнд муу бүү үйлд хэмээсэнд, эвхсэн цаасны дээр хөрвүүлсэнд арайхан амьтай хоёр эмгэн болов хэмээсэнд, хааны хөвгүүн

– Ай хөөрхий хэмээсэнд заяа нь барагдсан хаан амнаасаа үг алдав. Сарвад үл сууна хэмээгээд нисэж одов.

ТУГАЛ ХАНШААРТЫН ГУТГААР БҮЛЭГ

- Тэндээс бас урьдчилан одож, модны оройд дөхөж өгүүлсэнд, шидэт хүүр бууж ирэв. Түүнийг уутандаа хийгээд дээсээрээ боож үүрч иртэл, үхдэл урьдах мэт өгүүлсэнд хаан тэргүүнээ дохив. Тэндээс хүүр бас өгүүллүүн:
- Эрт урьд нэгэн их урт голд ганц бие хүн ажгуу. Түүнд эд мал ганцхан үнээнээс өөр юмгүй. Үнээгээ үржүүлэхийн тулд, хамаг зүгт бух эрвээс эс олсонд маш зовж:
- Миний энэ үнээ хээлтэхгүй болбоос, тос хийгээд айраг үл гарахын тулд, би умдаасаж өлсөж үхнэ. Өдгөө өөр аргагүй буюу. Би өөрөө явсугай хэмээн сэтгээд, үнээндээ өөрөө тачаав. Тэндээс сар бүрдэж төрөх цаг болсонд үнээний дэргэд очиж, үүнээс ямар тугал төрөх бол хэмээн сахин атал, бие нь хүний бие, тэргүүн нь үхрийн тэргүүн дүрт, сүүл урт ийм нэгэн төрөв. Түүнийг эцэг нь үзээд атгаг төрж сумаар алахаар завдахад хөвгүүн нь:
- Эцэг минь намайг бүү ал, ач хариулсугай хэмээгээд, ой дотор орж одов. Тэнд хүрвэл модны оройд нэгэн хар өнгөт хүн суухыг үзээд, бяруун тэргүүт Масан түүнээс
- Чи хэн бэ хэмээсэнд
- Би ойгоос төрсөн Идэр буй. Масан хаана өөд болох вэ, нөхөр больё хэмээгээд үе хоёр нөхцөж явтал, нэгэн их зүлгэн дунд нэгэн хөх өнгөт хүн байхыг үзээд
- Чи хэн бэ хэмээн асуусанд,
- Би өлөнгөөс төрсөн хүн буй. Би нөхөр больё хэмээгээд гурвуул ханилж явтал нэгэн сал овоонд хүрэв. Тэнд цагаан өнгөт хүнийг үзээд:
- Чи хэн бэ хэмээн асуусанд
- Би салаас төрсөн буюу. Би нөхцөлдье хэмээн дөрвүүлээ нөхцөж одвоос, эзэнгүй нэгэн голд хүрэв. Тэндэхнээ юун бээр үгүй болоод, нэгэн уулын өнцөг үзүүр өчүүхэн байшин бүхийг үзээд тэнд хүрвээс, дотор нь идэх уух дотоод хэрэг яраг, тан чимгүүд хийгээд, хүрээнд нь хайнаг тэргүүтэн олон бүхүйг үзэж, түүнийг эзлэн сууж өдөр тутам нь гурав нь авлаар одож, нэг нь гэрээ сахина. Нэгэн өдөр ойгоос төрсөн Идэр гэр сахиж тараг бүрээд мах чанаж суутал, хаалга шахтгнуулж нэгэн амьтан шат давж ирэхэд
- Хэн бэ? хэмээн гарч үзвээс нэг төө биетэй эмгэн, илжигний хомоолын төдий үүрэг үүрч ирээд,
- Зэ, ийм нэгэн хөвгүүн мах чанаж сууна уу, тараг махныхаа амтыг үзүүл хэмээв. Өчүүхэн амсуулсанд, идээ нь үгүй болоод, эмгэн бууж одов. Тараг мах үгүй болсонд ичиж хамаг сангуудаа уудалсанд морины хоёр туруу олдов. Түүгээр гэрийн орчин гадуур бүхнийг гишгүүлээд өөрийн бүх сумыг гадуур харваж дуусгав. Сууваас тэндээс авчид ирээд:
- Тараг, бүлсэн тос хийгээд мах хаа буй хэмээвээс ойгоос төрсөн Идэр

– Энэ өдөр зуугаад морьтой хүн ирж байшинг эргэж, тараг, мах булаагаад, намайг хөдлөн ядтал занчив. Та нар гадуур орчин мөрийг үзэгтүн хэмээв. Тэндээс нөхөд нь үзэхээр одвоос морины мөр хийгээд гадуур орчин харвасан сумаар дүүрэн байхыг үзэж, «түүний үг үнэн буюу» хэмээлдэв. Түүний маргааш бас зүлэгнээс төрсөн Тарбу сууваас мөн эмгэн авирч урд өдрийн ёсоор болбоос үхрийн хоёр туруугаар байшингийн гадуур орчныг гишгүүлээд, бух хөлөгтөн ирж, нисэв хэмээв. Бас маргааш салаас төрсөн Тарбу сууваас урьдах мэт бултаж, луусын хоёр туруугаар байшингийн орчныг гишгүүлээд «Луусын хөлөгтөн ирж нисэв» хэмээн худал өгүүлэв. Түүний маргааш Тугал ханшаарт эврээ гозойлгон, сүүлээ годойлгож тараг бүлэн сууваас урьдах мэт эмгэн ирж,

– Ай энэ өдөр энэ мэт нэгэн хүн суун амой. Тараг хийгээд махны амтыг үзүүл хэмээв. Тугал ханшаарт

– Урьд гурвууланд энэ ирсэн ажгуу. Түүнд идээний амт үзүүлбээс юу ч болох мэдэшгүй хэмээн сэтгээд

– Эмгэн ээ, чи идээнээс амсахын урьд ус авч ир хэмээн суулганы ёроолыг цоочиж өгөөд илгээвээс, тийн хийсүгэй хэмээн ус авахаар одов. Байшингийн цонхоор хойноос нь харж үзвээс төө биет тэр эмгэн тэнгэрт хүрэм биет болоод усыг утгавал савны ёроолоос садран гарах тутам дахиж утгаж байхыг үзэв. Эмгэний үүргийг уудалвал нэгэн шөрмөсөн аргамж хийгээд төмөр алх, нэгэн өрөлбө буй ажгуу, Тэр түүнд нэгэн хэврэг олсон дээс хийгээд, нэгэн модон өрөлбө ба нэгэн модон алхаар бүгдийг солив. Тэндээс эмгэн ирээд

– Чиний суулганд ус үл тогтоно. Өдгөө чи идээний амтыг үл үзүүлэх бөгөөс эдгээр хамаг эд мал минийх бөлгөө. Хоёулаа наадан тэмцэлдье хэмээн эмгэн олсон дээсээр Тугал ханшаартыг хүлэв. Түүнийг хүчлэн татваас хэсэг хэсгээр тасрав. Жич тэр шөрмөсөн аргамжаар эмгэнийг хүлвээс хөдлөн эс чадав.

Эмгэн

– Чи дийлэв. Өдгөө маажилдья хэмээгээд түүний өвчүүнээс модон өрөлбөөр хавчиж татваас эс өвтгөв. Тэр бас эмгэний өвчүүнээс төмөр өрөлбөөр хавчуулан мушгин татваас данхны төдий мах тасарч ирсэнд зайлаад, хөвгүүн чи гартаа их хүчтэй буюу хэмээгээд, Өдгөө нэжгээд оролдъё хэмээж, хөвгүүний өвчүүг эмгэн модон алхаар дэлдвээс иш нь хугаран эс өвтгөв. Хөвгүүн төмөр алхаа галд улайтгаж эмгэний бие тэргүүнгүй дэлдвээс цус цувруулж шатыг харайгаад хөө татуулан зугтав.

– Тэндээс авчингууд нь ирээд «Масан амгалан уу» хэмээсэнд,

Муу гуйлгачид та нар худал хэлсэн байна. Эс арилжиж байна та нар. Тэр эмгэнийг би номготголоо. Одоо түүний хүүрийг үзье хэмээн цусны мөрөөр мөшгөн одвоос, нэгэн их айх мэт хадны ангархайн завсраар арван найман эр барны төдий доор эмгэний хүүр лүгээ алтан оюу хуяг тэргүүтэн сэтгэшгүй эд таваарыг үзэв. Масан:

– Түүнийг та гурвуул очиж дээш оосорлож өгтүгэй. Би татаж авсугай. Эс бөгөөс би өгөх үү, та нар таг хэмээсэнд гурвуул

Тэр эмгэн шулмас учир бид очиж үл чадна. Масан чи одтугай хэмээсэнд, Тугал ханшаарт шижмээр одож, тэдгээр эдийг дээш өгөв. Өгч дуусаад дараа нь тэд муу сэтгэлээр нийлж

– Масаныг татаж авбал эдийг Масанд алдана. Түүнийг бид гурвуул эзэлбээс сайн хэмээн Масаныг таталгүй нүхний ёроолд хоцроов.

Эд надад муу үйл үйлдэв. Өдгөө үхэхээс өөр юун. Үүний хөмрөг дотор идэх юм бий болов уу хэмээн сэтгэж эрвэл гуравхан гүйлс олоод, түүнийг хөрөнгөлж, өөрийн шээсээ цацаад, би үнэхээр Масан мөн бөгөөс сэрэх цагт гурван гүйлс болтугай. Бус бөгөөс үхэх болтугай хэмээн ерөөгөөд эмгэний хүүрийг дэрлэв. Хүүрийн түйтгэрээр олон онд унтжээ. Тэндээс сэрвэл гүйлсэн модон хадны амсар лугаа чацуу ургасныг үзээд баясаж авирч гараад урьдын тэрхүү байшинд хүрвэл юу ч үгүй болоод өөрийнх нь төмөр нум сум буй ажгуу. Түүнийгээ аваад одвол гурван нөхөд нь гурван байшин барьж гурван эм аваад сууж байв гэнэ. Гурван эмээс

– Эрчүүд чинь хаашаа одов хэмээн асууваас «авлаар одлоо» хэмээв. Тэндээс төмөр нумаа хөвчлөөд үзэхээр одвоос нэжгээд хэсэг мах авч иржээ. Масан төмөр нум сумаар харвабаас тэнд гурвуул цочоод

– Чинийх зөв буюу. Өдгөө гурван эм гэр чинийх болтугай. Бид гарч одъё хэмээсэнд Масан:

– Та гурав миний нөхөд мөн бөлгөө. Би эцэг юүгээн ачийг хариулахаар одох хэрэгтэй байна. Та гурав урьдынх мэт суугтун хэмээгээд одвоос, түүний маргааш нэгэн булгаас нэгэн гуа охин ус аваад одсоны мөрөөс цэцэг ургасан бүхийг үзээд гайхаж, түүний мөрөөр явсаар тэнгэрийн улсад хүрэв. Тэндээс Эрхэт хурмаст

Маш сайн, өдгөө завсардагч хар шулмас лугаа өдөр бүр тэмцэн бөлгөө бид. Маргааш түүнийг үзтүгэй, чи. Нөгөөдөр бидэнтэй нөхцөх хэрэгтэй хэмээв. Тэндээс маргааш өглөө цагаан бухт, хар бухтад үлдүүлж хөнөөв. Үдэш хар бухт, цагаан бухтыг хөнөөв. Түүний маргааш Эрхэт хурмаст:

– Цагаан бухт нь тэнгэр нар буюу, хар бухт нь Асури нар буюу. Энэ өдрийн үдэш хар бухт биднийг дээш үлдэж ирэх цагт чи төмөр сумаар тэлэн гүйцэж нэгэн их хар бухын магнайдаа гэрэлт бүхий, түүнийг харватугай хэмээн захирав. Тэр түүнчлэн харвабаас хар бухын магнайг нь оноод хамаг бух түрхрэн одов. Төдий хурмаст маш баясаж

– Чи их ачит буюу. Миний дэргэд суутугай хэмээвээс үл болон, «эцгийнхээ ачийг хариулахаар одох хэрэгтэй» хэмээн тэнгэр нарын чандманийг авч одохыг завдваас хурмаст

– Зуур мөрт унтаад мөр алдах больюу, эндэж шулмасын хаалганд хүрнэ. Дутаж үл болно. Түүний хаалгыг гөвшөөд «хэн бэ» хэмээвээс, би Оточ буюу хэмээтүгэй, Шулмасын шархадсан тэр хааныг үзүүлбээс сумыг сугалах дүр үзүүлээд энэ долоон арвайг дээш цацаад сумны тэргүүнийг дунд түлхэж залтугай хэмээн захирав. Тэндээс тэр Масан дээр өгүүлсний ёсоор хар мөр түүдгэрч, шулмасын үүдэнд хүрэв.

Хаалгуудыг гөвшөөс шулмасын хатагтай амандаа гал бадруулан ирээд

– Чи юу мэдэх вэ хэмээвээс

– Би отчилж мэднэ хэмээв. Гэрт оруулаад шархадсан шулмас хааныг үзүүлэв. Тэр түүний сумыг татваас амрав хэмээн өгүүлээд, сумыг тэргүүний дунд түлхээд арвай цацвал, тэнгэрийн төмөр чагтаг нь хангирстал бууж ирсэнд тэр түүнээс бариад нистэл шулмасын хатан галт төмөр бялуугаар нурууг дэлдсэнд хэмхэрч долоон бурхан болов хэмээсэнд өдий Амгалан явдалт хаан:

– Эцгийнхээ ачийг хариулав уу хэмээсэнд,

Хишгээ барсан хааны амнаас үг гарав. Сарвад үл сууна хэмээн дуулаад нисэж алдуулав.

ГАХАЙ ТЭРГҮҮТ ОТЧИЙН ДӨТГӨӨР БҮЛЭГ

Тэндээс бас урьдчилан одож шидэт хүүрийг аваад урьдах мэт үүрч ирвээс хүүр өгүүлрүүн:

– Бас чи нэгэн хууль өгүүл. Эс бөгөөс би өгүүлье. Чи өгүүлэх бөгөөс тэргүүнээ гэх. Намайг өгүүл гэвэл тэргүүнээ дохь хэмээсэнд хаан тэргүүнээ дохин үйлдээс, хүүр хууль өгүүлрүүн:

Тийн бөгөөс балар эрт нэгэн цагт нэгэн жаргалант улсын голын эхэнд нэгэн хүн гэргий хоёул буй ажгуу. Эр нь эд таваарт маш харам болоод, идээ ундааны төдийхнийг ч хайрлан үргэлж өдөр шөнө унтан байдаг тийм нэгэн байжээ. Хэзээ нэгэн цагт гэргий нь:

Энэ мэт бүү үйлд. Эцгийн чинь хураасан эд мал олонх нь барагдав. Орноосоо босоод намайг тарианы ажилд явсны хойно, дээр доор гарч харуулд хэмээсэнд тэр үгэнд орж нэгэн дээр гарваас, байшингийн нүүдэл нүүсний нутагт шувуу хийгээд үнэг юм булаалцалдахыг үзэж одвоос нэгэн олгойтой тос бүхийг авч ирээд хөмрөг дээр тавьсныг гэргий нь үзэж

Энэ тосыг хаанаас олов хэмээвээс чиний үгээр дээр гарсанд нүүдлийн нутгаас олов хэмээсэнд эм

– Эр хүн хэмээх ийм ажгуу. Нэгэн өдөр дээр гарснаар энэ мэт болох бөгөөс олон өдөр явбаас юу олохыг хэн мэдэх вэ хэмээсэнд түүнд омог төрж

– Эл бөгөөс би одсугай. Чи морь эмээл, хазаар малгай жанч, нохой сэлтийг бэлд хэмээвээс, гэргий нь бүгдийг бэлтгэж өгөв. «Одоо аль хэрэгтэйг бэлтгэв. Яв» хэмээсэнд тэр нэгэн цагаан малгай жанчийг өмсөж, саадгаа агсан, нохойгоо хөтлөн морио унаад хаашаа явахаа үл мэдэн бус нэгэн газар хүрэв. Нэгэн хоосон талд явгал нэгэн үнэг явахыг үзэж,

– Урьд учирсан нөхрийн дээд, үүгээр нэгэн малгай хийсүгэй хэмээгээд хөөвөөс нэгэн нүхэнд оржээ. Тэнд мориноос бууж саадаг жанч бүхий хувцсаа моринд ачаад, нохойгоо морины цулбуураас уяд өөрөө нүцгэлээд малгайгаар нүхийг бөглөж, нэгэн том чулууг барьж үнэгний байгаа нүхний дээр очиж тогшвоос, үнэг айж гарахад малгай нь үнэгний толгойд өмсөгдөж зугтаав. Түүний хойноос нохой хөөгөөд нохойг морины цулбуураас уясан тул морь нь дагаж даваа даван одов. Тэндээс тэр нүцгэн хоцорч аргаа баран тэр голын адагт одвоос, тэнд хүчин агуу төгссөн нэгэн хаан бөлгөө. Түүний морины хүрээнд хүрээд, өвсний хивэгний дунд хэвтэн хоёр чихнийхээ нэгийг гарган, бүх биеэ сүрлээр бүрхэн хүнд үзэгдэхгүй хэвтэж байтал, тэр хааны охин нь маш сэтгэлд зохист нэгэн бөлгөө. Тэр уйдсанаа сэргээхийн тулд тэнд ирээд, түүний дэргэд харуулж босоод одоход тэр хааны их улсын үнэт сүнсний оюу эрдэнэ тэнд унаваас охин түүнийг үл үзэн хотдоо харив. Тэрээр сүрлийн дундаас босохоос залхуурч, оюуг авч эс чадав. Тэндээс наран шингэхэд нэгэн үнээ ирж оюу эрдэнийн дээр баажээ. Хоромхон атал нэгэн шивэгчин үнээг авахаар ирээд, баас оюу лугаа сэлтийг хэрэмд шавж тавив. Түүний маргааш

– Хааны сүнсний оюу чандманийг охин гэж гэнэ хэмээлдэн, хаан нөхөд сэлтээр яаран үймэв. Төрийн их хэнгэргийг дэлдэж, албат бүгдийг хурааж төлгөчин, бэлгэчин, ёрчин бүгдийг сураглав. Тэр сүрлийн дундаас биеэ хагас гарган хүнд үзэгдэхүйц болоход нэгэн хүн ирж

- Чи юу мэдэх вэ гэхэд
- Би төлгөч хүн гэв.
- Тийм болбоос манай хааны сүнсний оюуг гэж, хамаг төлгөчнийг цуглуулан байна. Чи хааны дэргэд очтугай хэмээвээс
- Надад дээл үгүй хэмээсэнд тэр хүн хаанд очиж, манай гадна хүрээнд нүцгэн төлгөч байна. Дээлтэй болбол хааны дэргэд ирнэ хэмээн өчсөнд
- Тийм бол энэ нөмрөг дээлийг өмсгөөд авчир хэмээн зарлиг болсонд, түүнчлэн авч ирвээс, тэрээр хааны дэргэд ирж мөргөхөд, хаан
- Чамд төлгө үзэхэд юу хэрэгтэй вэ? хэмээн зарлиг болов.
- Төлгөнд гахайн толгой хэрэгтэй. Таван өнгийн хивлүгээ, нэгэн их дором хэрэгтэй хэмээв. Тэднийг өгвөөс модны үзүүрт гахайн толгойг хатгаад, хивүүдийг уяж дором хатгаад, гурван хоногт бясалгалд суух дүр үзүүлэн гаргагч өдөр хааны харьяат албат бүгдийг цуглуулаад тэр төлгөч нэгэн жанчийг өмсөөд, гахайн толгойг барьж нэгэн их замд одоод, хамаг улсыг нэгэн хавцгайд цувуулан гахайн толгойгоор хатгаад,
- Эдэнд үгүй хэмээсэнд, бүгдээр баясав. Тэндээс тэр
- Хааны сүнсний оюу хүнд үгүй буюу. Өдгөө газарт эрье хэмээгээд улам хааны хотын гадуур чулуун шатнаас аван, гахайн толгойгоор дохин дохин явахад хойноос хаан нөхдийн хамт хүрээлэн явгал, тэр төлгөч морины хүрээний хэрэмд оюу лугаа баас шавсан газар хүрээд, тэндээс гахайн толгойгоор оюут баасыг хатгаад
- Энд буй хэмээх төлгө тусав хэмээсэнд, хаан баасыг уудалваас сүнсний оюу эрдэнэ гарав. Тэндээс хамтаар баясаад
- Чи бол их төлгөч ажгуу. Өдгөө сайныг чинь ачилсугай гэрт ортугай. Энэ бол гахай тэргүүт төлгөч буюу хэмээлдэн баясалцав. Тэндээс хаан
- Чи юу хэрэглэх вэ хэмээвээс, гахай төлгөч эртний морь, хувцас тэргүүтнийг сэтгэлдээ хадсан тул
- Надад эмээлтэй морь, хазаартай саадаг, жанч малгайтай, нохой гинжтэй нэгэн үнэгтэй өг хэмээсэнд
- Энэ өчүүхэн дурт хүн буюу хэмээгээд, түшмэддээ үүний хүссэнийг өгтүгэй хэмээж бүгдийг өгөөд, түүнд мах тосоор хоёр зааны ачаа өгвөөс өөрийн нутагт харив. Тэнд түүний гэргий нь дарс авч угтаж ирээд
- Үнэн эр хүн гэгч ийм буй заа хэмээгээд гэртээ оров. Тэр шөнө хамт хэвтэж хэлэлцвээс, гэргий нь

– Энэ мэт мах тосыг хаанаас олов хэмээвээс, төлгөч шалтгааныг нарийн өгүүлсэнд

– Чи ухаангүй осолхон эр ажгуу. Өдгөө маргааш хаанд би очиж өчсүгэй хэмээгээд, бичиг үүсгэж хааны дэргэд очив. Тэнд хүрээд

– Хаан чамд урьд зэтгэр их байжээ. Өчүүхэн бол сүнсний оюу гэснийг олж өглөө. Одоогоор биеийн чинь гайг гаргуулахын тулд, нохой хийгээд үнэг тэргүүтнийг авсан буюу, би. Оюу олж өгсний харамж юу соёрхохыг хаан өөрөө мэд хэмээн худлаар засаж төлгөчийн бичиг болгон өгвөөс,

– Энэ үг үнэн буюу, түүнчлэн болгосугай хэмээгээд, сэтгэшгүй олон эд өгч илгээв. Тэндээс гахай төлгөч эр эм хоёул амгалан жарган суув.

Хэзээд хойно бас тэндээс хол бус нэгэн газар нэгэн хаан ах дүү долуулаа бөлгөө. Тэдгээр ах дүү нар уйдсанаа сэргээхийн тулд нэгэн ойд одвоос тэнд нэгэн үзэж ханашгүй гуа үзэсгэлэнт охин лугаа нэгнээ хайнаг шар хоёр бүхийгээс

– Та хоёр юу үйлднэв, хаанаас ирэв хэмээн асууваас, охин

– Би өмнө зүгийн нэгэн цогт хааны охин бөлгөө. Энэ хайнагийн хойноос явсаар энд хүрэв хэмээв. Тийн бид ах дүү нарт гэргийгүй бөлгөө. Бид лугаа гэргий нөхөр болох уу? хэмээвээс

– Больё хэмээгээд нөхөр гэргий боллоцов. Тэр юу хэмээжээс эр, эм хоёр рагша хүнийг алахаар ирсэн ажгуу. Эр рагша хайнагт хувилав. Эм рагша хатанд хувилаад, он бүр ах дүү зургуулыг нэжгээд нэжгээд идсээр ганц дүү нь үлдэв. Тэр ганц нь догшин өвчин хүртэж зовоод үхэхэд ойртоход түшмэд нь зөвлөлдөж

– Урьд ах нарыг нь отчилж, тус эс болоод халив. Үүнийг отчилж тус болох бэрх. Үүнээс хоёр давааны цаана гахай толгойт оточ хэмээх зүйрлэшгүй зөн билэгт тийм нэгэн бөлгөө. Түүнийг залъя хэмээлдээд илгээв. Дөрвөн морьтон хүн төлгөчийн дэргэд хүрээд шалтгааныг өчвөөс,

– Би өдгөө сэм сууж байна. Юу ч болов энэ шөнө бясалгалдаа бэлгэдэж маргааш хариу өгүүлсүгэй хэмээгээд, тэр шөнө гэргийдээ шалтгааныг өгүүлбээс, гэргий нь

– Урьд учралаар сайн болов. Өдгөө энд сууснаас дээр болох магадгүйн тул, одсон нь зөв хэмээвээс маргааш, тэд залагчид

– Энэ шөнийн бэлгэ сайн болов. Би одоо одсугай хэмээн нэгэн морь унаж жанч өмсөөд үсээ зайдаад зүүн гартаа нэгэн их эрих бариад, баруун гартаа гахайн тэргүүнийг таван өнгийн хив уясныг бариад одов. Тэндээс хааны хотод хүргүүлэхэд, эр эм рагша мэдээд «Үүний чимэг чамд бэрхийн тулд таних болов уу» хэмээн сэтгэн атал, төлгөч хааны дэрэн тус хүний чинээ дором босгож түүнд гахайн тэргүүнийг хатгаад тарни уншин атал, тэр хатан хааны амийг тасалтал заримлан тавиад сэтгэл эс амран, сэтгэлт болж гадна хаалганы нэгэн завсар бүхийд хааны өвчин маш ихээр өвдөн эвэрлэх нь амирлаж унтсанд гахай тэргүүт оточ айж

– Ай юун болов. Тугаар маш их өвдөн тэсэн ядан бөлгөө. өдгөө дуунгүй хальж амой хэмээн

сэтгээд

– Хаан, хаан хэмээн дуудваас дуун эс гарсанд доромоос гахайн тэргүүнээ сугалаад аван дугаав. Нэгэн үүдээр орвоос, сангийн гэр бүхий тулд

– Хулгай оров, дэлд хэмээсэнд бас зугтваас идээний гэрт орвоос

– Тэнд хулгай оров, барь, дэлд хэмээсэнд, бас зугтваас хөмрөг учирсанд

– Тэд, хулгай оров, барь, дэлд хэмээсэнд, Энэ шөнө эс бүтэв, хүрээний буланд нуусугай хэмээн сэтгэж хаалга нээвээс, наг хайнагийн шар хэвтэж байв. Харайж орхитол хайнаг дээр унаж, унасан мэт болбоос санамсаргүй гахайн тэргүүнээр хайнагийн эврийн хооронд гурвантаа дэлдвээс, хөө хий хуй болоод хатны буй хаалганы дотор оров. Тэр төлгөч үзэхээр одож чиглэвээс эр рагша өгүүлрүүн:

– Төлгөч намайг хүрээнд байгааг мэдэж байна. Тэр айх мэт бэрээгээр гурвантаа цохив. Одоо хэрхсүгэй би хэмээвээс, хатан нь

Би танихаас айж түүний өмнө одож эс чадав. Өдгөө сайн үл болно. Хаанд харьяат эрэгтэй иргэнийг мэссээ авчир. Хатагтай иргэн цөм түлээ авчир хэмээгээд, тэндээс хайнагийн шар хөтөлж ир хэмээгээд чамайг биеэ үзүүл хэмээвээс үл үзүүлэх аргагүй, үзүүлвээс сум ба жадаар нэрвээд тэр галын дотор түймэрдэнэ. Тэндээс намайг ба хатныг хөтөлж ир хэмээгээд, чамд хэр үйлдсэн түүнчлэн болно хэмээхийг төлгөч сонсоод «өдгөө хялбар буюу» хэмээн сэтгэж, хааны дэргэд одоод гахайн тэргүүнийг доромд хатгаад, бясалгалаа дуусгасны дүрээр, Хааны бие ямар хэмээвээс Төлгөч багшийн сайнаар өвчин амирлаж, өнө унтаж байна би хэмээв.

Тийн бөгөөс чи түшмэддээ зарлиг болж, маргааш өөрийн харьяат албатуудад эрэгтэй иргэн мэссээ авчир. Хатагтай иргэн цөм түлээ үүрч ир хэмээтүгэй гэв. Түүнчлэн ирвээс тэд модоор хоёр их хүрээ босгож, тэндээс төлгөч нь эмээлийг хайнагийн шаранд тох хэмээв. Түүнчлэн тохвоос, хайнагийг унаж гахайн тэргүүнийг далайж, хойшоо тойроод одоо эмээл ав хэмээн авахуулаад, гахайн тэргүүнээр хайнагийн тэргүүнийг цохиод,

– Биеэ үзүүл хэмээсэнд, тэр хайнагийн шар маш айх мэт рагша өвчүүний мах сарьсалсан, нүднээс цус цуварсан, дээд соёо нь хөхөндөө хүрээд, доод соёо нь хөмсгөнд хүрсэн тийм нэгэн болов. Түүнийг хутга хийгээд жад ба чулуугаар алаад, нэгэн галын хүрээний дотор түлэв.

– Өдгөө бас хатныг хөтөлж ир хэмээсэнд тэр хатныг олон хүн уйлуулан, хөтөлж ирвээс төлгөч багш гахайн тэргүүнээр дохиод

– Биеэ үзүүл хэмээсэнд тэр хатан маш аюулт болоод, хөлд хүрсэн хөхтэй, урт соёот болоод, улаан нүдэт тийм нэгэн болов. Түүнийг элдэв мэсээр алаад, нэгэн галын хүрээний дотор түлэв. Тэндээс гахай тэргүүт оточ морио унаж хааны хотод одох мөрт нь хүн бүгд мөргөх хийгээд хүндлэн биширч нулимс унагах ба арвай цацах хийгээд эд агуурс өгөх тэргүүтнээр замд эс багтаж нэгэн хоногт тэнд бүгд хонов. Тэндээс гэрт орвоос хаан маш баясаж,

- Харамж юу хэрэглэх вэ хэмээвээс
- Манай газар үхрийн дөр маш чухагийн тул хэдий чинээ олон өгнө үү хэмээсэнд хаан
- Түүнчлэн өгсүгэй хэмээгээд гурван уут дөр өг илгээв. Долоон зааны ачаа мах тос өгч илгээв. Улсдаа ойрхон хүрч ирвээс гэргий нь угтаж ирээд зааны ачааг үзээд
- Үнэн гайхамшигт хүн гэгч ийм буй заа. Эр болж хэмээгээд гэрт харив. Төдий тэр шөнө хоёулаа орондоо өгүүлэлдрүүн:
- Эдгээр мах тосыг юу шүтэж олов хэмээвээс, төлгөч нь хааны өвчнийг арилган эр эм хоёр рагша-г галд түлсэн тэргүүтнийг нэрлэн дэлгэрэнгүй өгүүлбээс
- Алиа чамд үүнээс юун болох тэр мэт гайхамшиг үйлдсэнээс адгуусны дөрөөр юун хэрэг. Маргааш би хааны дэргэд одсугай хэмээн одож «төлгөчийн бичиг буй» хэмээн худал зохиогоод
- Хаан чамд их ба өчүүхэн гай буйг мэдсэний ёсоор, тэрхүү гайн үлдсэнийг арилгахын тулд дөрийг авсан нь тэр бөлгөө. Өдгөө харамж хэр үйлдэхийг хаан мэд хэмээхийг бичиж бариваас
- Энэ үг маш үнэн буюу. Төлгөч гэргий хоёул нааш ир хэмээсэнд түүнчлэн төлгөч нөхөр сэлтээр хааны хотод одвоос, хаан
- Урьд бол баяр хурим буй, түүгээр тохсон бус буй. Миний бие эс үхэж хан орон үл бууран, харцас рагшад эс идэгдсэн нь чиний сайнаар болсон буюу. Өдгөө хан орныг хоёулаа ялгалгүй эзэлье. Энэ гэргий чинь ухаант бүхийн тулд нийт хатан болгоё хэмээн зарлиг болбоос түүнчлэн үйлдэв хэмээсэнд Амгалан явдалт хаан «Тэр эр эм хоёр бол их буянт ажгуу» хэмээн ам алдсанд
- Хишгээ барсан хааны амнаас үг алдав. Сарвад үл сууна хэмээн дуулаад нисэж алдуулав.

НАРНЫ ГЭРЭЛ АХ ДҮҮ ХОЁРЫН ТАВДУГААР БҮЛЭГ

Тэндээс бас урьдчилан сэрүүн үхээрт Шидэт хүүрийг авахаар одож хүрээд, бардам үг өгүүлсэнд, хүүр буусныг уутандаа хийгээд дээсээр боож, тосоо идэн үүрч ирэхдээ олон өдөр болсонд наран урт, бие ядрал.

– Бас чи мэргэн хууль өгүүл, эс бөгөөс би өгүүлье. Чи өгүүлэх бөгөөс тэргүүнээ гэх, намайг өгүүл гэвэл тэргүүнээ дохь хэмээсэнд хаан толгойгоо дохиход шидэт хүүр өгүүлрүүн:

– Тийн бөгөөс балар эрт нэгэн цагт, нэгэн маш жаргалант улсад Самандарасми нэрт хаан бөлгөө. Тэрбээр нэгэн хатан авснаас Нарны гэрэл нэрт хөвгүүн төрөөд хатан нь халив. Бас нэгэн хатан авбаас түүнээс Сарны гэрэлт нэрт хөвгүүн төрөв. Тэндээс хэзээд тэр хатан

– Энэ Нарны гэрэлт нэрт их хөвгүүн болбоос, миний өчүүхэн хөвгүүнд хан ор үл хүртээнэ. Өдгөө нэгэн аргаар Нарны гэрлийг алаад, би хөвгүүндээ хан орныг хүртүүлсүгэй хэмээн сэтгэж, нэгэн цагт худлаар бархирч хөрвөлөн тарчлав. Түүнийг хаан үзэж

– Сайн царайт минь чамд ямар өвчин болов хэмээн зарлиг болбоос

– Надад эцэг эхийн дэргэд бүхий цагаас ийм нэгэн өвчин бөлгөө. Өдгөө урьдаас үлэмж өвдөнө, Нэгэн арга буй бүтээхэд бэрх. Өдгөө үхэх болжээ хэмээсэнд хаан

– Чи үхвээс зүрх зогсох мэт тулд, хан орноо ч тэвчих бөгөөс хайрлах юм үгүйн аргыг өгүүлтүгэй хэмээвээс хатан

– Арга нь хоёр хөвгүүний алин ч болов нэгний зүрхийг гүнцэдийн тосонд чанаж идвээс эдгэх болно. Нарны гэрэлийг хаан тэвчихүйеэ бэрх. Сарны гэрэл миний биеэс төрсөн тул түүний зүрх миний аманд үл орох. Өдгөө үхэхээс өөр аргагүй хэмээн өчсөнд, хаан хатны үг өвчнийг дуусан ядаж:

– Маш хайрт болбоос, өдгөө үхэх чинь магад бөгөөс Нарны гэрэлийг яргачнаа өгтүгэй хэмээн ам алдав. Тэндээс

Сарны гэрэл тэдгээр үгсийг сонсоод ахынхаа дэргэд очоод уйлан.

– Ахай ижий хоёр энэ мэт зөвлөлдөнө. Нөгөө өдөр чамайг магад ална. Хэрхэх билээ хэмээн өгүүлсэнд ах нь

– Тэр мэт бөгөөс чи эцэг эхийгээ хүндлээд мэнд амгалан байтугай. Би буруулах цаг болжээ хэмээсэнд, Сарны гэрэл гашуудан

– Ах чамаас хагацан энд үл сууна. Чамайг хаана одвоос тэнд одно хэмээгээд түүнчлэн бололцов. Төдий маргааш алахын тэр шөнө хүнс эрвээс хатан мэднэ хэмээн айж, нэгэн тахилын орноо хүнээс доромын хатсан гурилыг нэгэн өчүүхэн туламд гуйж аваад, арван тавны шөнө саран ургахын үед ах дүү хоёр хотоос гараад өмнө зүг зугтав. Даваа хийгээд голыг огтолж өдөр шөнөгүй явбаас, нэгэн өдөр усгүй голд хүрч, тэнд доромын гурил нь

барагдан усгүйн тулд Сарны гэрэл хөсөрт унаж явж эс чадав. Ах нь өршөөж

– Ус эрэхээр одож ирсүгэй, хатуужиж бай хэмээгээд, нэгэн уулын өнцөгт ус эрж эс олоод, жич харьж ирвээс дүү нь умдаасаж үхсэн байв. Тэнд Нарны гэрэл гашууд дарагдаад дүүгийн хүүрийг чулуугаар хүрээлэн бариад нөгөө төрөлд хамт төрөх ерөөлийг ерөөж, тэндээс хоёр давааг давж одвоос, нэгэн хадны амсарт улаан хаалга байв. Түүний дотор орвоос нэгэн өвгөн арш бөлгөө.

– Хөөрхий хөвгүүн чи хаанаас ирэв, өршөөх мэт буюу хэмээвээс, тэр хөвгүүн шалтгааныг нарийн өгүүлсэнд

– Тийн бөгөөс миний хөвгүүн бол хэмээж болгоов.

– Эхлээд хоёулаа чиний дүүгийн ясны газарт очъё хэмээгээд ус хийгээд идээ ундааныг авч одов. Тэндээс Сарныгэрэл хөвгүүнд өчүүхэн идээ илдэж өгсөөр эдгээжээ. Тэндээс тэр гурвуул аршийн гэрт хүрч ирэв. Хэзээд тэр улсын адагт нэгэн их агуу хүчин төгсгөсөн хаан буй ажгуу. Түүний албатууд тарианд ус татах цагт тэр голын эхэнд их нуур бөлгөө. Тэр нуурт агч лусын хаадыг тахихын тулд, он бүр нэгэн барс жилт хөвгүүнийг өргөх бөлгөө. Нэгэн жилд тэр улсын барс жилт хөвгүүд барагдаж, хамаг зүгт эрвээс эс олов. Мал адуулагч бус нэгэн хөвгүүн

– Энэ голын эхэнд нэгэн өвгөн аршид нэгэн барс жилт хөвгүүн бөлгөө. Бид адгуус адуулахаар очиж үзлээ хэмээвээс, хаан сонсоод

– Түүнийг авч ир хэмээн гурван хүнийг илгээв. Тэд аршийн хаалгыг цохивоос арш гарч ирээд

– Юу вэ хэмээвээс

– Хааны зарлиг, чамд нэгэн барс жилт хөвгүүн буй ажгуу. Түүнийг чинь хан орны тулд хэрэг бүхийн тул над өгч илгээ хэмээн зарлиг болов хэмээвээс арш

– Юу өгүүлнэ, надад хөвгүүн үгүй хэмээгээд гэртээ ороод хаалгаа хааж хөвгүүнээ бутанд хийгээд, амсрыг нь шавраар шавж, тутарганы архи хийсэн бутан мэт атал, хааны зарц тэр хүн

– Хаалга эвдээд, гэрийг нэгжъе хэмээгээд гэрт оров. Нэгжиж эс олоод өвгөн чамд хөвгүүн үгүй бөгөөс, биднийг юунд зовоов, хэмээгээд аршийг шийдмээр цохив. Тэнд Нарны гэрэл эс тэсээд,

– Ахайг бүү цохь, би энд байна хэмээн гарч ирвээс түүнийг тэр хүн бариад хөтөлж одов. Арш гашууд дарагдан ихэд уйлав. Тэд хөвгүүнийг хааны хотод авч одвоос хааны охин үзэж, тэр хөвгүүнд тачааж хагацан ядаж хүзүүнээс тэврэн үйлдэв. Албатууд бүгд

– Барс жилт хөвгүүнийг өргөх цаг болжээ, энэ өдөр хэмээн өчив

Хаан

– Тийм болтугай хэмээсэнд тэдгээр албат хөтлөн завдвас тэр охин

– Үүнийг уснаа үл орхи. Үл болох бөгөөс намайг орхитугай хэмээвээс, түүнийг хаан сонсож, охиноо

– Хан орныг үл сэтгэнэ энэ хэмээн, барс жилт хөвгүүн лүгээ хамт ширлэж усанд хая хэмээсэнд тэр хаан ганц зарлигтай бүхийн тулд, албат бүгд зарлигийн ёсоор болгосугай хэмээгээд, хамт хүлээд ширлэж, лусын хаадыг тахихын тулд усанд хаяв. Тэнд Нарны гэрэл сэтгэлдээ

– Аяа, хохой би барс жилтэй учраас уснаа хаягдваас хаягд, надад тачаасан энэ хааны охин, миний мөрт үхэх боллоо хэмээн сэтгэж байв. Охины сэтгэлд

– Би доорд төрөлт бүхийн тулд хан эцэг минь энэ мэт үйлдвээс болно гэж үү. Сэтгэлд зохист энэ хөвгүүнийг юунд хаяна хэмээн сэтгэж нааш цааш өршөөлцөн бүхийг тэр лусын хаад мэдэж, нуурын хязгаарт гаргаж тавив. Тэнд хоёулаа усны аюулаас зайлаад нутагтаа очиж

– Охин чи одоо хотдоо харигтун. Би эцэг аршаа үзэхээр явъя. Эцэгтэйгээ уулзсаны хойно эргэж ирээд хоёул энэ насандаа хагацалгүй, нөхцсүгэй хэмээн ам алдсанд, түүнчлэн

– хааны охин хотдоо харив. Нарны гэрэл арш бүхий оронд хүрээд хаалга цохивоос арайхан дуугаар

– Хэн бэ? хэмээн асууваас

– Би хөвгүүн чинь буюу хэмээвээс, арш

– Надад хөвгүүн үгүй, ганц хөвгүүнийг минь хаан булааж аллаа. Одоо би түүний хойноос гашууд дарагдан сууна хэмээсэнд

– Би хөвгүүн чинь магад мөн. Хаан усанд хаясанд лусын хаад эс идэж, харин гаргав. Эцэг минь бүү гашууд, хаалгаа нээ хэмээсэнд

– Тийм бөгөөс юу хэлэх вэ гээд хаалга нээвээс тэр арш нь маш тураад сахал үс нь буурал болоод үхэх мэт болсонд төдий Нарныгэрэл сүү хийгээд ус хольж аршийн биеийг угаагаад, зохист үгсээр гашуудлыг амирлуулан үйлдэв. Тэр охин хааны хотод хүрвээс хаан хамаг харцас лугаа нөхөд сэлтээр гайхаж,

– Аяа, лусын шулмас нь тэр нуурт хаягдсан хүнийг гаргахын үлгэр үгүй бөлгөө. Энэ охины гарч ирсэн нь гайхамшиг хэмээлдээд, хамгаар тойрон мөргөх хийгээд, наманчлах тэргүүтэн сэтгэшгүй үйлдээд, хаан

– Хөөрхий энэ охин эс үхэж ирсэн сайн, барс жилт тэр хөвгүүн үхэв үү хэмээн зарлиг болсонд,

– Тэр хөвгүүн эс үхээд түүний нигүүлсэхүйн хүчээр шүтэж би эс үхэн, тэр лусын хаадыг номготгосноос хойшид барс жилтнээр тахихын хэрэггүй болоод, ус нь насад урсана хэмээн өчсөнд, хаан

– Тэр мэт их гайхамшиг буюу хэмээн өдгөө тэр хөвгүүнийг хаа байгаа газраас залагтун хэмээн түшмэддээ зарлиг болов. Түшмэд тэр голын эхэнд хөвгүүнийг залахаар илгээвээс заларч, арш эцэг хөвгүүн дүү гурвуул хотын ойр хүрвээс хаан, «тэр их ачит хөвгүүн буюу» хэмээн агуу ихэд угтав. Тэндээс хотод хүрээд, эрдэнийн тавцанд суулгав. Хаан

– Хөвгүүн чи гайхамшигт буюу. Энэ аршийнх буюу хэмээн асууваас

Би энэ мэт нэгэн хааны хөвгүүн бөлгөө. Хойд эх учралдсанаар алах болоход зугтааж, аршийн дэргэд хүрсэн бөлгөө. Энэ хөвгүүн бол миний дүү хэмээх тэргүүтнийг дэлгэрэнгүй өчсөнд, төдий хаан маш ихэд гайхаж

– Тэр мэт бөгөөс би энэ охиноо та ах дүү хоёрт хатан болгон өгөөд олон эд таваарыг өгсүгэй. Өөрийн орондоо одвоос сайн. Хүргэх хүн илгээе хэмээв. Тэндээс хоёр хөвгүүн хатантайгаа сэтгэшгүй эдийг авч дөрвөн аймаг үдэгч цэргүүд лүгээ сэлтээр улсдаа харив. Хотын ойр хүрээд элчээр эцэгтээ

– Бид ах дүү хоёр хүрч айсуй хэмээн бичиг өгвөөс эцэг эх хоёр хөвгүүнээ буруутгасны гашууд дарагдаж хүнтэй үл золгон сууж атал, тэр бичгийг үзээд, сэтгэл нь маш баясаж, агуу их угтуулаар угтав. Ах дүү хоёул сэтгэшгүй агуу хүчин лүгээ сэлт хотод ирсэнд эртний тэр хорт хатан хөвгүүнээ ах дүү нарыг үзээд гайхаж цусаар бөөлжиж үхэв хэмээсэнд, Амгалан явдалт хаан «Зөв ч биз» хэмээсэнд

Хишгээ барсан хааны амнаас үг гарав. Сарвад үл сууна хэмээн дуулан нисээд алдуулав.

ХУВИЛГААНТ НЭРТ ХҮН ХААНЫГ НОМГОТГОСОН ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Тэндээс бас сэрүүн үхээрт шидэт хүүрийг авахаар хүрээд бардам үгээ өгүүлсэнд хүүр бууваас, уугандаа хийгээд дээсээр эрчлэн тосоо идэж нуруундаа үүрч иртэл олон өдөр болов.

Нар ч урт, бие ч алжаав. Бас чи нэгэн мэргэн хууль өгүүл, эс бөгөөс би өгүүлье хэмээсэнд хаан юухан бээр эс өгүүлвээс

– Чи өгүүлэх бөгөөс тэргүүнээ гэх, намайг өгүүл гэвэл тэргүүнээ дохь хэмээвээс, хаан тэргүүнээ дохисонд шидэт хүүр хууль өгүүлрүүн.

– Тийм бөгөөс балар эрт нэгэн цагт, тутаргат орон хэмээгдэх нэгэн улс бөлгөө. Тэнд нэгэн зусар дээрэнгүй хүн ажгуу. Тэр хэнийг ч үл тоон зусар аальтай тул, тэр улсын хаан хилэгнэж,

– Чи маш ширүүн тул энд сууж болохгүй, бус газар од хэмээн хөөв. Тэр тэнд үл тэсэн одвоос наран үдшийн цагт нэгэн хоосон талд цайрч бүхий нэгэн дэрсэнд хүрэв. Тэр талын дунд нэгэн маш өндөр дал модон буй ажээ. Түүний ойр нэгэн үхсэн морь байжээ. Тэр «толгойгоор нь хүнс хийсүгэй» хэмээн сэтгэж, бүсэндээ хавчуулаад дал модонд авирав. Бүрий барай болоход тэр дал модны хормойгоос үйсэн морь унаад үйсэн малгай өмссөн чөтгөрүүд ирээд дал модны ёроолд хурав. Бас дал модны эхээс цаасан морь унасан цаасан малгай өмссөн хөлчид ирээд тэнд хурав. Тэдгээр хөлчид модны ёроолд элдэв идээ ундааныг найруулах ажээ. Дал модны үзүүр дэх тэр хүн айж чичрэхэд бүсэнд хавчуулсан морины толгой шувтарч, чөтгөрүүдийн идээний дунд унахад бүх чөтгөрүүд цочоод зүг бүр тархав. Тэр хүн маргааш эрт дал модноос буугаад,

– Энэ шөнө тийм олон эд таваарт бөлгөө. Өдгөө юу болов хэмээн үзвээс тэр хүн нэгэн алтан аяга дүүрэн архийг олоод умдаассаны тулд ууж аягыг түрүүлгэнэ хөмөрч тавив. Хоёр хэсэг мах, гурил бий болов.

– Энэ алтан аяга бол юу хүсвээс болох хуурцаг буюу. Надад нэгэн шидэт буюу хэмээн сэтгэж аван одвоос, тэр хүнийг одох мөрт нэгэн шийдэм барьсан хүн учирсанд түүнээс

– Чиний энэ юу вэ хэмээн асууваас

– Миний шийдмийн нэр эргэж гүйгч хэмээнэ. Эргэж гүйгч одоод цаана тэр миний эдийг авлаа. Түүнийг авч ир хэмээснээр хүрээд хүний хүзүүг ороож алаад эдийг авч ирэгч буюу хэмээсэнд

– Тийм бол миний энэ алтан аяга юу хүсвээс болох хуурцаг бөлгөө. Үүн лүгээ арилжих уу хэмээвээс арилжсугай хэмээгээд арилжив. Эргэж гүйгчийг аваад эргэн гүйгч шийдэм чи одож хүнийг алаад алтан аяга авч иртүгэй хэмээмэгц шийдэм огторгуйгаар одоод тэр хүнийг алаад алтан аяга авч ирэв. Бас цааш явбаас замд нэгэн төмөр алх барьсан хүн учрав.

– Чиний энэ төмөр алхаар юу хийх вэ хэмээвээс

– Миний энэ төмөр алх есөнтөө газарт дэлдвээс есөн давхар төмөр балгас болно хэмээв.

- Тийм бөгөөс миний алтан аягаар арилжих уу хэмээвэл арилжъя гээд арилжив. Бас
- Эргэж гүйгч шийдэм алтан аяга авч ир хэмээсэнд одож тэр хүнийг алаад алтан аяга авч ирэв. Бас цааш явбаас замд нэгэн ямааны арьс барьсан хүн учрав.
- Энэ юун болох хэмээвээс
- Энэ миний гайхамшиг буй. Гөвшсөний төдийхнөөр хур ороод ихэд гөвшвөөс их хур орно хэмээв.
- Тийм бөгөөс миний энэ алтан аягаар арилжих уу хэмээвээс арилжъя хэмээв. Тэндээс эргэж гүйгч шийдэм алтан аяга авч ир хэмээсэнд одоод тэр хүнийг алж алтан аягыг авч ирэв. Тэндээс тэдгээр эд бүхийг авч манай тэр улсын хаан намайг хөөсөн бөлгөө. Өдгөө өшилсүгэй хэмээн сэтгэж, тэнд одоод хааны хотын хойно очоод шөнө дөл төмөр алхаар газар есөнтөө дэлдсэнд есөн давхар төмөр балгас болов. Маргааш нь хаан Энэ шөнө хотын хойно олонтаа тас тас дуун гарав. Хатан чи үз хэмээсэнд хатан үзээд
- Хотын хойно есөн давхар төмөр балгас байна хэмээн өчвөөс хаан хилэгнэж,
- Түүнд ёсгүй тэр муу хүн үйлдэв. Өдгөө тэнцүүгээн мэдэлцье. Надад харьяат албат бүгдээр нүүрсээр төмөр балгасыг төдий овоолж дархад бүгд тал талаас хөөрөгд хэмээв. Түүнчлэн гал нь ихэд шатаад, тэр төмөр байшингийн дотор хувилгаант хэмээх тэр хүн эх хоёулаа бүгд хэрэгтэй идээ умдаан алтан аяганаас болохын тулд, удаан жаргаж суун атал эх нь найман давхарт агаад хөвгүүн нь есөн давхарт атал, эхийн хавирга нь халахад
- Хувилгаант аа, төмөр балгасанд хааны галын аюул болов. Өдгөө бид эх хөвгүүн магад үхэх болно хэмээвээс, хувилгаант сонсож,
- Ээж минь сэтгэлээ бүү зовоо. Энэ мэт арга буй надад гээд төмөр балгасны үзүүрт очиж эртний ямааны арьсыг гөвшсөнд хур сүржигнэн ороод гал ихэнх нь унтрав. Тэндээс тэр сайтар гөвшсөнд маш их хурж орж, үер болж төмөр балгасыг хучсан нүүрс хийгээд хөөрөг цөм урсаж нэгэн их хавцгай голд одов хэмээвээс, Амгалан явдалт хаан
- Тэр улсад тэр хүн нэн ажгуу хэмээн үг алдсанд
- Хишгээ барсан хааны амнаас үг гарав. Сарвад үл сууна хэмээн дуулаад алдуулав.

ШУВУУН ГЭРТИЙН ДОЛДУГААР БҮЛЭГ

Тэндээс бас сэрүүн үхээрт шидэт хүүрийг авахаар хүрч бардам өгүүлсэнд, хүүр бууваас уутанд хийгээд дээсээр эрчлэн тосоо идэн нуруундаа үүрч ирж явтал

– Өдөр олон болов. Нар ч урт, бие ч алжаав. Бас чи мэргэн хууль өгүүл, эс бөгөөс би өгүүлье хэмээсэнд хаан дуу эс гарсанд

– Бас чи өгүүлэх бөгөөс тэргүүнээ гэх. Намайг өгүүл гэвэл тэргүүнээ дохь хэмээсэнд хаан тэргүүнээ дохисонд, бас хууль өгүүлрүүн:

– Тийм бөгөөс, балар эрт нэгэн цагт Жаргалант ой нэрт газар нэгэн улсын нэгэн гэрийн эзэнд эгч дүү гурван охин бөлгөө. Өдөр бүр ээлжээр үхэр хариулахаар явдаг байжээ.

Нэгэн өдөр эгч нь хариулж яваад нойр нь хүрч унтаад нэгэн үхэр завхасныг эрж одвоос, нэгэн хүрээний завсарт нэгэн хаалга улайж бүхийг нээж үзвээс, нэгэн алтан хаалга буюу. Түүнийг нээж орвоос лавай хаалга байв. Түүнийг нээж орвол маш жаргалант болоод, алт, оюу тэргүүтэн эдээр дүүрсэн гайхах мэт тийм нэгэн байшин буй. Түүнд дутуу юм үгүй болоод нэгэн их цагаан шувуу эрдэнийн торонд суух ажээ. Түүнд тэр охин

– Миний нэгэн үхэр завхаж эс оллоо. Энд ирэв үү хэмээн асууваас шувуу:

– Чи миний гэргий болох бөгөөс заасугай. Эс болох бөгөөс үгүй хэмээсэнд,

Ер ертөнцийн үйл үл болох, ялангуяа шувуу хэмээх адгуусан буй. Маргааш эс олвоос чиний гэргий болохгүй хэмээн харив. Маргааш нь дунд охин эрж одвоос урьдах мэт бултаж бас гэргий эс болов. Түүний маргааш бага охин эрж одсонд урьд мэт учраад шувуу

Миний гэргий болох бөгөөс зааж өгнө хэмээв.

Ер эр хүний үг зөв болно. Ялангуяа шувуу чиний өгүүлснээр болсугай хэмээгээд түүний гэргий нь болов. Хойно тэр улсын нэгэн бухар хийдийн шүтээнийг үзэхээр олон иргэн арван гурван өдөр болтол хүрээлэн чуулав. Тэр охин тэднийг үзэхээр одов. Тэнд хүрвээс тоолшгүй олон иргэн хурж байв. Хатагтай иргэнд тэр охин өөрөө шалгарч, эрэгтэй иргэнд хөх морьтой маш гуа үзэсгэлэнт хүнийг хурагсдыг гурвантаа тойроод одвоос, хотлоорт «тэр шалгарав» хэмээлдэв. Тэндээс охин харьж ирвээс шувуу

– Энэ өдөр хурагсдад эрэгтэй ба хатагтай дотор хэн шалгарав хэмээн асууваас охин

– Эрэгтэйд нэгэн хөх морьтой хүн, хэн болохыг эс танилаа, тэр шалгарав. Хатагтайн дотор би өөрөө шалгарсан буй хэмээв. Тэндээс арван нэгэн өдөр болтол түүнчлэвээс арван хоёр өдөрт тэр охин хурагсдыг тойроод ирж айлын нэгэн эмгэний дэргэд суун атал, эмгэн

Энэ өдөр хурагсдад хэн шалгарав хэмээн асууваас, охин

– Эр хүнд нэгэн хөх морьтой маш гуа үзэсгэлэнт тэр шалгарав. Хатагтайд би өөрөө мэт буй.

Аяа хохой энэ өдрийн тэр хүн мэт эртэй болбоос энэ заяанд өөр юу ч хэрэггүй бөлгөө.
Миний нөхөр адгуусан төрөлт шувуу заяав хэмээн уйлсанд эмгэн

– Аяа, охин чи тийн бүү өгүүл. Хатагтайн дотроос чи өөрөө шалгарсан нь үнэн буй. Тэр хөх морьт хүн чиний нөхөр мөн буюу. Өдгөө мөн бүхий тулд чи одоо өөрөө үл одон бөгөөтөл одохыг дүрлэн гаднаа нуугдагтун, Шувуу гэрээ (багаа) тайлаад хүрээнээс хөх морио гаргаж унаад одьюу. Түүний хойно чи тайлж тавьсан шувууны гэрийг галд түлэгтүн. Тэндээс түүний ариун гуа бие лүгээ нөхцөж болох хэмээн сургав. Тэндээс охин сургасанчлан үйлдвээс нөхөр нь хөх морио унаж хуралд одов. Хатагтай шувууны гэрийг галд түлээд, түүнийг танихын тулд хаалганд хүлээв. Наран шингэх цагт нөхөр нь ирж

– Юу болов? Чи урьд хүрэв үү хэмээвээс гэргий нь

– Би урьд ирлээ хэмээв. Тэнд тэр

– Миний шувуун гэр хаана байна хэмээвээс галд түллээ хэмээсэнд

– Хөөрхий гэмгүй үйл үйлджээ чи. Тэр миний сүнс бөлгөө.

– Одоо хэрхсүгэй хэмээсэнд

– Өөр аргагүй. Өдгөө чи үүдэнд суугаад энэ шийдмээр үргэлж түйтүгэй. Нэгэн агшинд үл алсан, гэрээр алсан, түйтэхээ тасалдваас, намайг хөлчин авна. Би өөрөө долоо хонотол тэнгэр чөтгөрүүд лүгээ тэмцсүгэй хэмээв. Тэндээс тэр охин шийдэм бариад нүдэндээ дэрсээр тулхлан шийдмээр зургаа хонотол түйтвээс тэндээс өчүүхэн унтсанд Чингис гэж тэнгэр чөтгөрүүд шувуун гэрт хэмээх эр нөхрийг нь аваад одвоос тэндээс тэр охин маш гашуут болоод, хамаг голыг үлдээлгүйгээр амар ухамсаргүй эрэн одож,

– Аяа, шувуун гэрт, шувуун гэрт хэмээн энэлэх дуугаар дуудав. Тэндээс өдөр шөнөгүй эрвээс эс олоод, хэзээд нэгэн цагт шувуун гэргийн дуун өндөр уулын оройд сонсдов. Тэнд одвоос доор голын адагт сонсдоно. Охин тэнд хүрвээс нэгэн, мануулын дэргэд шувуун гэрт нэгэн үүрэг гутал үүрч охин лугаа учраад

– Чамтай учирснаар сэтгэл баясав. Би тэнгэр чөтгөрүүдийн ус авагч болсны тулд эдгээр гутлыг элтэл зөөнө хэмээгээд Чи өдгөө гэртээ одож нэгэн шувуун гэрийг үүдэж, түүнд сүнсийг далла. Тийн үйлдвээс би тэнд ирж болох магадгүй хэмээв. Тэнд даруй дээр тэнгэр чөтгөрүүд нэгэн хий хуй болон аван одов. Тэндээс тэр охин гэртээ хүрч нэгэн шувуун гэрийг шинээр үүдээд, сүнсийг далласанд шувуун гэрт шатны дээр гарч ирэв хэмээсэнд, Амгалан явдалт хаан нь

– Тэр эм маш баясав уу хэмээн өгүүлсэнд

– Хишгээ барсан хааны амнаас үг гарав. Сарвад үл сууна хэмээн дуулаад нисэж алдуулав.

АНАНД ЗУРААЧ ХИЙГЭЭД АНАНД МОДОЧ ХОЁРЫН НАЙМДУГААР БҮЛЭГ

Тэндээс бас урьдчилан шидэт хүүрийг авахаар хүрээд бардам үгээ өгүүлвээс хүүр нь буусанд, уугандаа хийгээд дээсээр эрчлэн үүрч иртэл:

- Наран урт, бие ч алжаав. Бас чи нэгэн мэргэн хууль өгүүл. Эс бөгөөс би өгүүлсүгэй. Чи өгүүлэх бөгөөс тэргүүнээ гэх. Намайг өгүүл гэвэл дохь хэмээсэнд хаан тэргүүнээ дохисонд тэрбээр хууль өгүүллүүн:
- Тийн бөгөөс балар эртний нэгэн цагт Хотлоор хүсэгч нэрт улсад Хамгийг гийгүүлэгч нэрт хаан бөлгөө. Түүнийг нөгчсөний хойно, хөвгүүн нь Хамгийг мандуулагч хэмээх тэр хан орныг сахин бөлгөө. Түүний албатуудад Ананд нэрт зураач хийгээд, Ананд нэрт модоч хоёр бөлгөө. Тэр хоёр маш атаархах сэтгэлт буюу. Муу сэтгэлээг нэгэн цагт зураач хааны дэргэд одож
- Би өдгөө үдэш маргааш хан эцэг чинь тэнгэр нарт төрж амой. Түүний дэргэд ир хэмээсэнд зарилгаар одлоо. Сэтгэшгүй агуу хүчит хөвгүүн чамд эцгийн чинь өгсөн бичиг энэ буй хэмээн нэгэн бичгийг өгөв. Түүний дотор «Өөрийн хөвгүүн Хотлыг мандуулагчид өгүүлэх нь: «Би тэндээс насаа егүүтгэж тэнгэр нарт төрөв. Өдгөө эд агуурс дуусаж амой. Энд нэгэн бухар хийд барих хэрэгтэй тул, модоч эс олсноор миний Ананд модчийг энд илгээтүгэй. Дээш илгээх аргыг зураач мэднэ хэмээх худал бичгийг хан хөвгүүнд өргөвөөс, хан хөвгүүн түүнийг үзээд
- Миний эцэг тийм бөгөөс маш сайн буюу. Модчийг авч ир хэмээсэнд модоч ирвээс хаан
- Хан эцэг минь тэнгэрийн газар буй ажгуу. Чамайг бухар хийдийн модны тулд илгээ хэмээсэн ийм бичиг амой хэмээн бичгийг үзүүлсэнд тэр үзээд,
- Энэ мэт ёсгүй буюу. Энэ хэмээвээс ямагт Ананд зураачийн муу арга буюу. Өдгөө нэгэн арга хэрэгтэй хэмээн сэтгээд хан хөвгүүнд
- Тийн хийсүгэй, тэнгэрийн оронд ямраар одох ёстой вэ хэмээн өчвөөс
- Түүнийг нь Ананд зураачаас асууна хэмээж ирүүлээд асууваас
- Эргүүл, хэмжээ, бэлгээ аваад, модонд махчны тос сүрчээд хүрээлж, түүннй дунд суун, элдэв хөг дуун алдаршуулан галыг шатааж, унааны морь унаж ир хэмээлээ. Ананд модоч тийн хийсүгэй хэмээгээд одохдоо
- Миний байшингийн дэргэд нэгэн тариа буй, түүний дундаас одъё хэмээсэнд зөв хэмээлдэв. Тэндээс долоо хоногийн дараа одъё хэмээх ам аваад модоч гэртээ харив. Хариад гэргийдээ
- Ананд зураач урнаар энэ мэт сэдэж амой. Өдгөө би долоо хоногоос одно хэмээн ам алдав. Нэг арга сэдье хэмээгээд байшингийн ёроолоос нүх ухаж тарианы дунд ноолж, түүнийг чулуугаар бөглөж шороогоор бүрхэн тавив. Долоо хоноод хаан

– Энэ өдөр Ананд модоч эцэг хааны дэргэд одох бөлгөө. Албатууд бүгд нэжгээд үүрэг түлээ, нэжгээд шим тос авч ир хэмээн зарлиг болоод, тэднийг ирсний хойно модоор модчийн тарианы дунд нэгэн хүрээ барив. Түүний дунд модчийг бэлэг лүгээ сэлтийг тавьж хязгаараас нь галыг шатаан хөг дууг дуурсгасанд, гал нь ихэд шатаад ониор нисэж гарсанд, Ананд модоч бэлгүүдээ аваад эртний ухсан нүхээр орж өөрийн байшиндаа оров. Ананд зураач «тэр онины дотор оров» хэмээн хуруугаа огторгуйд сунгав. Тэндээс хурагсад тархаж хамгаар

– Энэ өдөр мужаан нөгчөөд хааны дэргэд тэнгэр нарын улсад одов хэмээлдэв. Тэндээс модоч нэгэн сар сэм сууж, хэнд ч үл үзэгдэн өдөр бүр сүүгээр угааж, сүүдэр бариад суув. Суугаад нэгэн цагаан хив дээлийг өмсөж, бас худал бичгийг үүдэн Хотлыг мандуулагч хөвгүүнд өгөв.

Мэнд амгалан болоод, хан орныг номын ёсоор мандуулан бүхий чинь сайн. Энд бухар хийд үүдэхийн тул Ананд модоч чи үйлс сайтар бүтээж дуусав. Тэнд бас үүнийг баясган ихэд хүндлэгдэх. Өдгөө энэ бухар хийдэд зураг хэрэгтэй тул, тэндээс Ананд зураачийг үтэр илгээх хэрэгтэй буй. Дээш илгээхийн ёсон эртний ёсоор болох болно» хэмээх бичгийг аваад хааны дэргэд хүрвээс, хаан түүнийг үзээд

– Аяа, энэ тэнгэрийн орноос эргэж ирсэн ажгуу. Хан эцэг амгалан буй юу хэмээвээс тэр худал бичгийг бариад

«тэнгэрийн оронд хүрэв» хэмээн нарийн дэлгэрүүлэн өчсөнд хаан «маш үнэн ажгуу» хэмээгээд баясан өглөг сайтар өгөв. Тэндээс

– Өдгөө тэр бухар хийдэд зураг хэрэгтэй буй ажгуу. Ананд зураач ир хэмээн зарлиг болсонд зураач ирээд Ананд модчийн бие нь цагаан болоод цагаан дээл емсөн элдэв эрдэнэсийг зүүснийг үзээд

– Яагаад энэ эс үхэж эргэж ирэв хэмээн бодов, Түүнд хаан эцгийн бичгийг үзүүлж, одох хэргийн тул, шалтгааныг зарлиг болсонд, зураач

– Өдгөө магад онийг морь унаж одвоос хүрэх ажгуу. Энэ мужааныг би өөрөө нүдээрээ үзэж, гараараа барьж түллээ. Өдгөө үл болох аргагүй. Урьд үлгэр хойтод зам бүхийн тулд хэмээн сэтгээд,

– Долоо хоногт одъё хэмээн ам авав. Одохын ёсыг асууваас «урьд ёсоор буй» хэмээв. Долоо хоносны хойно тэр өдөр хамаг хүн мод хийгээд тосыг авч ирээд, нэгэн тарианы дунд ихэд хүрээлэв. Түүний дунд Ананд зураачийн бэлэг хийгээд, хаанд мөргөхийн бэлэг, хан хөвгүүн эцэгтээ өргөх бичиг тэргүүтнийг тавиад зүг бүрээс галыг шатаан хөг дуун дуурсгасанд Ананд энэрэхүй дуун гаргаад нааш дүүлвээс хөг дуугаар үл сонсгуулан түлэв хэмээвээс Амгалан явдалт хаан нь

– Агаархсан өшөөг даруйд авчээ хэмээсэнд

– Хишгээ барсан хааны амнаас уг гарав. Сарвад үл сууна хэмээн дуулаад нисэж алдуулав.

ЗҮРХ БАРИГЧ ОХИНЫ ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Тэндээс бас урьдчилан шидэт хүүрийг авахаар хүрээд бардам үгээ өгүүлсэнд хүүр бууж ирснийг уутандаа хийгээд дээсээр эрчлэн, тосоо идээд, нуруундаа үүрч иртэл,

– Наран урт, бие ч алжаав, Бас чи нэгэн хууль өгүүл, эс бөгөөс би өгүүлье хэмээвээс, хаан зарлиг эс болсонд

– Чи өгүүлэх бөгөөс тэргүүнээ гэх, намайг өгүүл гэвэл тэргүүнээ дохь хэмээсэнд, хаан тэргүүнээ дохисонд бас хүүр хууль өгүүлсэн нь:

Балар эрт нэгэн цагт Бурам, чихэр, модыг нэмүүлэгч нэрт улсад, Гийгүүлэгч нэрт нэгэн хаан бөлгөө. Түүний нөгчсөний хойно хөвгүүн нь гуа үзэсгэлэнт болоод төгс хүчит бөх их идэрт сэтгэлд зохист тийм нэгэн бөлгөө. Түүнд өмнө зүгийн хааны охиныг авч өгвөөс, тэр хан хөвгүүн түүнд үл баясан, тэндээс нэгэн бээрийн газарт одвоос, нэгэн гэрийн эзний охин нь идэр бие бялдар төгссөн бөлгөө. Хан хөвгүүн түүнд сэтгэлээ тачаан насад тэнд одох болов. Хэзээд нэгэн цагт хан хөвгүүн хатуу өвчнөөр нөгчөөд тэндээс тэр охин түүнийг эс сонсож, хан хөвгүүнээс жирэмсэн бүхийд, тэндээс тэр хааны сүнс шөнө болбоос сарны гэрэлд охины хаалгыг цохисонд, охин гэрэл бариад гарч үзвээс хан хөвгүүн чимгүүдээ тавиад, тэнд ирснийг охин үзэж баясаад хаалганд хүрч, хан хөвгүүний гараас бариад гэрт урьж оруулав. Тэндээс тутарганы дарсыг сайтар хүндлэн өргөвөөс уугаад «гадна ир» хэмээсэнд хойноос даган одвоос «нааш ир» хэмээн зарлиг болсонд, хан хөвгүүний хойноос даган одсонд

хотын дэргэд хүрэв. Хотын дотор хөг дуун дүнгэнэж байв. Охин нь хан хөвгүүнээс

– Энэ юу вэ? хэмээн асуувал

– Чи эс мэдсэн үү, энэ миний хүүрийн тахилыг баригчид буй хэмээн зарлиг болвоос

– Юун хүүрийн тахил барих гээд байна хэмээн өчвөөс

– Би үхсэн буюу. Өдгөө чиний биед агч энэ нуган хөвгүүн төрнө. Төрөхдөө зааны хүрээнээ төртүгэй. Энэ хотын дотор миний эх хийгээд хатан хоёр нэгэн оюу булаалдаж, тэмцэн аху бөлгөө. Тэр оюу миний дэвсгэрийн завсарт бий. Түүнийг хатанд өгөөд өөрийн улсад хариул. Эх хийгээд та хоёул хөвгүүн том болтол хан орныг барь хэмээгээд, хий болон үгүй болж одов. Тэндээс охин маш гуньж үхэтхийн унав. Түүнээс сэрээд, «хан хөвгүүн» хэмээн олонтаа дуудан бие нь нярайлах цагийн өвчин хүртээд, зааны хүрээнд одож тэр шөнө тэнд нэгэн хөвгүүн төрүүлэв. Маргааш нар мандсаны хойно зааны адуулагч ирээд

– Аяа хааны зааны хүрээнд эм нярайлах ёсонгүй. Заанд булай болох хэмээв. Тэр охин

– Гайгүй буюу, чи гэрт орж хан хөвгүүний эхийг энд ир хэмээтүгэй. Нэгэн их хэрэгт буй хэмээв. Тэр түүний үгээр «эхийг ир» хэмээн өчсөнд ирэв. Охин тэдгээр шалтгааныг нэрлэн өчсөнд

– Аяа, гайхамшигт хөвгүүн үгүй бөгөөтөл энэ гайхамшиг хүү мэт их гайхамшигт хэмээн гэрт

ортугай хэмээж, тэр нялх хөвгүүнийг хайрлан үйлдэв. Тэр оюу өгүүлсэн мэт бүхийн тулд маш итгэв. Тэр оюуг хатанд өгч өөрийн газарт хариулав. Эх хийгээд тэр охин хоёр хан орныг тэтгэв. Тэндээс сар бүрийн арван тавны үдэш охины дэргэд хан хөвгүүн ирээд шөнө дуустал нөхцөж, маргааш үүр гийхэд үл үзэгдэн одох болов. Түүнийг эхэд өчсөнд эх нь «худал» хэмээн зарлиг болоод.

– Үнэн бөгөөс хан хөвгүүний нэгэн бэлгэсийг хадгалагтун хэмээв. Түүнчлэн бэлгэсийг хадгалж эхэд үзүүлвээс эх нь

– Үнэн ажгуу. Аяа, охин чи бид эх хөвгүүн хоёрыг учралдуулан чадах нэгэн арга өчтүгэй хэмээн зарлиг болов. Тэндээс арван тавны шөнө хан хөвгүүнийг ирүүлээд тэр охин

– Арван тавны шөнө бүр золголдох нь сайн боловч насад нөхцөж үл болох хэмээн гуньж уйлбаас, хан хөвгүүн

– Чи хатуужлаар чадваас насад нөхцөж болох бөлгөө. Эм хүн хатуужил өчүүхний тулд бэрх хэмээвээс, охин

– Хатуужлыг би даасугай. Хан хөвгүүн лугаа энэ насанд нөхцөж болох бөгөөс, бие мах, яс ангижравч чадна хэмээсэнд

– Тийм бөгөөс нөгөө сарын арван тавнаа сар ургуулаад өмнө зүгт нэгэн бээрийн газар хүрвээс, төмөр өвгөн буцалсан ширмийн усыг уугаад умдаасав хэмээгч тийм нэгэн буй. Түүнд нэгэн тулам тутарганы дарсыг өгөөд, тэндээс одвоос хоёр хонь мөргөлдөн авай. Түүнд нэжгээд өвсийг өгөгтүн. Тэндээс одвоос хуягтан мэс баригсад олон буй. Түүнд нэжгээд мах гурил өгөөд, тэндээс одвоос нэгэн хар байшин айх мэт болоод цусаар сүрчсэн, хүний арьсаар чимэг хатгасан түүний үүдэнд хоёр цусан сүхт эрлэгүүд амой. Түүнд нэжгээд хэсэг цусыг өгөөд тэндээс тэр байшингийн дотор одвоос айх мэт найман тарничнаар хүрээлсний дунд нэгэн мандал буй. Түүний гадуур есөн зүрхээр хүрээлсэн амой. Найман хуучин зүрх нь намайг ав хэмээнэ. Ганц шинэ зүрх нь намайг бүү ав, намайг бүү ав хэмээж байх бөлгөө. Ажиг сэжиггүй тэр шинэ зүрхийг аваад хойшоогоо үл харан төдөлгүй зугтвас, энэ насанд үүрд нөхцөж болох болой хэмээв. Тэндээс тэр охин тэр үгсийг сэтгэлдээ агуулж арван тавны сар оруулаад хэнд ч үл мэдүүлэн хүчин төрүүлж, өмнө зүгт хүрээд, зэргээр үнэ өгч тэр байшингийн дотор хүрэв. Хүрээд «Намайг бүү ав» хэмээгч тэр зүрхийг эндүүрэлгүй аваад нууж зугтаав. Тэндээс тарничид хойноос хөөж «хоёр эрлэг зүрхэнд хулгай оров, баригтун» хэмээв. Тэр хоёр бидэнд «цус өглөө» хэмээн тавив. Тэндээс хуягтан цэргүүдийг «барь» хэмээвээс «энэ бидэнд мах гурил өглөө» хэмээгээд тавив. Тэндээс «хоёр хуц зүрхэнд хулгай оров хэмээсэнд «Энэ бидэнд өвс өглөө» гээд тавив. Тэндээс төмөр өвгөнд «зүрх авагч эмийг барь» хэмээвээс «Энэ надад дарс өглөө» хэмээн тавив. Тэндээс тэр охин сайтар гүйж хотдоо хүрч хаалгыг нээлгэхийн үес, нөхөр нь хан хөвгүүн элдэв чимгүүдээр чимээд ирж, учраад хүзүүг нь тэврэв хэмээсэнд сайн амгалан явдалт хаан

– Тэр охины сэтгэл нь сайтар баясаа биз ээ хэмээн ам алдсанд

– Хишгээ барсан хааны амнаас үг гарав. Сарвад үл сууна хэмээн дуулан нисээд алдуулав.

ЭР ЭМ ХОЁРЫН АРАВДУГААР БҮЛЭГ

Тэндээс бас урьдчилан шидэт хүүрийг авахаар хүрээд бардам үгээ өгүүлбээс хүүр буусныг уугандаа хийн дээсээр эрчлэн, тосоо идэн, нуруундаа үүрч, иртэл

– Наран урт, бие ч алжаав. Бас чи нэгэн мэргэн хууль өгүүл. Эс бөгөөс би өгүүлье хэмээвээс хаан юм эс өгүүлсэнд

– Чи өөрөө өгүүлэх бөгөөс тэргүүнээ гэх, намайг өгүүл гэхүл тэргүүнээ дохь хэмээсэнд, хаан тэргүүнээ дохьсонд хүүр хууль өгүүлрүүн:

Балар эрт нэгэн цагт Удмаагийн цэцэрлэг нэрт улсад, их дүү хоёр хүн буй ажгуу. Тэндээс язгууртнаас гэргий авсанд ах нь дүүгээ маш зовоон гадагш хөөж орхив. Хэзээд ах нь тэр төгс баялагийн тулд тэр улсын хүн бүгдэд хурим өгөхийг сэдэв. Тэр дүү нь

– Надад сайн эс хийвээс хамагт сайн хурим өгөх бөгөөс, намайг урина хэмээн сэтгэв. Түүнийг эс урьсанд «эхэнд нь эс уриваас энэ өдөр их хуримд урих биз» хэмээн сэтгэв. Бас эс урьсанд «маргааш сүүл адгийн дарсанд урих биз ээ» хэмээн сэтгэвээс эс урьсанд түүний сэтгэл гуньж энэ үдэш гэрийн иргэн цөм дарс ууж согтсон буй за. Би одож нэгэн сайн эдүүдийг хулгайлсугай хэмээн сэтгэж, тэнд байшин дотор хүрээд нуугдаж сууваас үдэш орой болтол хүн бүгд дарс ууж, согтоод унтав. Тэр бэргэн нь ахыг согтуу хөтөлж ирээд сангийн гэрт унтуулав. Тэр бэргэн нь хоромхон хэвтэгч болоод босож ах нь унтсанд нэгэн саванд чанасан гурил хийгээд мах идээний зүйл, саримсаг тэргүүтэн амттаныг хийж аваад гадаа гаран одов. Тэр хүн түүнийг үзээд «хойно хулгайламц, урьд үүнийг мэдье» хэмээн хойноос нь даган одов. Тэр эм байшингийн хойно буй нэгэн айх мэт үхээрийн орны тэнд авирч одов. Тэр дүү нь түүнийг давж хойноос даган одож хүрвээс, нэгэн хөхрөн бүхий зүлгэний дунд цайтал дэвссэн чулууны дэвсгэр бүхий тэнд одов. Тэнд одвоос нэгэн хүүр хухирч хэвтэн амой. Тэр хэмээвээс түүний амраг нь бүхийн тулд түүнд тачааж

Шувуу хийгээд араатнаа үл идэгдэн амой хэмээхийг сонсож, одсон ажгуу. Тэндээс тэр хүүрийг үзээд төсрөөс нэрлэн дуудан дэргэд нь хүрээд хүзүүг тэврэв. Тэр дүү нь түүний ойр нуугдаж үзэн суув. Тэр эм тэдгээр идээг хүүрийн өмнө тавьж өгвөөс шүд нь зуурч, аманд эс орсонд зэс халбагаар хүүрийн шүдийг нээж тэр эм идээг өөрөө амандаа үмхээд амаар хүүрийн аманд цутгаж өгвөөс, зэс халбага хугарав. Эмийн хамрын үзүүр хийгээд хэлний үзүүр тасарч хүүрийн аманд хоцров. Төдий цус ихэд гараад зовж идээ авч одсон савнуудаа . аваад харихад дүү нь урьд ирж сангийн гэрт нуугдав. Тэндээс эм эрийнхээ өвөрт оров. Орж хоромхон хэвтэн атал нөхөр нойрмогоор янцагласанд төдий тэр хүн чагнаваас

– Халхай хэмээгээд энэ мэт хүн буй ажгуу. Хэлний үзүүр хийгээд хамрын үзүүр хоёрыг хазав чи. Эм хүнд тэр хоёр үгүй болбоос юун болох хэмээв. Эр нь:

– Би юу ч үйлдсэнгүй хэмээвээс түгдрэлгүй маргааш хаанд өчсүгэй хэмээгээд хэрэлдэн амой. Тэр дүү нь тэр шөнө хулгай үл хийн ус газар одов. Маргааш эрт, тэр эм хааны дэргэд одов. Одоод

– Аяа, хаан минь энэ шөнө миний эр ийм ёсгүй үйлдэв. Эртээс үүний гэргий болж гэмгүй

бөлгөө. Ямар ёст засгаар засаглагдах вэ хэмээн өчсөнд тэнд тэр эрийг нь ирүүлж хоёулыг зэрэгцүүлж асууваас, эм нь үнэн мэт үгс олон өгүүлэн эр нь «би эс мэдэв» хэмээхээс бус үг үгүйн тулд, хаан

– Чинийх буруу хэмээгээд алах модны үзүүрт өлгөв. Өлгөж үхэхэд ойртож бүхийд, дүү нь түүнийг сонсож ирэв. Ирвээс ах нь шургаагны үзүүрт өлгөгдөн бүхүйд

– Юу болов хэмээн асууваас шалтгаанаа өгүүлсэнд дүү нь хааны дэргэд одоод

Аяа, тэнгэр айлдан соёрх, Болгоолгүй хамаг үйлсийг үл итгэтүгэй. Өдгөө ах бэргэн хоёрыг маань зэрэгцүүл. Тэндээс би тодорхой өгүүлсүгэй хэмээв. Түүнчлэн зэрэгцүүлвээс, тэр дүү нь бэргэнээ үхээрийн оронд одож хүүрийн шүднээ хазуулсан тэргүүтнийг нарийнаа өгүүлэв.

– Хаан эс итгэвээс өдгөө хүүрийн аманд бэргэний хэлний үзүүр бүхий ба зэс халбага хугарсан хийгээд хүүрийн хамрын үзүүрт цус наалдсан бүгдийг үзэхээр илгээ хэмээсэнд, хаан түүнчлэн үзэхээр илгээсэнд тэр өгүүлсэн мэт бүхийн тулд «чиний үг үнэн ажгуу» хэмээгээд, ахыг нь шурагнаас буулгав. Тэр эмийг өлгөж алав хэмээсэнд, Сайн амгалан явдалт хаан нь,

– Тэр бүхэн зөв хэмээн үг алдсанд

– Хишгээ барсан хааны амнаас үг гарав. Сарвад үл сууна хэмээн дуулаад нисэж алдуулав.

СУВАРАНДИВ ОХИНЫ АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Тэндээс бас урьдчилан сэрүүн ойд хүрээд бардам үгээ өгүүлсэнд хүүр бууваас уутанд хийгээд, дээсээр эрчлэн тосоо идэн, ардаа үүрч иртэл,

– Олон өдөр болоод, бие ч алжаав. Наран урт, бас чи нэгэн мэргэн хууль өгүүл. Эс бөгөөс би өгүүлье хэмээсэнд хаан юу ч эс өгүүлсэнд,

– Чи өөрөө өгүүлэх бөгөөс тэргүүнээ гэх, намайг өгүүл гэхүл тэргүүнээ дохь хэмээсэнд хаан тэргүүнээ дохьсонд, хүүр хууль өгүүллүүн:

Балар эрт нэгэн цагт, нэгэн улсад их ой болоод, түүний дунд хаа зүгээс ирвээс хоног учрах тийм нэгэн оронд, хожим бодисунгийн бие үүдсэн нэгэн давхар бухар хийд хийгээд, нэгэн эргийн дэргэд өчүүхэн нэгэн байшин буй ажгуу. Түүнд өвгөн эмгэн хоёрт, гоо охин буй бөлгөө. Хэзээд нэгэн цагт голын бэлээр нэгэн үгээгүй хүн нэгэн модон авдрын дотор жимс дүүргэж үүрээд, голын эхэнд худалдахаар одож харьж ирэхэд, хоног нь хонсим бодисунгийн хийдийн дэргэд учирч хонов. Тэр' үгээгүй хүн өвгөн эмгэн хоёрын байшингийн цонхоор чагнаваас эмгэн

– Өдгөө бид хоёр насан болов. Энэ Суварандив охиныг нөхөрт өгвөөс сайн хэмээвээс, эцэг

– Тэр ч үнэн буй, миний энэ жаргалан ба нэгэн шим оюу хийгээд энэ охин сэлт, хонсим бодисунгийн энэ биед хөтлөөд сүсэлснээс болсон бүхийн тулд энэ Суварандив охиныг хэнд өгөх, ном ба ертөнц болохыг маргааш шинийн найман бүхийн тулд тахилыг бэлдэж, хонсим бодисунгаас асууя хэмээн эедэлдэв. Тэр үгийг үгээгүй хүн сонсоод, «өдгөө аргадаж чадна» хэмээн сэтгээд тэр шөнө хийдийн хаалгыг нээж ороод Хонсим бодисунгийн биеийн нуруунаас нь дотор орж авай. Маргааш өвгөн эмгэн хоёр охинтойгоо ирээд тахилгыг бэлдэн мөргөж, эх нь

– Хутагт хонсим бодисун минь, энэ охин тойн болох ба ертөнц болох, хэдийгээр ертөнц болох бөгөөс ямар хүнд өгөхийг илт зарлиг болон соёрх. Эцэс бөгөөс живангирид зүүдэнд өгөн соёрх хэмээсэнд, түүнд тэр үгээгүй хүн хонсим бодисунгийн хамрын нүхээр амаа тулгаж зарлиг болсон мэт болж,

– Чиний энэ охин ертөнц болох нь зөв буюу. Маргааш эрт чиний үүдэнд хэн урьд ирвээс түүнд өгтүгэй. Үйлс нь бүтэх болно хэмээн өгүүлэв. Өвгөн эмгэн «хутагт зарлиг болов» хэмээн маш сэтгэл нь баясаж тэнд мөргөөд харив. Тэндээс тэр үгээгүй хүн бодисунгийн дотроос гараад маргааш эрт үүдэнд хүрээд хаалгыг цохисонд эмгэн ирээд үзэж үтэрхэн орж өвгөндөө

– Хутагтын живангирид үзүүлсэн тэр хүн гадаа иржээ хэмээсэнд, өвгөн

– Тийм бөгөөс сайн буюу. Гэрт оруул хэмээж оруулаад идээ умдааныг төгс найруулж хүндлээд, охиноо нэгэн шим оюу сэлтийг түүнд өгч нарийнаа өгүүлэв. Тэр «тийн хийсүгэй» хэмээн охиныг аван модон авдрыг үүрч оюу эрдэнийг зүүж харив. Голын адагт өөрийн гэрийн дэргэд хүрээд,

– Өдгөө өвгөн эмгэн хоёрыг аргалж чадав, би. Одоо би энэ охиныг авдранд хийгээд энэ элсэн талд нууж тавиад нэгэн арга үйлдье хэмээн сэтгээд, оюу хийгээд охиноо модон авдранд хийгээд элсэн талд нууж тавиад орондоо хариад улсдаа

– Урьд олонтаа хэрэг хийж эе баяжив. Өдгөө хувируулагч дайсан түйтгэрийг хөнөөхийн зан үйлс үйлдэхүйд хэрэг буюу хүнээс эд гуйгаад нэгэн хэрэг хийв. Маргааш даруйд буяныг хураах нэгэн хэрэг хийнэ хэмээн эдийг гуйна.

Тэр учирт бус нэгэн улсын хааны хөвгүүн уйдсанаа сэргээхийн тулд саадгаа агсан нэгэн барсыг хөтөлж хоёр боол лугаа гурвуул тэнд учрав. Учраад Суварандив охиныг булсан тэр элсэн талд хүрэв. Тэр барайж агч элсэн довыг харвая хэмээж харваад онож сум нь хадсанд элсийг эрж үзвээс тэр авдранд хадсан байв. Түүнийг нээж үзвээс охин лугаа оюу гарсанд

– Аяа, охин чи хэн бэ хэмээн асуусанд

Би лусын охин хэмээсэнд, хан хөвгүүн

Миний хатан бол, намайг дагаж одтугай хэмээвээс

– Би үл одно. Энэ авдранд нэжгээд амьтан байх хэрэгт буй хэмээсэнд, модон авдранд барсыг хийж тавив. Охин оюу сэлтийг хан хөвгүүн аваад одов. Тэндээс тэр үгээгүй хүн даруйд буян хураах хэргийг дуусгаад

– Би охиныг алаад оюуг эдэлвээс баяжина хэмээн сэтгэж авахаар одов. Элсэн талаас авдраа гаргаж үүрээд ирж байшингийн дотор тавив. Жич хэрхэндээ

– Энэ шөнө даруйд буяныг хураахын хэргийг тахиж үйлдэх хэрэг буй. Исгэрэх ба хашхирах дуун болбоос бүү ирэгтүн хэмээн захирав. Тэндээс «тэр охиныг алдуузай» хэмээн хаалгаа хааж ороо засан өөрийнхөө хувцсыг тайлаад авдрын амсрыг нээж

Аяа, охин зовж чилэв үү, гарч ир хэмээсэнд барс босон харайсанд маш айж,

– Аяа, хохой барс ирэв. Эм минь барс болов. Нөхцөлдөгчид ир хэмээн хашхирч, нүцгэнээр барс лугаа уралдваас гэргий хөвгүүд нь «буян хураах хэрэг нь түргэн болоод яаралтай буюу» хэмээн инээлдэв. Маргааш эрт үзэхээр одвоос гэрийн буланд нэг их барс ам хийгээд хөлөө цусадсан нэгэн эрээлж суун амой. Эцэг нь үхэж яс нь бутран амой.

Тэндээс тэр охин хааны хатан болж гурван хөвгүүн төрүүлж төгс жарган атал, хэзээд нэгэн цагт ноёд харцас нь

Манай энэ хаан өчүүхэн үйлт буюу. Газрын доороос гарсан эмээр хатан болгов. Хөвгүүн болбоос нагац үгүй юун хэрэг хэмээн өгүүлэлдэв. Хатан түүнийг сонсож сэтгэл нь маш зовж, надад гурван хөвгүүн болбоос эдгээрийн энэ охинд өөрийн эцэг эх өвгөн эмгэний дэргэд одсугай хэмээн сэтгэж, арван тавны сар ургуулаад, сац хотоос гарч одов. Цааш явбаас маргааш наран гарахад эцэг бүхий газрын ойр хүрвээс, тэнд урьд үгүй олон тариа байв. Тэр тариадыг олон хүн тэр бүхийн дотроос, нэгэн засалт харавтар хүн ирж, элдэв идээ умдаан

найруулан амой. Тэр хүн

– Охин чи хаанаас ирэв хэмээвээс,

Хол нэгэн газраас ирлээ хэмээсэнд

– Өдгөө хааш одно хэмээвээс

– Энэ уулын хойно минин эцэг эх өвгөн эмгэн хоёр бөлгөө. Түүний мэндийг асуухаар одно хэмээсэнд

– Тийн бөгөөс тэдний охин мөн үү хэмээвээс мөн хэмээсэнд

– Аяа, би түүний хөвгүүн буюу. Надад нэгэн эгч буй хэмээх тэр мөн ажгуу. Чи энд сууж идээ умдаанаар ханатугай хэмээсэнд идээ умдааныг дуусгаад, тэр хүн лүгээ хамт ханилж одвоос тэр уулын өнцгөөс харваас эртний байшингийн оронд маш их байшин нь хааны хотоос хэр үлэмж болоод ялгуусан чимэг хийгээд манжилгаар чимсэн тийм нэгэн бөлгөө. Түүний дэргэдэх бодисунгийн бухар хийд урьдахаас үлэмж их болоод, алтан дээврээр чимсэн, манжлага молор хонхсын дуун сонстох тийм нэгэн бүхийд

– Энэ хэнийх вэ хэмээн асууваас

Эдгээр нь биднийх. Би чиний хойно барьсан бөлгөө. Эцэг эх хоёр мэнд буй хэмээв. Тэндээс гэрт хүрвээс адгуусны хүрээнээс аван морь луус тэргүүтэн эд малаар дүүрч байв. Эцэг эх хоёр хивийн тавцанд сууж атал охиноо үзээд

– Чи мэнд болоод, эцэг эх хоёроо амьдад золгохоор ирсэн чннь маш сайн хэмээгээд, шалтгааныг нарийнаа өгүүлсэнд эцэг эх нь, хаан түшмэд харцас лугаа энэ мэт өгүүлэх бөгөөс хаан нөхөд сэлтийг урь хэмээгээд урив. Уриад эд агуурсаар гурван хоногт хүндэлвээс маш баясаж, энэ хатныг төрхөмгүй хэмээгч худал ажгуу хэмээлдээд, хаан нөхөд сэлтээр баясаад ханаж харив. Тэнд хатан нь нэгэн хоногт саатан, эцэг эхээс хагацан ядаж хоноод үгсээр ханалцав. Тэр шөнө хэвтээд маргааш өглөө дэрлэсэн дэрээ хатуу болсонд

– Юу болов, энэ шөнө эцэг эх лүгээ хамт ажгуу. Дэр дэвсгэр хив тэргүүтэн бөлгөө. Энэ юу болов хэмээн сэтгэж тэргүүнээ өндийж үзвээс юмгүй болоод эртний өчүүхэн байшин эвдрээд эцэг эх хоёр нь үхэж гаднаа яс нь хувирч амой. Дэр нь нэгэн хавтгай чулуунаас бус үгүй болоод шороон дээр хэвтэж бүхийд сэтгэл нь маш үл баясан, өдгөө бухар хийдийг үзсүгэй хэмээн сэтгэж хүрвээс, бухар хийд эвдэрч бодисунгийн бие хомс болсныг үзэж, тэндээс эхнэр

– Аяа хохой энэ хэмээвээс хутагт хонсим бодьсатва миний төрхөм болон хувилсан ажгуу. Хаан нөхөд сэлтээр баяссан бөлгөө. Өдгөө тэнд одсугай хэмээн сэтгээд тэнд одвоос, ноён ба харц бүгдээр хатан холоос айсуйг үзээд

Энэ хатан болбоос маш хүчин аугаа их төрхөмт болоод төрөл нь ариун биетэн болж, хатан өөрөө, төгс гоо бие бялдарт буй хэмээн агуу их угтуулаар угтав. Тэндээс ордондоо хүрч ирэв

хэмээсэнд, Сайн амгалан явдалт хаан

– Тэр мэт их буян хишигт охин бол хэмээн ам алдсанд

– Хишгээ барсан хааны амнаас үг гарав. Сарвад үл сууна хэмээн дуулан нисэж алдуулав.

НЯЛХ ХААНЫ АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ

Тэндээс бас урьдчилан одоод сэрүүн ойд хүүрийг авахаар урьд ёсоор хүрч бардам үгээ өгүүлснээр хүүр буусанд, уутандаа хийгээд дээсээр эрчлэн тосоо идэн, ардаа үүрч иртэл,

Наран урт, бие алжаав.

Бас чи нэгэн мэргэн хууль өгүүл, эс бөгөөс би өгүүлье хэмээсэнд хаан юу ч хариу эс өгүүлсэнд

Чи өгүүлэх бөгөөс тэргүүнээ гэх, намайг өгүүл гэхүл тэргүүнээ дохь хэмээсэнд хаан тэргүүнээ дохисонд, хүүр хууль өгүүллүүн

– Балар эрт нэгэн цагт Цэцгүүдээр чимсэн нэрт жаргалант улсад хатуу бүгд зандан хийгээд, амирын мод ба үзмийн мод тэргүүтсэн элдэв модоор дүүрсэн. түүний дотор элдэв үр тариа болохын тариалан хийгээд усны залгал уулзвар урсан бүхий тиймийн дунд, Алтан төгссөн нэрт хот болоод, түүний гадуур нь балгадаар хүрээлсэн тийм нэгэн бөлгөө. Түүнд Нялхсын оюут хэмээх нэгэн цагт өөрийн боол Гэгээн оюут хэмээх нэгэн хөвгүүнд

– Чи Гэгээн оюут буй хэмээгч үнэн бөгөөс, миний энэ сүнсний оюуг хулгуулж авч чадтугай. Чадах бөгөөс их өглөг өгсүгэй. Эс чадваас орон газрыг ч булаагаад нүдийг ухсугай хэмээв. Тэр эс болон эс зөвшөөрсөнд арван тавны шөнө хулгайल्या хэмээн ам аваад одов. Тэндээс хааны оюуг шурагт уяж хаалгаа хааж бус шагайгчдыг зэргээр захиж мануулав. Тэндээс Гэгээн оюут хэмээх тэр хөвгүүн, арван тавны үдэш өтгөн тутарганы дарс авч одоод хааны адуучин хаалганд агсан тэдэнд өгөөд

– Өдгөө би оюуг авч үл чадна. Хааны нойр хүрэхгүй амой хэмээгээд тэднийг согтоов. Тэндээс нэгэн хатсан гүзээ хийгээд сүрлэн малгайны орны үзүүр хэвгээр үүдсэн нэгэн малгай гурван моголцог чулуу хийгээдийг бариад шөнө дүл хотын дотор орвоос үүдэнд адуучин морио унасаар унтаж бүхийд арга олоод нэжгээдчилэн мориноос буулгаж шавар хэрэмд унуулж тавив. Тэндээс дотор орвоос, идээний гэрт шивэгчин хувцсаа үл тайлан галаа түлэхийг завдаж, нойрмоглох амой. Тэр галд шадар агсны тэргүүнд сүрлэн малгайг өмсгөв. Түүний дэргэд агчийн ханцуйд моголцог чулууг хийж тавив. Тэндээс хоймор өөд одвоос хаан унтан бүхийн тэргүүнд хатсан гүзээг өмсгөв. Шурагт тэр оюу гялбалан бүхийн гадуур ардууд тойрон хэвгэж амой. Тэр тэдгээрийн үсийг холбож, тавиад, тэндээс тэр оюуг шургаас тайлан аваад, шатнаас харайж зугтсанд хамгаар «хулгай ирэв» хэмээлдэн, үсүүдийг холбосон тул «намайг бүү тат! Намайг бүү тат» хэмээн овоорч суув. Хаан

– Аяа, нөхөд үтэр гүйгтүн. Оюу аваад миний тэргүүнийг хадаж амой. «Гал шатаа» хэмээсэнд тэр шивэгчин галыг үлээсэнд сүрлийн малгайд гал шатаж тэргүүн нь түлэгдэв. Нөгөө шивэгчин түүнийг ханцуйгаар дэлдвээс чулуугаар гурван яр гаргав. Тэр шивэгчид хулгайчийг үл хөөн шархаа аргална. Тэндээс

– Адуучдад хулгай ирэв. Үтэр үлд хэмээсэнд, дарсанд согтсоноор хэрмийг давж хэвтэхээс бус хариу эс олов. Тэндээс тэр оюуг авч гэртээ хүрэв. Маргааш тэр сүнсний оюуг авч хааны дэргэд одвоос, хаан хилэгнэж бүхийд, Гэгээн оюут өгүүллүүн:

– Хаан бүү хилэгнэтүгэй. Оюуг харин өргөө хэмээн өчсөнд оюуг юун хэргээ үйлдэвч үйлд. Энэ шөнө босож гайгүй болтугай. Миний тэргүүнд гүзээг өмсгөснөөр би тэргүүнээ хадсан мэт сэтгэж айв. Тэр мэт ёсгүйн тулд, энэ хүнийг өдгөө бөгөөд засгийн гэрт авч одоод хүзүүг нь огтол хэмээсэнд Гэгээн оюут

– Өдгөө юун үйлдвээс энэ хаан сайн үл болно хэмээн сэтгэж үтэр гарч сүнсний оюуг хаданд дэлдвээс хааны хамраас цус гарч үхэв хэмээсэнд, Сайн амгалан явдалт хаан:

– Тэр юутай алиа буй хэмээн ам алдсанд

– Хишгээ барсан хааны амнаас үг гарав. Сарвад үл сууна хэмээн дуулаад нисэж алдуулав.

БЯРМАНЫ ХӨВГҮҮН ХААН БОЛСОН АРВАН ГУТГААР БҮЛЭГ

Тэндээс бас урьдчилан сэрүүн ойд урьд ёсоор шидэт хүүрийг авахаар хүрч бардам үгээ өгүүлсэнд, хүүр бууж ирснийг уугандаа хийгээд, дээсээр эрчлэн, тосоо идэн үүрч иртэл,

Олон өдөр болж, наран урт бие ч алжаав. Бас чи нэг мэргэн хууль өгүүл, эс бөгөөс би өгүүлье хэмээсэнд хаан юу ч эс өгүүлсэнд

– Чи өөрөө өгүүлэх бөгөөс тэргүүнээ гэх. Намайг өгүүл гэхүл тэргүүнээ дохь хэмээвээс, хаан тэргүүнээ дохисонд шидэт хүүр хууль өгүүлрүүн:

Тийн бөгөөс балар эрт нэгэн цагт, нэгэн хязгаар улсад нэгэн бярманы хөвгүүн буй ажгуу. Хэзээд тэр өөрөө харьяат нэгэн тариагаа худалдаж гурван баг өрмөг аваад, нэгэн илжгэнд ачаад бус нэгэн улсад одов. Одвоос нэгэн талд олон хөвгүүд нэгэн хулганыг бариад, түүний хүзүүнээс дээс уяж усанд дүрэх хийгээд чирэх тэргүүтнээр зовоон бүхийд тэр түүнийг өршөөж эс тэсээд

– Аяа, хөвгүүд энэ хилэнцэт буюу, үүнийг тавь хэмээсэнд, хөвгүүд

– Энэ манд хэрэгтэйн тулд барьсан буюу. Чи юун алиа хүн вэ хэмээв.

Тийн бөгөөс үнэ өгье хэмээн нэгэн баг өрмөгөө өгч хулганыг авч тавив. Бас одвоос нэгэн замын бэлчирт олон хөвгүүд нэгэн сармагчны зулзага бариад наадаж эс чадваас эргүүлж наадан шийдмээр занчихад өршөөж «тавь» хэмээвээс, эс тавьсанд бас нэгэн баг өрмөг өгч худалдаад авч ойд тавив. Тэндээс бас одвоос нэгэн балгадын адагт олон хөвгүүд нэгэн өтөгний (баавгай) зулзага барьж унах тэргүүтнээр зовоон бүхийд эс тэсээд өршөөж ганц баг өрмөгөө өгч аваад ойд тавив. Тэндээс түүнд өрмөг үгүй болоод илжгээ унаж одохдоо

Би худалдаанд ирвээс өдгөө эд үгүйн тулд аргагүй буюу. Хааны ордонд одож хулгай хийе хэмээн сэтгээд илжгээ зузаан ой дотор нуугаад, хааны хотод хүрч хаалганы завсраар орж сангийн гэрээс нэгэн баг хивүүдийг хулгайлж үүдэнд иртэл хатан лугаа учрав.

– Аяа, энэ хүн хотоос юм хулгай хийв хэмээн дуу гарсанд, иргэн хурж түүнийг барив. Хаан:

– Ёсгүй үүнийг нэгэн модон авдранд хийж төмрөөр хадаад усанд хая хэмээвээс, түүнчлэн усанд хаяв. Тэр уснаа урсаж нэгэн хойгт гарваас амь бүтэж үхэхэд ойртон атал, авдарны гаднаас нэгэн амьтан маажив. Өчүүхэн цоолсонд гарч ирвээс эртний өрмөг худалдаж тавьсан тэр хулгана буй ажгуу, Хулгана өгүүлрүүн,

Сэтгэлээ сулхнаа агуултугай. Би бус нөхдөө авчирсугай хэмээгээд одов. Тэндээс амин уурыг амсгуулснаар эс үхэж аваас, тэр хулгана бэчний дэргэд одож шалтгааныг өгүүлсэнд тэр бэч ирж авдрын ихэнхийг нээв. Тэндээс өтөг ирж хуурцгийг хагачиж, хавтгай зүлгэний дээр гаргав. Тэндээс тэр гурав мод өгч, тэр хүнийг тэжээн уснаас гарган ядан авай. Хэзээ нэгэн шөнө болбоос тэр өтөг усны чанд далайн дунд нэгэн маш их гэрэл бүхийд бэчийг үзүүлэхээр илгээвээс шувууны өндөгний төдий чандманийг олов. Түүнийг авч бярманы хөвгүүний гарт өгвөөс, энэ усны чанд хүрэх ерөөлийг залбирсанд түүнчлэн болов. Тэнд тэр далайн дунд

балгасанд байшингуудаар давхарласан түүнд морийг хүрээгээр давхарласан, орчин бүхий тариа болоод элдэв мод ургасан, рашааны булаг урссан, дотор нь эдээр дүүргэсэн тийм болох ахуй их ерөөл ерөөгөөд унтав. Нүдээ нээвээс тэр мэт болжээ. Тэнд жарган атал, нэгэн цагт нэгэн их хэсэг худалдаачин ирж хамгаар гайхалдруун:

– Энэ юун буй. Урьд энэ тал хоосон бөгөөтөл өдгөө энэ мэт гайхамшиг хэмээж, тэр сартваахь бярманы хөвгүүний дэргэд одоод асуусанд шалтгааныг нарийнаа өгүүлж, чандманийг үзүүлсэнд, сартваахь өгүүлрүүн:

– Чамд дэлхийн юм төгсөж амой. Үүгээр болно. Эдгээр худалдаачны унасан ачсаныг цөм чамд өгсүгэй. Энэ чандманиа надад соёрх хэмээн өчив. Түүнчлэн хүслийг хангагч чандманийг сартваахид өгөв. Бярманы хөвгүүн хивүүдийн дэвсгэрт хэвтэв. Маргааш эрт унтан бүхий агаарт орон нь хатуу ширүүн бүхийд сэрж үзвээс эд, гэр балгас юухан бээр үгүй болоод эртний хойг дэх зүлгэн дээр суун амой. Тэнд гашуут болоод суун атал гурван нөхөд нь ирж «юу болов» хэмээвээс шалтгааныг өгүүлсэнд

Чи болгоомжгүй хүн буюу. Чандманиа юунд өгөв хэмээгээд өдгөө гурвуул одож авсугай хэмээн одов. Тэнд хүрвээс сартваахь төгс аугаа хүчит болж суун амой. Хаалганы завсарт өтөг, бэч хоёр эс багтав. Хулгана чандманийг хаана бүхийг үзэхээр илгээвээс хулгана хаалганы нүхээр орж дотор хүрвээс, нэгэн шилт байшингийн дотор сартваахь унтаж амой. Тэр хоймроо нэгэн их тутарганы дунд сум хатгаж сумны үзүүрт чандманиа уяд тутарга овоолсны ёроолд хоёр их мэс уясан байв. Чандманий дэргэд одон эс чадав. Хоёр нөхрийн дэргэд одож шалтгааныг өгүүлсэнд өтөг

– Өдгөө аргагүй, харъя хэмээв. Бэч

– Тийм бөгөөс надад нэгэн арга буюу хэмээгээд, Хулгана чи одож энэ үдэш хааны гэзгийг хазаж ир. Тийн үйлдбээс маргааш үдэш мэсээ миний дэрний тус уя та хэмээнэ. Тийн уябаас чандманийг хулгайлж болно хэмээв. Түүнчлэн гэзгийг нь хазваас маргааш өглөө хаан сэрээд тэргүүнээ өндийлгөсөнд гэзэг нь цөм унаваас тэргүүнээ тасарч унасан мэт сэжиг төрж

– Аяа, энэ шөнө хулгана гэзэг хазжээ. Өдгөө их хэрэг хийгтүн. Энэ үлдсэн гэзгийг сахихын тулд мэсийг ширээний хөлөөс уятугай хэмээв. Түүний үдэш өтөг бэч хоёр хаалганд хүлээж хулганыг чандманийг хулгайлахаар илгээвээс хүрээд тутарганы ёроолд мэс үгүйд баясаад чандманийг авахаар дүүлвээс сумны үзүүрт эс хүрч хоосон харьсанд өтөг нь «өдгөө аргагүй харъя» хэмээв. Бэч

– Энэ сайн буюу. Чи одоод суманд авирч эс чадваас сумны ёроол дахь тутаргыг малтваас сум унах болно. Тэндээс чандманийг өнхрүүлж иртүгэй хэмээв. Тэндээс хулгана түүнчлэн үйлдэж чандманийг хүрээнд хаяж хүрээнээс хаалганд өнхрүүлж хаалганы бул хүрч ирээд, тэндээс булны нүхээр чандманийг эс багтааж алжаагаад гадна гарч ирээд

– Эндэхнээ энэ хүний дотор авч ирлээ. Үүгээр гаргаж эс чадав хэмээсэнд өтөг

– Бэч бид хоёр булны нүхээр үл багтана. Өдгөө аргагүй тул харъя хэмээсэнд бэч

– Арга буй хэмээгээд хулганы сүүлнээс утсыг уяж, Өдгөө хулгана чи өөрөө дөрвөн хөлөөр чандманийг хичээж тэвэр. Би утаснаас татсугай хэмээв. Түүнчлэн татсанд хулгана чандмань лугаа хамт ирэв. Тэндээс хулганыг алжаав хэмээн бэч өтгийг унаж хулганыг чихэндээ хийж, чандманийг амандаа үмхээд хурдан одов. Зуур замд өвдөг чинээ нэгэн усыг гэтлэхэд өтөг

Бэч хийгээд хулгана чандмань бүгдийг үүрсний тул их хүчит буй хэмээн сэтгээд, би энэ мэт ихийг даав зэ хэмээсэнд, хулгана нь алжааж унтсан ажгуу. Бэч хариу өгүүлбээс, аман дахь чандмань унана хэмээн хариу эс өгүүлсэнд, өтөг хилэгнэж

– Та хоёр хариу эс өгүүлвээс усны дунд хаяна хэмээсэнд бэч, бүү хая хэмээхэд аман дахь чандмань усанд унав. Бас тэндээс усны хязгаар гараад бэч өтгийг гэмшихээр «Чи нэгэн муу чанарт амьтан буй» хэмээн хэрэлдэхийг нь хулгана сонсож, «Энэ юу вэ хэмээвээс» энэ мэт болов хэмээн өгүүлээд, «Өдгөө хэрхсүгэй» хэмээсэнд өтөг бэч хоёр

Ил газарт үгүй, усны дотроос үл олно, харъя хэмээсэнд хулгана

Би нэгэн аргаар үзсүгэй. Та хоёр тэнд суу хэмээгээд хулгана тэр усны. хязгаарт чис чис хэмээн дуун дуурсаад дээш доош гүйсэнд, усны дотор агч амьтан ирж

– Аяа, хулгана чи энэ мэт юунд яарна хэмээвээс, хулгана:

Та эс сонсов уу? Усанд үл түдэх, талд үл түдэх нэгэн цэрэг ирнэ хэмээн өгүүлсэнд

– Тийн бөгөөс юун хэрэг хэмээвээс,

– Бус аргагүй. Чийг чилгэр хоёрын энэ завсарт хаалт бариваас сайн хэмээв. Түүнчлэн уснаа агч хамаг амьтан чулуу зөөгч, хулгана баригч болон нэгэн төө болоход нэгэн их мэлхий их чандманийг өнхрүүлж чулуунд үүнээс нэн хүнд үгүй буюу хэмээв. Даруйд хулгана бэчийг дуудаж ирүүлээд

Чандмань энд буй хэмээсэнд бэч баясаж «Ухаант хулгана» хэмээгээд, чандманийг аманд үмхээд хулганыг чихэндээ хийж, өтгийг унаж одов. Одвоос бярмань хөвгүүн өлсөж үхэхэд хүрч амой. Бэч чандманийг өгвөөс

– Нөхөд минь маш сайн ачит буюу хэмээгээд, усны захад хүрээд урьд ёсоор ерөөсөнд хааны хотоос нэн үлэмж байшинт болоод сэтгэшгүй олон албат болон жимст элдэв мод хийгээд, элдэв дуут шувуун сонсох мэт эгшгийг хувилгаж, насад элдэв цэцгүүдээр бүх амтат жимс болоод, өвөл хэмээх нэрийн төдий хаваргүй болоод эд агуурс төгссөнд, чандмань эрдэнэт бас залбирав.

Чандмань эрдэнэ мөн бөгөөс надад эм үгүйн тулд тэнгэр нарын орноос Асурийн охиныг миний хатан болгон соёрх хэмээсэнд сац тэнгэрийн охин тоолшгүй нөхдөөр хүрээлүүлэн ирэв. Түүн лүгээ баясалцсанаас юун хөвгүүдэд сэтгэлт тэргүүтэн болов хэмээсэнд Сайн амгалан явдалт хаан

Тэр мэт хүн ч их буянт буй хэмээн ам алдсанд

Аяа, хаан өдгөө сайн сайн хэмээн Наганжуна багшийн өмнө чухал бүхийгээс огторгуйд нисээд одов. Багш зарлиг болруун

– Чиний хатуужилд гэм үгүй болбоос замбутив дэх ерийн амьтны буянд эс багтсан болой. Чи өөрөө шидэс хүүр арван гурвантаа үүрсний тулд энэ насанд хүчин аугаа эд агуурсыг бус юун, тэнцэж үл больюу хэмээв.

АХ ДҮҮ ХОЁРЫН АРВАН ДӨТГӨӨР БҮЛЭГ

Тэндээс бас сэрүүн үхээрт урьдчилан үйлдэж хүрээд шидэт хүүрийг үүрч ирсэнд наран уртын тулд уйдаад,

– Сайхан хуулийг өгүүл гэсэнд хаан юуг ч эс өгүүлэв. Хүүр өгүүллрүүн:

– Чи өгүүлэх бөгөөс дохь, намайг өгүүл гэхүл гэхи хэмээсэнд Сайн амгалан гэхисэнд

– Урьд цагт энэтхэгийн Өрнө зүгийн нэгэн балгадад ах дүү хоёул бөлгөө. Ах нь эд тавааргүйн тул бусдад тоомжгүй бөгөөд, өвс мод худалдаж амиа тэжээгч бөлгөө. Дүү нь хамаг баялаг бүхий бөгөөтөл ахдаа тус үл хүргэгч ажгуу. Нэгэн учирт дүү нь хамаг улсыг хурааж их баярын хурим хийвээс ахыгаа эс уриад хувь нь тасалваас, ахынх нь гэргий

– Аяа. эр минь чи үхвээс сайн. Үргэлжид тусгүй боловч хуримын хувийг чинь таслав хэмээн өгүүлвээс

– Тэр үг чинь зөв. Өдгөө үхсүгэй хэмээгээд сүх дээсийг аваад олон уулыг гэтэлж нэгэн шугуйн эхэнд хүрвээс тэр голд арслан барс тэргүүтэн олон араатан дүүрсэн тэр голын эхэнд одвоос нэгэн их хадны дэргэд олон хөг дуун хийгээд олон баатар дагинас огторгуй дүүрэн бууж суух ажгуу. Тэдгээр чуулсны дотроос нэг жигүүрт дагина нисэж одоод, нэгэн хадны нээвчээс нэгэн тулам авч ирээд, бүгд дотор амсрыг нь нээгээд дотроос нэгэн төмөр алхыг аваад, тэр тулмыг дэлдвээс идээ хувцас юу хэрэглэх бүхэн тэр дотроос гараад их чуулсан хуримыг үйлдээд бас тэр дотроос алт мөнгө тэргүүтэн элдэв зүйл эрдэнэсийн титэм манжлага тэргүүтнийг гаргаад дагинас биеэ чимэглэж бүжиг тэргүүтнийг олон зүйлээр бүжиглэсээр огторгуйд одов. Урьдын тэр дагина нь тэр тулмыг авч нисээд мөн хаданд тавиад хөг дуунаар дуурсгаж бас огторгуйд одов. Тэр хүн дагинасыг чуулсан газарт одвоос юу ч үгүй ажгуу. Хаданд агсан тэр тулмыг үзмэгц олон модыг огтолж шат хийв. Шатаар авирч тэр тулмыг авав. Тулам доторх алх аваад дохиж, хүссэн идээ нь зүйл бүр гарваас түүнийг ханаж цадтал идээд тулам, алхыг гэртээ авч хариваас, түүнийг эхнэр нь үхсэн мэт санаж суусан бөлгөө. Эрээ үзээд уйлваас

– Аяа, миний тул бүү уйл. Бид хоёр амь зуух юмыг би авч ирэв. Эмийнхээ гарт тулмыг өгвөөс, тулмыг нээж үзээд дотроос эд идээг хэдий хүссэний чинээгээр аваад хойно мод өвс худалдахаа байж жаргаж суутал, хамгаар зөвлөлдөж ийн өгүүллрүүн:

– Гэнэт энэ юуны хүчээр ийм баян жаргалтай болов хэмээлдээд төдий дүүгийн эхнэр нь

– Чиний тэр ах манай сангаас лав хулгайлж аваад баян болов уу хэмээсэнд түүнийг эр нь үнэмшээд, ахыгаа урьж,

Чамд ийм эд таваарыг хэн өгөв, хаанаас олов? Миний эдээс хулгайлсан буй. Надад эс өгвөөс би чамайг хаанд мэдүүлнэ. Нүдийг чинь ухуулна хэмээсэнд ах нь

– Чиний нүдэнд үл үзэгдэх хол газарт одож үхье хэмээгээд нэгэн хад уулын дэргэдээс ийм тулам, алхыг олов хэмээн урьд үгсээ дэлгэрэнгүй өгүүлвээс

– Тэр газар чинь хаана буй? Надад үзүүл хэмээв. Тэр газрыг нь зааж өгмөгц, тэр зүгт ахынхаа ёсоор сүх дээсийг авч тэр ойд одвоос тэр хадны дэргэд найман аймаг чуулж уйлалдан байхыг үзвээс, нэгэн учирт биеэ нууж эс чадаад, нааш цааш явахын зуур, найман аймаг түүнийг бариад

– Манай тулмыг хулгайлагч хүн энэ мөн буй за. Үүнийг алсугай хэмээгээд нэгдэж эдэлдэв. Тэр дотроос нэгэн чөтгөр

– Үүнийг алж юу хийх вэ. Үүний биед нэгэн муу бэлгэ тавьж, хүний дэргэд үл одох мэт болгосугай хэмээвээс, хамгаар түүний үгийг зөвшөөрч, тэр хүний хамрыг нь сунгаж татаад есөн зангиа зангидаж тавьсугай хэмээлдээд найман аймаг хамрыг нь найм зангидав. Ганц хөлт чөтгөр

– Миний хувь нэг зангид хэмээгээд ёс зангидаж тавив. Төдий найман аймаг үл үзэгдэн одов. Тэндээс тэр хүн хамраа чирж гэртээ шөнө хүрч ирэв. Түүний эхнэр нь хамрыг нь үзээд цочиж дутаан одов.

– Надаас бүү дугаа. Урьдах хүн би мөн. Надад үзэхэд муу мэт болов. Нэгэн үе амиа тэжээсүгэй, түүний хойно үхсүгэй хэмээв. Хамаг бүгдээр асууваас «өвдөв» хэмээн өгүүлэв. Нэгэн учирт түүний ойр хаданд даяанд суусан нэгэн лам буй ажгуу. Түүнийг залж ирээд ван авшиг аваад үхсүгэй хэмээн сэтгээд, ламыг залж ирээд ван авшиг авахдаа хамраа үл даан суухад лам нь

– Чамд юу болов, надад үзүүл хэмээвээс

Үзүүлэх аргагүй, чамаас ном сонсоод үхсүгэй би хэмээн өчвөөс, лам нь

– Надад гайгүй, үзүүл хэмээвээс, тэр хамраа үзүүлсэнд лам айж дугаав. Тэр ламыг залаад буян өргөж урьд үгсээ дэлгэрэнгүй егүүлээд

– Миний хамрын зангиаг алдруулах арга ламд буюу хэмээн өчвөөс

– Надад үгүй, бичигт үзсүгэй. Бичигт үгүй аваас, үхэх чинь болно хэмээвээс

Маргааш хүртэл чиний зарлигаар болсугай. Арга эс олдвоос үл үхэж юу хийнэ. Лам нааш харьж ирээд

– Чнний ахын авчирсан тулам алх хоёроор энэ хамрын зангиаг, эс алдруултаас бус алдруулах арга миний бичигт үгүй хэмээвээс, ахдаа эхнэрээ илгээж

– Чи тэр олсон тулам алх хоёроо авч ир хэмээвээс, ах нь

Миний энэ алх тулмыг булаах ажгуу хэмээн сэтгэв. Үл булаах ам авалцаад алхаа бүсэндээ хавчуулж одоод, дүүдээ

– Чамд ямар гэм болов хэмээвээс дүү нь

– Ийм гэмт зовлон болов. Чамд эд таваар юу хүссэн чинь олдов. Чи тэр алхаар миний энэ хамарт дохиж энэ зангиаг алдруул. Энэ зовлонгоос гарваас миний газар эд таваарын хагасыг чи ав хэмээхэд ах нь

– Тэр чинь үнэн бөгөөс бичиг тамга авалцсугай хэмээвээс, төдий бичиг авалцахад

– Есөн зангиаг бүгдийг алдруулваас эд таваарын хагасыг ав хэмээгээд ах нь бичгийг гартаа барьж байгаад алх далайж дохивоос Найман аймгийн зангиас алдартугай хэмээгээд, нэжгээд нэжгээд дохивоос нэжгээд нэжгээд алдрав. Нэг зангиа үлдсэн учирт дүүгийн эхнэр нь

– Би эд газраа хайрлана, зангиа алдруулах хялбар ажгуу. Нэгэн зангиасыг бүү алдруултугай хэмээв. Ах нь:

– Энэ бичиг тамгаа эс тоов хэмээгээд сүхээ аван зугтаав. Энэ нэгэн зангиаг эс алдруулваас үл зохино хэмээгээд бэр нь хадам ахынхаа хойноос гүйгээд ах нь үүдэндээ орохын зуур бүсэнд хавчуулсан алхыг аван нааш зугтаав.

Булааж одов хэмээн ах нь эхнэрийн хойноос нэхвээс гүйцэхийн зуур гэртээ орохуй

– Найман аймгийн зангиа алдраг хэмээн урьд ёсоор дохивоос эм хэмжээг эс мэдээд эрийнхээ магнайг цөм цохиж тархи нь гарч үхэв. Урьд газар ус, эд таваар эм тэргүүтнийг ах нь эзлэв. Төдий Сайн амгалант хаан

– Тэр ах дүү хоёуланг эхнэр нь хутгасан ажгуу хэмээвээс

– Заяагаа барсан хааны амнаас дуун гарав. Сарвад үл сууна би хэмээж огторгуйд нисэн одов.

ХААН, ТҮШМЭЛ ХОЁРЫН ХӨВГҮҮНИЙ АРВАН ТАВДУГААР БҮЛЭГ

Тэндээс бас урьдчилан авч ирвээс шидэт хүүр ийн өгүүлрүүн:

– Урьд цагт энэтхэгийн өрнө зүг дэх нэгэн хаанд Төгсбилигт хэмээх хөвгүүн буй ажгуу. Хан хөвгүүн хийгээд нэгэн түшмэлийн хөвгүүн хоёуланд нэжгээд хэсэг алтыг хувааж егөөд

– Та хоёр дундад энэтхэгийн очирт оронд одож үүгээр хүнс хийж, эрдмийг сайтар сурч мэргэн болж иртүгэй хэмээсэнд очирт оронд одоод, хоёр ламд тэр хоёр буяныг өөр өөр өргөөд, арван хоёр жил болтол сургуульд суугаад, түшмэлийн хөвгүүн нь хан хөвгүүнд,

Өдгөө бид харьсугай хэмээгээд, өөр өөрийн ламдаа өчвөөс лам нь зөвшөөрч харьж ирэхэд, газар хол, ус олон ядаж ухэхэд ойртоод хэвтэх цагт нэгэн хэрээ энрэн хэмээх нэгэн дуу гарваас түүнийг сонсмогц хан хөвгүүн

– Өдгөө бид хоёр явсугай, ус олдоно хэмээвээс түшмэлийн хөвгүүн

– Ус бидэнд хэрхэн олдох хэмээв.

Өдгөөх хон хэрээний дууг ухаас ийн өгүүлмүй. Тэндээс өмнө зүгт одвоос таван зуун алхмын тэнд, сэрүүн хийгээд амтат тунгалаг сайхан ус буй ажгуу. Өдгөө түүнийг үзээд сац амсья бид. Тэндээс хоёул таван зуун алхмын газарт одоод булаг усыг олж, хоёул тэр уснаас ууж ханаад уснаас авч одвоос түшмэлийн хөвгүүн

– Хаан бид хоёрт хүнс адилхан өгсөн бөлгөө. Энэ ийм мэргэн болов. Би үүний чинээ эс сурав хэмээн сэтгээд хан хөвгүүнд муу сэтгэл төрүүлэв. Энэ шөнө бид хоёр нэгэн ууланд гарч хоносугай. Талд хоновоос хулгайд эндэнэ бид хэмээгээд, нэгэн ойт ууланд авд одоод, хан хөвгүүнийг алахад хан хөвгүүн «абра шэгэ» хэмээн өгүүлэв. Тэндээс түшмэлийн хөвгүүн гэртээ харьж ойртоход, хаан түшмэлийг яг тэнд угтаж ирээд, хан хөвгүүн үгүйн тул

– Хан хөвгүүн хаана одов хэмээн асууваас хан хөвгүүн нь нөгчив хэмээв. Тэр хаан нь их гашуут болоод

– Олон зуун тоотон балгад хийгээд аугаа хүчин нь эзэн үгүй болов хэмээн энэлэн шаналан гашуудаж орд харшдаа харьж ирэв. Хаан нь

– Миний хөвгүүн үхвээс нэг гэрээс зарлиг болсон буй за хэмээн сэтгээд, түшмэлийн хөвгүүнээс асууваас, түшмэлийн хөвгүүн

Хатуу түргэн өвчин хүртсэний тул юун бээр олон эс өгүүлэв. Амин гарахдаа «абра шэгэ» хэмээн өгүүлэв гэв. Хаан нь

– Энэ үгэнд нэгэн утга буй за хэмээгээд, хамаг их улсад тунхаглаж банди, тарнич, төлгөч, оточ бүхнийг хурааж,

«Абра шэгэ» хэмээхийн утга нь юу вэ хэмээн асууваас, хамгаар эс мэдэж хан хөвгүүний үгийг

тайлан эс чадав.

– Өдгөө долоон хоногт судруудаа үзэж, түүнийг тайлж надад өгүүл. Хэрвээ нээж эс өгүүлвээс та бүхнийг нэгэн хотод оруулж ална хэмээн мянган ухаантныг нэгэн байшинд оруулваас зургаан хоног болтол эс олоод «Маргааш лав үхнэ» хэмээгээд зарим нь тэнгэр нарыг залбирав. «Зарим нь ураг садан эцэг эхээ дурдаж өгүүлэлдэв. Тэр дотроос нэгэн өчүүхэн тойн буруулж одоод нэгэн ойд нэгэн модны язгуурт далдалж сууваас, тэр модны үзүүрт нэгэн өчүүхэн хүүхэд уйлваас түүний эцэг нь

– Хөвгүүн чи бүү уйл. Маргааш энэ хаан мянган хүнийг ална. Тэдний махыг бид үл идвээс хэн идэх буй. Бас төдий болоод хүүхэд «Би өлснөм» хэмээн уйлваас эх нь,

– Хөвгүүн чи бүү уйл, Маргааш энэ хаан мянган хүнийг ална. Түүний мах цусыг биднээс бус хэн идэх хэмээвээс хөвгүүн нь

– Тэр мянган хүнийг юуны тул ална хэмээвээс, эцэг нь

– Абра шэгэ хэмээхийн утгыг эс мэдсэний тулд ална.

– Түүний утга юу вэ хэмээвээс эцэг нь

– Түүний утга хялбар буй хэмээгээд, зүрхтэй адил тэр нөхөр минь зузаан ойд хөтлөөд, жирс гэхийн зуур хүзүүг минь хөлөөр гижигдээд занданч хурц илдээр хүзүүг минь огтлов хэмээсэнд тэр үгсийг сонсонгуут өчүүхэн тойн хааны орд харшийг тэмцэж гүйгээд үүр гийхэд хаалганд хүрч дэлдэв. Хаалгачууд

– Чи юун хүн бэ хэмээвээс

Би ухаантны нөхөр бөлгөө. Намайг тэнд хүргэгтүн хэмээвээс дотор агсан нөхдөд нь хүргэв. Нөхдөдөө

– Түүний утгыг би номлосугай. Та бүхэн бүү зов хэмээгээд төдий бүгдийг хурааж асуух цагт, урьд ёсоор өгүүлвээс, түшмэлийн хөвгүүнд юун бээр үл өгүүл. Хөвгүүний минь ясыг зааж өгтүгэй хэмээн хөвгүүний ясыг авч суварга хийж, түшмэлийн хөвгүүнийг алаад, хөвгүүний эцэг түшмэлийг бууруулав. Зуун ухаант хуврагийг дээдлэн хүндлэв. Сайн амгалант хаан,

– Таван ухаант мэргэн болсон хааны тэр хөвгүүнийг алсан нь хайран хэмээвээс

– Заяагаа барсан хааны амнаас дуу гарав. Сарвад үл сууна би хэмээж огторгуйгаар нисэн одов.

ӨНГӨТ НАРАН ХАТНЫ АРВАН ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Бас мөрт одох ёсыг урьдчилан үйлдэж хүрээд шидэт хүүрийг үүрч ирсэнд, наран уртын тулд уйдаад

– Сайхан хуулийг өгүүл хэмээсэнд, хаан юу ч эс өгүүлэв. Хүүр,

– Чи өгүүлэх бөгөөс дохь, намайг өгүүл гэхүл гэхитүгэй хэмээсэнд, Сайн амгалант хаан гэхисэнд

– Эрт урьд цагт энэтхэгийн өмнөд зүгт Саран алдаршсан хэмээх нэгэн их хаан бөлгөө. Аугаа хүч хийгээд эд агуурс цогтойяа болсон, гурван мянга, таван зуун балгадыг эзлэгч бөлгөө. Төгс амгалант эх тэргүүтэн зуун найман хатантай бөлгөө. Төгс амгалант хатнаас нэгэн хөвгүүн төрөөд сац хатан нь нөгчив. Тэр хан хөвгүүнийг Наран саран хэмээн нэрийдэв. Тэр цагт хаан нь уйтгараа сэргээхийн тул дөрвөн аймаг цэргүүдийг авч цэцэрлэгт одох мөр дэх балгадын иргэд увсан тавьж, хаан нөхдийг үзэхээр ирсэнд, нэгэн балгадын дээр өнгө зүс сайт нэгэн сайхан гоо охиныг үзээд, хаан түүнийг наадах цэцэрлэгт авч ирэв. Жич бас орд харшдаа авч ирэв. Хамаг хатдаас цоллон хайрлаваас, тэр хатан нь муу язгууртын тул хаанд нэгэн зохисгүй ажгуу хэмээн бүгдээр санах учирт, тэр хааны нэгэн цэцэрлэгийн үндэсний хүрээг хадгалсан нэгэн хүний хүрээний дотор нэг гахай ороод сэндэлж гаргаваас, тэр хүн хааны засгаас айж нум сумыг бариад, тэр зэрлэг гахайг хөөж одвоос гүйцэхийн зуур нэгэн хүдэр ирвээс гахайг элдэхээ байж, хүдрийг алж, арьс заар хоёрыг авсугай» хэмээгээд хүдрийг хөөв. Түүнийг гүйцэхийн зуур нэгэн буга гүйвээс,

– Үүний мах нь их буй хэмээн түүнийг хөөв. Хөөсөөр нэгэн их ойд ортол хөөвөөс тэр ойн эхэнд нь мод өвс бүрдсэн сэтгэлд зохист нэгэн булаг үзэв. Түүнийг тойрон олон зүйл жимст ой мод бөлгөө. Тэр зохист булгийн дэргэд нэгэн хумхны ор ажгуу. Түүний дэргэд өчүүхэн нялх хүүхдийн хөлийн мөр ажгуу. Энд нэгэн хүн ажгуу» хэмээн сэтгэж, навчны дотор нуугдаж сууваас, маргааш эрт нэгэн сайхан үзэсгэлэнт охин гартаа хумх барьж ирээд, тэр булагт биеэ угаагаад булгийн дээрээс нэгэн хумх дүүрэн усыг аваад одоход тэр хүн охинд

– Би төөрсөн хүн бөлгөө. Надад зам зааж өгтүгэй хэмээсэнд, охин нь «зам үгүй» хэмээгээд зугтааж одвоос, охины мөрөөр хойноос одоход нэгэн ой модны язгуурт нэгэн өвсөн чачарын гөрмөл дотор нэгэн их хөгшин арш ажгуу. Тэр охин нь тэр аршид нэгэн саванд ус дүүргэж угаах усыг ергев. Бас тэр охин савыг бариад модны үзүүрт гарч жимсийг аваад, усаар угааж бас тэр аршид өргөв. Түүнээс арш дээж тавиад өөрөө зооглож үлдсэнээ охин тэр хүн хоёрт өгөв. Тэр охин нь өөрийн өвсөн гөрмөлд ороод бясалгал бясалгахыг үзэв. Төдий тэр хүн аршид

– Би гөрөөс хөөсөөр ирж энэ ойд ороод толгой эргэж замаа эс олов. Их арш надад замыг минь зааж өгөн соёрх хэмээн өчвөөс, нэгэн төдийхнөө юун бээр эс өгүүлээд хойно,

Чи их хилэнцэт хүн ажгуу. Чамд надад ирэх хэрэг үгүй бөлгөө. Миний ном бясалгахад саад зэтгэр бүү хий. Хүнд намайг тэнд гэж бүү хэл хэмээгээд, нэгэн хэсэг гүш өвсийг өгөв. Түүнийг барьж одвоос замаа үл эндүүрнэ. Араатан хор хүргэж үл чадна. Тэр хүн замд ороод

– Энэ охиныг миний хаанд хатан болговоос зохин хэмээн сэтгээд, харьж ирээд аршид

– Нэгэн гүш өвсийг гээвээс газартаа үл хүрнэ. Өдгөө нэгэн гүш өвсийг соёрхогтун хэмээн өчихөд, арш бас нэгэн гүш өвс соёрхов. Төдий тэр хүн гэртээ харьж ирээд нум сумаа тавиад хааны дэргэд одвоос хаалгач нь эс оруулваас тэр хүн дуу гаргаж бархирахад, хаан

– Энэ юу вэ хэмээн асуув.

Нэгэн гөрөөс хүн хаанд үг айлдах бөлгөө хэмээж байнамхэмээн өчвөөс хаан нь

– Саадгүй нааш илгээтүгэй, түүнийг. Бид гэрт суусан бөлгөө. Тэр ууланд одсон хүнд нэг үг буй ч буй заа. Төдий хааны дэргэд тэр хүн ирвэл хаан эхлэн хамаг хатдаар хамт нэгнээ суугаад

– Хүн үгээ өгүүл хэмээв.

Зуун хаалгыг хааваас нэгэн хаалгыг нээ юү? Зуун нүхийг бөглөж, нэгэн нүхийг нээмүү. Зуун булгийн угаалгыг тэвчиж тегс найман уянгат булгийг уугдах хэмээх дохиог өгүүлвээс хаан түүнийг мэдэж зуун найман хатнаа хариулаад нууж асууваас

– Бэрх үйлсийг чадагч нэгэн хөгшин аршид нэгэн залуу гоо охин буй ажгуу хэмээн урьдахийгаа дэлгэрэнгүй өгүүлвээс хаан баясан

– Түүнийг авах арга юу вэ? хэмээн зарлиг болов.

Газар хол одох бэрх боловч хаан нэгэн зааныг унагтун. Бид хоёр одвоос авья уу хэмээн өчив. Төдий хаан нь зааныг унаад тэр хүн хааны биеэс бариад, нэжгээд нэжгээд гүш өвсийг гартаа бариад одов. Урьд булагт хүрээд хааны зааныг тэр далд газарт авч одов. Заан нь булгийн дэргэд модны навчаар хучиж хэвтэхэд охин ирээд урьд ёсоор угааж хумхандаа ус аваад одохын зуур хаан

– Охин чи хэнийх вэ? Надад өгүүл гэхэд охин үл өгүүлэн зугтааж одов. Хаан түүний мөрөөр нэхэж одоод, аршид угаал усыг өргөөд, жимс тэргүүтнийг өргөвөөс урьд ёсоор дээж тавиад өөрөө зооглож, хишгээ хаан охин хоёрт өгөв. Төдий хаан ийн өчрүүн:

– Би гурван мянга таван зуун балгадын эзэн бөлгөө. Хатнаа охорч чамд ийн ечмүй. Үзэсгэлэнт сайхан охиноо надад нөхөр болохын тул, их арш баясах сэтгэлээр зөвшөөрч надад өгөн соёрх. Арш өгүүллрүүн,

– Энэ хүний охин бус. Нэгэн согооноос төрсөн бөлгөө. Өдгөө би увсанзын санваар өгсөн бөлгөө. Үүнийг чи бүү ав. Хүний үнэр үнэртвээс зүрх нь цочиж үхнэ. Хаан чамд тус үл болно. Үүний санваарыг бүү эвд хэмээн зарлиг болвоос, хаан:

Үүнийг надад өгтүгэй, эс өгвөөс би үл харина. Намайг эрэхээр олон улс ирвээс их аршийн тугдамд саад болохгүй гэж үү. Төдий арш охинд зарлиг болруун,

– Чи энэ ертөнцийн хаанд одтугай. Хэрэв эс одвоос миний бясалгалд гэм болно. Охин нь үл

ЗӨВШӨӨРӨН

- Би гөрөөснөөс төрсний тул ертөнцийн хүний үйлсийг үл чадна хэмээн өчвөөс хаан,
- Тийм бөгөөс нэгэн шинэ хот бэлдэж, түүний дотор суулгаваас ертөнцөд хаа нийлэх гэхэд арш
- Хаанаа, энэ охиныг тугдамыг нь үл тасалтугай хэмээвээс «зарлигийн ёсоор болтугай» хэмээгээд охиныг авсны хойно их арш охиноо олон зүйлээр сургаад, хаанд үзүүлэлгүй зуун найман болор эрихийг өгөв.

Энэ эрихийг чи өөрөөсөө бусад хэнд ч бүү үзүүл, биеийн чинь сахиулс буй хэмээн захирав. Наадан тойроход үл алгасан, буяны үйлсэд хичээтүгэй хэмээгээд хаанд өгөв. Төдий арш нь үдээд хойноос нь харваас охин нь хойш харалгүй одсонд, ертөнцийн бага нь ихдээд, нааш намайг эс харав хэмээгээд үдсэндээ гомдож уурлаад харьж ирэв. Тэндээс хаан шинэ хот барьсны дотор тэр хатныг суулгаад нэрийг нь Өнгөт наран хатан хэмээн нэрийдэв. Төдий муу язгуурт хатан нь хаанд өөрөө доройтох (гологдох) тул, муу сэтгэл үүсгээд

- Өнгөт наран хатныг хэрхэж бууруулсугай хэмээгээд, бүжигч дууч Ямагандай нэрт охинд
- . – Чи өдөр бүр хааны дэргэд очиж бүжиг наадагч бөлгөө. Хаанд, Өнгөт наран хатныг үзье хэмээн өчиж хааны юу өгүүлснийг чи надад өгүүлсүгэй хэмээвээс

Ямагандай охин хааны дэргэд одоод бүжиг наадам тэргүүтнийг наадаж өргөөд хаандаа

- Аяа, их хаан чиний сайн хатанд би золгосугай хэмээн өчвөөс
- Чи золгож үл болно хэмээв.

Дахиж өчвөөс, бус хүнийг авч бүү од, ганцаар золго хэмээв. Ямагандай одоод хатанд золгож бүжиглэх дуулах тэргүүтэн наадмыг үзүүлээд, үг өдөн, яриа үүсгэж хуурч аргадах мэт олон үгсийг өгүүлж ирээд, муу язгуурт хатанд дэлгэрэнгүй өгүүлвээс, муу язгуурт хатан нь ертөнц дэх муу эд, муу бузар үнэртнийг Ямагандайгаар өгч илгээж

Тэр хатны дэргэд үүгээр утаа тавь гэв. Түүгээр утаа тавиад гэм эс болсонд муу язгуурт хатанд

- Утаа тавиваас гэм эс болов. Түүгээр бузарлахгүй ажгуу хэмээсэнд муу язгуурт хатан,

Түүгээр үл бузарлах бөгөөс тэр хатны биед нэгэн сахиулс буй ажгуу. Түүнийг чи аргалж үзээд над өгүүл хэмээв. Ямагандай хатны дэргэд бас ирээд

- Аяа, язгууртны охин чамд нэгэн сайн сахиулс буй бөлгөө. Түүнийгээ надад үзүүлтүгэй хэмээвээс хатан

– Надад тийм юм үгүй хэмээв. Бас давтан өчвөөс, хойно аргагүй болж, эцэг аршийн захиргаанаас давж зуун наймаар болор эрихээ Ямагандайд үзүүлэв. Ямагандай түүнийг үзээд сац толгой дээр тавиад, хүзүүндээ зүүгээд, өвөртөө дарж, зүрхээ адислаад, эрихний их бага

оосор тоог нь бүртгээд хатанд барив. Ямагандай нааш ирээд муу язгуурт хатанд, «тийм сахиулс буй ажгуу» хэмээн өгүүлэв.

Түүнд арга нь юу вэ? хэмээвээс Ямагандай худалдааны хуралд одоод хатны тэр болор эрихний их бага олон цөөхний тоо хэлхээ, оосор ямар бөгөөс түүнтэй адилыг өвөртөө хийж авч одоод, Өнгөт наран хатны дэргэд хүрч наадан тойрох тэргүүтнийг хатанд өргөөд

– Энэ шөнө би сайхан зүүд зүүдэллээ. Урьд өдөр чиний тэр шүтээнд золгосны хүч болой. Өдгөө хүнд үзүүлэлгүй би бас золгосугай хэмээн өчвөөс, Өнгөт наран хатан шүтээн дотроос шил эрихийг аваад Ямагандайд өгөхөд, түүнийг аваад толгой дээрээ тавьж, хоёр хацартаа хүргээд хоолойдоо хүргэж өвөртөө хийж, зүрхэндээ хүргэж тавиад нөгөө эрихийг гарган тоолоод «бүрэн буй» хэмээж хатанд өргөв. Хатан мэдэлгүй аваад, шүтээний дотор тавив. Түүний маргааш нь бас одож хамаг муу утааг тавиваас хатан согтуурч наран ургахын хойно болтол үхэдхийв. Түүний хойно эрхтэнд бузар болсны тул, нүд нь хараагүй, чих нь дүлий болоод, хааны ухаан бас бузар болов. Нэгэн учирт хааны Төгс хүчит зааны хүзүүг илдээр огтлоод, зааны тэргүүнийг шинэ хотын үүдэнд тавив. Зааны цусыг Өнгөт наран хатны аманд түрхэв. Маргааш наран мандахад хаан нойрноос сэрж еөд болоод, зааныг алсныг үзээд, Өнгөт наран хатны дэргэд одвоос аман дахь цусыг үзэж дэргэдэх илдийг хараад

– Үүнийг би уулнаас олсон бөлгөө. Энэ шулмас уягуурт эхнэр ажгуу. Миний зүрх мэт хайрлах зааныг алав. Өдгөө би үүнийг алсугай хэмээн сэтгээд илд далайваас, тэр хаанд нэгэн үг өгүүлэгч тоть буй ажгуу. Тэр хааны дэргэд нисэж ирээд

– Хаан, хаан. Хамаг үйлсийг ухаж үйлд, ухалгүй үйлийг үйлдвээс, мал адуулагч хийгээд хэрээний домог мэт гэхэд далайсан илдээ хураагаад

– Тэр юу вэ? чи хэл хэмээвээс тоть

– Хаан чи сайтар сонс. Эрт урьд үхэр хариулагч нэгэн хүн олон үхрээ алдаад эрж эс олоод, нэгэн халуун цөлд учирч усыг эс олоод, ус эрвээс олон ядаж явахад, нэгэн хадны дээр нэгэн зандан модны гишүүнээс ус дусаж байхыг үзээд, нэгэн модны навчийг хумьж тосоод уухын зуур нэгэн хэрээ нисэж ирээд далавчаар усыг дэлдээд асгаж орхив. Гурван үе тосож уухын төдийхнөө хэрээ далавчаар дэлдэж асгав. Хойно нэгэн бэрээ барьж байгаад бас усыг тосвоос, бас хэрээ ирж далавчаар дэлдэхийн зуур хэрээг модоор цохиж алав. Төдий тэр хадны дээр авирч гарваас, нэгэн их хорт могой халуунд чилж зандан модыг ороож могойн тэргүүн нь модны үзүүр навчинд байгаад, сүүлнээс хорт ус дуссан ажгуу. Төдий их туст хэрээгээ алав би хэмээн гомдлоо. Аяа, хаан чиний энэ үйл түүнтэй адил белгее хэмээвээс, төдий хаан нь их зааны мах цусыг далд оруулаад хот гэрээ ариутгахын төдийхнөө Өнгөт наран хатан сэрэв. Түүний хойно Яматандай Энэ хатанд гэм эс болов хэмээн дахин дэргэд нь одож золгов. Түүний хойд шөнө тэр хааны сүргийн манлай нэгэн хүлэг морийг Ямагандай алаад толгойг нь огтолж Өнгөт наран хатны дэргэд тавиад цусыг нь аманд сүрчив. Маргааш хаан сэрээд мориныхоо ясыг үзэж илдээ аваад хатнаа цавчихын төдийхнөө бас тоть нисэж ирээд хаанд шүлэглэж өгүүлрүүн:

Аяа хаан, хамаг үйлсийг бэлгэдэж мэд. Бэлгэдэлгүй эмгэн хийгээд хулганын домог мэт болуузай! Хаан илдээ тавиад түүний учрыг үтэр хэл хэмээв. Тоть өгүүлрүүн:

– Эрт урьд нэгэн эмгэнд нэгэн хөвгүүн бөлгөө. Тэр хөвгүүнээ нэгэн хулганад сахиулаад өөрөө гал усыг авахаар одогч бөлгөө. Нэгэн өдөр хөвгүүнээ нойрсуулаад ус авахаар явж, усыг авч ирэхэд хулгана нь амандаа цусыг наалдуулж эмгэний өмнөөс одоод дуу гаргаж, нааш цааш гүйвээс эмгэн нь, миний хөвгүүнийг алж идэв үү хэмээгээд хилэгнэж хулганын толгойг шанагаар бялц дэлдэж алаад гэртээ ирвээс хөвгүүний тэргүүн дээр ирсэн хорт могойг хулгана алж хэсэг хэсэг болгосон ажгуу. Түүнийг үзээд эмгэн гэмшиж ихэд гутав хэмээн өгүүлвээс, хаан түүнийг сонсоод

Туст юугаан алсан ажгуу хэмээн, хүлэг морины мах ясыг нууж далд болгожээ. Бас Ямагандай түүний хойд шөнө хааны ганц хан хөвгүүн Наран саран хэмээхийг алаад, хүүрийг нь Өнгөт наран хатны дэргэд тавиад, цусыг аманд сүрчиж орхив. Түүний маргааш хаан сэрээд хан хөвгүүний хүүрийг үзээд, хатныхаа аман дахь цусыг хараад хүлцэн ядаж илдээ гаргаж хатнаа цавчихыг завдвас, тоть ирээд

Аяа хаанаа, хамаг үйлийг бэлгэдэж мэд. Бэлгэдэлгүй үйлдвээс, хаан хийгээд тоть хоёртой адил буй. Хаан уурлаж, «муу тоть олон үгсийг бүү өгүүл хэмээгээд илдээ ширвэвээс тотийн тэргүүн тасарч тоть үхэв. Өнгөт наран хатныг алсугай хэмээгээд хувцсыг тайлахад, хатны биенд нь сайн үлгэр бэлгэ төгссөний тул гар хүрч алан эс чадаад хамаг түшмэдээ тунхаглаж ирүүлээд:

– Энэ муу шулмас эм миний хан орныг барих ганц хөвгүүнийг минь алав. Би үүнийг өдгөө алсугай хэмээн зарлиг болвоос түшмэд юу ч үл өгүүлэхэд түшмэдийн дотроос Эрхэт заяа хэмээх түшмэл хаанд ийн өчрүүн:

Энэ хатныг хаан чи алваас зохисгүй болно. Хатан хүн хэдийбээр гэмтэй ч гэсэн, хаан нь еөрөө алсныг урьд эс сонслоо. Тним болохоор яргачны гарт өгч, үхээрийн оронд хөтөлж одоод алваас зохино хэмээвээс, тэр үгийг зөвшөөрч, их хэнгэрэг дэлдээд, хамаг их улсыг хурааж Өнгөт наран хатны хувцсыг тайлж аваад, гурван яргачны гарт өгөв. Өргөст модоор занчиж хөөсөөр, хотын гадна гаргаж үхээрийн оронд аваачин үүнийг алтугай» хэмээн захирав. Үхээрт авч одоод, гурван яргачны нэг нь

Энэ хатныг та хоёр ал, алсны шанг бид гуравт өгвөөс миний хувийг та хоёр ав хэмээв. Нөгөө хоёр авч одоод хоёулын нэг нь: Би үүнд гар хүрч үл болно. Мнний хувийг чи ав, бн суусугай хэмээгээд, нэгэн яргачиндаа өгөв. Нэгэн яргачин авч одоод, гар хүрч ядаад үл алахад Өнгөт наран хатан

– Та намайг алагтун. Өдгөө намайг эс алваас таныг хаан засаглана хэмээв. Өнгөт наран хатан төрөл тутамд амь нядлахыг тэвчээд самиди агуулсны хүчээр яргачин гар хүрэн эс чадаад, дөрвөн мөчийг тэлж гадас шааж тавиад, араатан идтүгэй хэмээвээс, тэр шөнө хамаг араатан тэнд хурж ирээд, хатныг идэн ядаж, хүйтэн болсонд хатныг тойрч, хүрээлэн байхыг яргачин үзэв. Маргааш нь гурван яргачин хатны дэргэд ирээд

– Чамайг араатан бүхэн амаа хүргэж, үл ядан бөгөөтөл, бид гурвуул хэрхэж гар хүрэн алж чадах билээ. Өдгөө бид чамайг алав хэмээсүгэй. Чи нэгэн хол газарт өөд бологтун хэмээн өчвөөс, тэр гурвууланд мөнх бусын номыг номлож үзүүлээд одов. Тэр гурван яргачин нааш ирээд

– Өнгөт наран хатныг алав бид хэмээн тунхаглав. Тэндээс Өнгөт наран хатан урьдын эцэг арш юугаа зорьж одвоос, аршийн өвсөн гөрмөл нь эвдрээд жимс мод нь хатаад, арш хүүрээ тавилгүй нөгчиж одсон ажгуу. Нэгэн хувцасны хэсэг өлгөж тавьснаас бус юу ч үгүй бөлгөө. Хатан тэр хувцасны заримыг үзээд маш энэлж гацуудав. Урьд аршийн сургаал тангаргаас давсны тул энэ мэт зовов хэмээгээд тэр хувцсанд олонтаа мөргөж бөхийн наманчлав. Хэд хоносны хойно нэгэн шөнө зүүдэнд нэгэн цагаан хүн ирээд

– Чи тангаргаа эвдсэний тул энэ мэт элдэв зовлонг үзэв. Өдгөө тойн болж ёогинийн дүрээр хамаг амьтанд номын өглөгийг өгтүгэй. Бацаг шагшабадыг сахиулваас, үүнээс хойд төрөлдөө эцэг аршдаа золгоно хэмээв. Төдий хамаг зүгийн оронд одоод номыг үзүүлвээс хамгаар биширч өргөн тахиад ёогини хэмээн алдаршжээ. Явсаар урьдын хааны орд харшийн ойр хүрээд, хамаг бүгдэд зургаан үсгийн удиргуулсан өгөөд өөд болоход, нэгэн өдөр урьдын Ямагандай ирээд хүнээс нууж ёогинид ийн өчрүүн:

Энэ шөнө хамаг хүн унтсаны хойно миний муу гэрт өөд бологтун хэмээн залав. Төдий шөнө өөд болбоос гэртээ ширээ засаж суулгаад идээнд цав цацаж өргөв. Наманчлахдаа ийн өгүүлэв.

Энэ хааны хатан Өнгөт наран хэмээхийг би алуулав. Заан, морь хийтээд хааны Наран саран хэмээх хөвгүүнийг би алав. Үнэнийг өгүүлэгч тоть тэргүүтнийг алсан хилэнц юугаа наманчилмуй. Хилэнцүүд надад буй бөлгөө. Ёогини эх тэд бүхнийгээ чиний өмнө гэмшиж наманчилсугай хэмээн гэмшиж наманчлав. Тэгээд

Аяа, надад арван таван, битүүн, шинийн найман гурван өдөрт сахихын санваарыг өгөн соёрх хэмээн өчвөөс, ёогини

– Чиний хилэнц маш их бөлгөө. Өдгөө бас наманчилтугай хэмээвээс

Тийн хийсүгэй. Маргааш надад бацаг өгөн соёрх хэмээн өчив. Маргааш өдөр Ямагандайн залсан балгадад еөд болох мөр дээр, хааны их түшмэл, Эрхэт заяа хэмээх олон нөхдөөр хүрээлүүлж одохын тедийхнөө Ёогинийг үзээд ийн

– Энэ Ёогини манай хааны Өнгөт наран хатантай адил бөлгөө хэмээгээд одохоо түдэж нааш ирээд

– Ёогини эх ээ, чи манай хааны урьдын Өнгөт наран хатантай адил бөлгөө. Чи мөн үү? Надад нуулгүй өгүүлэгтүн хэмээвээс,

Би тэр бус. Тийм боловч мөн хэмээн намайг хүнд бүү өгүүл хэмээгээд Эрхэт заяа түшмэлийг ам алдуулав. Түшмэл

Тэр хатны баруун хацарт удвал цэцгийн бэлгэ буй бөллөө. Чамд тэр бэлгэ буй хэмээвээс Ёогини

Тийн шинжлэх бөгөөс маргааш шөнө дөл болоход Ямагандайн балгадад одох бөлгөө. Түүний наманчлахыг гэтэж сонсогтун хэмээн зарлиг болбоос түшмэл хааны дэргэд одоод, хааныг авч

ирж Ямагандайн хаалганд чагнахад Ямагандай ёгинид ширээ засаж суулгаад эд идээ цав цацаж өргөөд мөргөж

Аяа, би муу язгуурт хатны тулд хааны төрийг хоосон болтол хилэнц үйлдэв. Муу үнэртнээр угаж ядаад Өнгөт наран хатны шил эрихийг аргалан хулгайлж аваад, түүнийг авсны хойно хаан хатан хоёр хирт түйтэж согтуурсанд заан, морь, хөвгүүн тэргүүтнийг алсан минь ийм бөлгөө. Өдгөө би Өнгөт наран хатны шил эрихийг чамд өргөсүгэй хэмээгээд ергөв.

Төдий хаан ихэд уурлаж хүлцэн ядаад нлдээ гаргаж Ямагандайг цавчиж орхиод, хэсэг хэсэг огтчив. Тэндээс хаан урьд хийсэндээ гомдож

Өдгөө миний хатан болтугай хэмээн өчвөөс,

Ертенцийн эцэс барагдан шантарч ийм болох уу хэмээгээд эс болов. Хаан орд харшид харьж ирээд, муу язгуурт хатнаа бас алаад, төдий хан орноо тэвчиж номд оров. Нэгэн насандаа бодь хутгийг олов хэмээн алдаршив хэмээвээс

– Ямагандай тийм их хилэнцэт ажгуу хэмээн дуу гарваас

– Заяа нь барагдсан хааны амнаас дуу гарав. Сарвад үл сууна би хэмээгээд огторгуйд нисэж одов.

ӨВГӨН ЭМГЭН ХОЁРЫН АРВАН ДОЛДУГААР БҮЛЭГ

Тэндээс одох ёсыг урьдах мэт үйлдэж сэрүүн үхээрийн ойд шидэт хүүрийг авахаар хүрээд үүрч ирэхэд бас хүүр энэ үлгэрийг өгүүлрүүн:

Бас урьд цагт Энэтхэгийн умар зүг дэх Таван мянга хэмээх балгадад, өвгөн эмгэн хоёрт хөвгүүнгүй, есөн үнээнээс өөр эд үгүй ажгуу. Өвгөн нь маханд дуртай тул төрсөн тугалуудыг алж иддэг байжээ. Эмгэн нь сүүгий нь сааж тос аваад идэгч бөлгөө. Нэгэн өдөр өвгөн нь есөн үнээнийхээ нэгийг алж махыг идсүгэй. Найм ес хэмээхийн тоонд юуны ялгаа байх вэ? Бус хүмүүс үзээд найм есөн үхэр гэнэ биз гээд нэгэн үнээгээ алж идэв. Түүний махыг идэж бараад, бас нэгэн үнээгээ алав. Долоо наймд юуны ялгаа хэмээгээд нэгийг алж идэв. Бас зургаа долоод юуны ялгаа хэмээгээд нэгэн үнээнээс бусдыг нь үлдээлгүй алж идэв. Ганц үнээ үлдсэнд эмгэн үл хүлцэн, хаа л явна, үнээгээ хөтөлж явах бөлгөө. Нэгэн учирт өвгөн нь согтож унтан хэвтсэнд, үнээгээ гэртээ орхиод ус авахаар одсоны хойно, өвгөн босоод үнээгээ алваас, эмгэн ус авч ирэхдээ үнээгээ алсныг мэдэж уйлан гашуудаад

– Энэ ертөнцөд амиа юугаар тэжээнэм. Ганц үнээ миний хувь бөлгөө. Чи алж идэв хэмээгээд буруулан дутаахад эмгэндээ үнээний хөхийг огтлоод өмнө нь орхиж өгвөөс эмгэн хөхийг аваад гашуудаж, элчилгүй хол газар одоод нэгэн хадны хонгилд хүрч гурван эрдэнэ хийгээд тэнгэр газар, газрын эзэд бүгдэд үнэн үгсийг өгүүлж, ийн залбирав.

Ертөнцийн идээний хувийг өвгөн таслав. Өдгөө амь зуух эд идээний хувийг гурван эрдэнэ хийгээд тэнгэр газар бүхий бээр надад өгөн соёрх хэмээгээд үнээний дэлэнгээр хадыг дэлдвээс, дэлэнг нааш авч ядаад, сааваас сүү гарчээ. Тэр сүүг зайлж тос авбаас тос нь их болов. Нэгэн учирт өвгөн минь надад үүнийг өгөв хэмээгээд нэгэн тулам тосыг авч одоод байшингийн дээр гарч дээд нүхээр харж үзвээс, өвгөн нэгэн модон халбагаар үнсийг утгаж аягандаа хийж

– Үүнийг энэ өдөр идсүгэй, үүнийг маргааш идсүгэй хэмээн сууж байв. Байшингийн ханзны дээрээс туламтай тосоо орхиод зугтаан одоос өвгөн

– Үүнийг надад тэнгэр газар хэн өгөв. Ачит эмгэн минь өгсөн бөлгөө. Энэ шөнө цас орвоос мөрөөр нь одсугай хэмээсэнд тэр шөнө цас ормогц хойноос нь мөрөөр одоод, хадны хонгилд хүрч эмгэний хураасан их тосыг үзээд, эрхгүйеэ хадан дахь дэлэнг үзээд очиж хутгаар огтолж идэв. Түүний хойно эмгэн гашуудаж зугтаан одсоны хойно өвгөн нь эмгэний тосыг үүрч гэртээ авч харив. Эмгэн зугтааж явсаар нэгэн их хүний хүршгүй цэнгэлд хүрвээс, нэгэн хэсэг марал ажгуу. Тэр марлын дэргэд эмгэн очиход, үл дутаан, хамар амнаас нь бариваас үл хөдлөн, төдий хөхийг сааж тосыг ихэд авав. Нэгэн төдий болоод, эмгэн нь нэгэн тулам тосыг аваад өвгөндөө бас одоод сэмээрхэн харж үзвээс бас үнсийг халбагаар, маргааш нөгөөдрийн хувь хэмээн хэмжиж байхыг үзээд, байшингийн цонхоор туламтай тосоо орхиод, дутааж одов. Тэр шөнө цас орсонд мөрөөр нь нэхэж хойноос одоод, марал саасан газарт хүрэв. Тэнд хүрмэгц тэр марлыг хутгалж алав. Бас эмгэн нь энэлэн шаналан зугтааж одоод, нэгэн их уулын оройд, нэгэн хадны хонгилд хүрвээс арьс махаар дүүрсэн ажгуу. Тэр махнаас өөрийн чинээгээр идээд, далдалж суух газар олон ядаж, дэвссэн өвсөн дотор орж хэвтэв. Тэр хадны хөндий нь хамаг араатны чуулах хөндий бөлгөө. Туулай идэшлэсний хойно эмгэн орсныг эс

үзжээ. Төдий бүгд чуулсны хойно, туулайн доорх өвс хөдөлвөөс, туулай

Авгай барс, миний доор нэгэн юм гүвэгнэж хөдөлнө. Энэ юу вэ? Хэмээвээс барс

Энд юу байгаа аж. Чи гэр сахисан бус уу, маргааш үүр цайлгаж үзье хэмээв. Үүр цайсны хойно өвсийг татаж үзвээс, өвсний доорх эмгэнийг үзмэгц, барс уурлаад эмгэнийг залгиж орхив. Төдий туулай нь

– Энэ эмгэнийг эс залгиваас манай гэрийн сахиул болговол сайн биш үү. Үүнийг залгиснаар юуны тус хэмээвээс, тэр үгийг зөвшөөрч барс нь эмгэнийг бөөлжиж гаргав. Эмгэн амьд гарсан тул, тэр хадны хөндийд хэн ирсэн ч бүү халгаагтун хэмээн захирч суулгав. Төдий болоод нэгэн учирт эмгэн нь гөрөөсний хөл мах аваад өвгөндөө урьд ёсоор одож, байшингийн дээрээс харж үзвээс өвгөн урьд ёсоор халбагаар үнс хэмжиж байна. Эмгэн хөл махыг цонхоор орхиод бас зугтаав.

Үүнийг надад тэнгэр газар хэн өгөв? Ачит эмгэн минь өгсөн буюу хэмээгээд, тэр шөнө цас орсонд эмгэний мөрөөр одвоос хадны хөндийд хүрэв. Төдий эмгэн өвгөнөө зэмлэв.

– Чи энд юунд ирэв. Энд араатны цуглах орон бөлгөө. Бид хоёрыг лав иднэ хэмээвээс өвгөн нь

– Чамайг эс идэх бөгөөтөл намайг юунд идэх вэ? Хэмээн эс болсонд өвгөнийг өвсний доор нууж тавив. Төдий араатан тэр шөнө тэнд хүрж ирээд хэвтэхэд туулай

– Авгай барс, миний доор нэгэн юм хэвтнэм. Чи үз хэмээвээс, Энд юу байгаа аж. Маргааш үзье хэмээв. Төдий бас хөдөлвөөс, туулай урьд ёсоор өгүүлсэнд барс бас, үүр цайлгаж үзье хэмээгээд үүр цайсны хойно үзвээс өвгөн буй ажгуу. Өвгөнийг хараад араатан бүхэн зөвшиж, үүнээс уламжилж олон хүн ирээд манд хор хүргэнэ хэмээн өвгөн эмгэн хоёрыг идээд өөр өөрийнхөө таалалт газар тархаж одов хэмээвээс төдий Сайн амгалант хаан, муу нөхрийг огоот эс тэвчвээс эмгэнийг хорлуулав уу хэмээн дуу гарваас

Заяагаа барсан хааны амнаас дуу гарав. Сарвад үл сууна би хэмээн огторгуйгаар нисэж одов.

БАЯН ХҮНИЙ ХӨВГҮҮНИЙ АРВАН НАЙМДУГААР БҮЛЭГ

Тэндээс одох ёсыг урьдах мэт үйлдэж, Сэрүүн үхээрийн ойд шидэт хүүрийг авахаар хүрээд, үүрч ирэхэд бас хүүр энэ үлгэр өгүүллүүн:

Бас эрт урьд цагт Энэтхэгийн өмнө зүгт нэгэн баян хүнд нэгэн тэнэг хөвгүүн бөлгөө. Эцэг эх хоёр нь үхэв. Эд таваартай болоод, сайн эхнэрт бөлгөө. Тэр хөвгүүн нь их мунхгийн тул гадагш үл гарна. Бүсээ бүсэлдэггүй, хэзээ ч гэрээс үл гарагч бөлгөө. Нэгэн учирт тэнд нэгэн зүгээс олон худалдаачин ирвээс, эхнэр нь нэгэн гуталт хэмээх овогт худалдаачны харьсны хойно тэр талд тасын нэгэн бүхэл өдийг орхиод, гэртээ харьж ирээд эрдээ ирж өгүүллүүн:

– Чи худалдааг эс мэдвээс, гадагш дотогш орж гарч явбаас эд юунд үл олдох. Эр хүнд олдох олз нь хээр буй. Эцэг эхийн энэ зөөш барагдваас юугаар амиа зуух буй. Гадагш гарч энэ талд одогтун хэмээвээс, эр нь тэр үгээр гадагш гарваас хоёр жигүүрийг олоод ихэд баясаад гэртээ авч ирээд эмдээ:

– Чннийх үнэн бөлгөө. Би үүнийг олж ирэв. Маргаашаас би худалдаа хийхээр одсугай. Надад хүнс идээг сайтар өгтүгэй хэмээвээс, эхнэр

– Үүнд нэг их юм орохгүй бөлгөө хэмээгээд, нэгэн илжгэнд тутаргыг ачиж, өөрт нь хүнс өгөөд тутаргаа худалд гэж илрээв. Маргааш эрт эр нь илжгийг авч одов. Нэгэн их талын захад хүрэхийн тэнд хулгай дээрэм явах нэгэн хавцгай хаданд хүрээд, хадны хөндийн адаг уулзварт илжгээ орхиод хөндийн эхэнд нэгэн хаданд авчирч гараад хүнсээ идэж суув. Тэгтэл нэгэн олон худалдаачин ирээд хөндий хадны эхэнд эд бараагаа хураагаад адаг уулзварт худалдаач суугаад, бүрээгээ дээрэм хулгайгаас айж хөндий хадны эхэнд тавьсан бөлгөө. Төдий тэнэг хүн хүнсээ идэж цадаад унгас алдахад бөгсөнд нь бүрээний ам таарч, бүрээ чанга дуугарав. Худалдаачид «дайсан хүрч ирэв» хэмээгээд эд агуурсаа хаяад зугтааж одов. Маргааш эрт буугаад нэгээхэн ч хүнгүйг мэдэж, эд агуурс бүхнийг ачаад, гэртээ авч харьж ирэв. Төдий улс бүгдээр гайхаж,

– Энэ ийм их хүчит бөлгөө. Өдий дайсныг дараад олзыг нь их авав хэмээлджээ. Эм нь:

– Үүнд энэ мэт авахын хүчин үгүй бөлгөө. Энэ хэрхэж авав. Үүнийг нэгэн аргаар ухсугай хэмээн сэтгэх зуур эр нь:

– Өдгөө би гөрөөлөхөөр явна хэмээв. Эм нь

– Одох бөгөөс Чи муу хүнд бүү золго хэмээвээс, Надад үл чадагдах хэн ч үгүй буй за хэмээв. Эхнэр нь Чамаас үлэмж хүчит Сүръяа баатар хэмээх буй бөлгөө. Түүнийг чи яаж ч чадахгүй. Чамайг тэр ална гэсэнд

– Надад гайгүй хэмээгээд нэгэн сайн морийг унаж одов. Түүний хойно эм нь нэгэн сайн морийг унаад эр хүний хувцсыг өмсөж, нэгэн илдийг зүүж эрдээ үзүүлэлгүй тойрч урьд одов. Төдий болоод нэгэн их талд тааралдаж эм юүгээ үл танин дутааваас, эм нь хойноос нь хөөж бариад, дуу гаралгүй илдээ гаргаж далайгаад айлгасанд, саадаг нум хийгээд морио өгөв. Эм нь мориноосоо бууж ирээд эрээ унаж хэвтэж элджээ.

Аяа, чи намайг бүү ал. Саадаг нум хийгээд морийг минь ав хэмээн олонтаа залбирав.

Тийм бөгөөс миний аланд амаа хүргэ. Би чамайг тавьсу хэмээвээс

Чиний юу өгүүлснээр болсугай хэмээгээд, эм нь өмдөө тайлаад алаа үнсүүлээд тавив. Эм саадгийг бүслээд морийг унаваас эр нь

—Чи Сүрьяа баатар хэмээгч мөн буюу хэмээн асуусанд эм нь

Би мөн хэмээгээд харьж одов. Эр нь хойноос нь шөнө хүрч ирэв. Эм нь

Саадаг нум морь чинь аль вэ хэмээвээс,

Энэ өдөр Сүрьяа баатартай учраад өдөржингөө тэмцэлдэн хүч мөхөсдсөний тул, саадаг морь нумыг тэр аван одов гэв. Төдий эхнэр нь идээ тариа хуурч өгөөд,

Та хоёр хэрхэж алалдсанаа надад бүрнээр өгүүлэгтүн хэмээвээс цадсаны хойно,

Сахалгүйгээс биш чиний эцэгтэй адил. Бас Сүрьяа баатар хэмээгч тэр хүн нь хоёр нууц оронтой бус буй за гэхэд эм нь инээд алдав хэмээсэнд Сайн амгалант хаан нь

– Тэр цагт эм эрийн ялгалыг үл мэдэх хүн буй ажгуу хэмээвээс,

Заяагаа барсан хааны амнаас дуу гарав. Сарвад үл сууна би хэмээж, огторгуйгаар нисэн одов.

САНАГБАГИЙН ХӨВГҮҮНИЙ АРВАН ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Тэндээс одох ёсыг урьдах мэт үйлдэж, Сэрүүн үхээрийн ойд шидэт хүүрийг авахаар хүрээд үүрч ирэхэд бас энэ үлгэрийг өгүүлрүүн:

Эрт урьд цагт Энэтхэгийн умар зүгийн нэгэн балгадад, Санагаба эцэг хөвгүүн хоёул бөлгөө. Эд тавааргүйн тулд мод худалдаж амиа тэжээх бөлгөө. Нэгэн удаа их уулын үзүүрээс модыг үүрч нэгэн шугуй модны дотор хүрвээс, тэр шугуйн дотор нэгэн хэсэг мод гүн зүлгэнд амарч суух учирт эцэг Санагаба нь хөвгүүндээ

– Би энэ орон дахь Санагаба нарын эрхэм бөгөөтөл, эд тавааргүй болов. Хэрэв намайг үхвээс миний ясыг энэ газарт авчирч баригтун. Миний үгээгүй ядуу болсон нь эцгийнхээ ясыг муу газар барьсны тул ийм болов. Миний ясыг энд бариваас чамд буян хишиг их болно. Ертөнцөд үнэнхүү эх буй за. Үнэмлэхүйд ач үр үнэн. Януухад (наашлахад) газар үнэн. Миний ясыг энд бариваас чи хааны хөвгүүний чинээт аугаа хүчит болно гэв.

– Төдий модоо худалдахаар одох учирт, тэр цагт хөвгүүн нь эцгийнхээ эрдмийг заалгаж нэгээхнийг ч эс сураад өрмөг нэхэгч болсон бөлгөө. Нэгэн үе түлээ түүхээр одсоны хойно эцэг нь үхжээ. Эцгийнхээ ясыг үүрч урьд заасан газар аван одож тавив. Эцгийнхээ судруудыг үл мэдэхийн тулд тэр балгадын өрмөгийг нэхээд амиа тэжээв. Төдий нэгэн үе нэгэн уулын тэр этгээдийн балгадад одоод өрмөгийг нэхэж үлдсэн утсаа хураагаад нааш харьж ирэх мөр дээр утсаа залгаж ой дотор цэмбэ нэхэж суухад өлсөж умдаасаад нэгэн ус уусугай хэмээхийн зуур, нэгэн болжмор ирээд, өрмөг нэхэх ширээн дээр суусныг өрмөг нэхэх модоор цохиж алаад, шарж идэхдээ урьд эцгийнхээ өгүүлсэн газрыг санаад, «энэ ясыг тавиваас чи баян болно хэмээсэн худал ажгуу. Өдгөө энэ өрмөг нэхэх нь ертөнцөд доордсын үйлс бөлгөө. Энэ өдөр өрмөг нэхэхээ орхисугай» хэмээн, нэхэх ширээгээ түлээд «энэтхэгийн хааны охиныг гуйж аваад хүргэн болсугай» хэмээн хааны харшид одоход өнө болсны хойно хааны харшийн ойр нэгэн ууланд хааны хотоос нэгэн гарьд шувуу хэрэг хийж, тэр ууланд гаргасан бөлгөө. Тэр хэргийн дором идээд гарьдад уясан хив торгыг өвөр түрийдээ хийгээд хааны харшид одоод, «хаалгаа тайл» хэмээвээс хаалгачин нь эс тайлсанд, хааны засгийн их хөөргийг дэлдвээс хаан,

– Энэ юу вэ хэмээн асуусанд, хаалгач нь

– Нэгэн муу хүн хаанд үг айлтгана гэж байна. Хаан нь

Тэр хүнийг саадгүй нааш илгээтүгэй хэмээн зарлиг болбоос төдий хааны дэргэд илгээв. Хаан

– Хүн чи юуны тулд ирэв. Хэрэг чинь юу вэ? хэмээвээс тэр хүн

Хааны охиныг гуйж аваад хүргэн нь болохоор ирлээ гэв. Хааны дэргэдэх түшмэдүүд буруушааж

Үүнийг алагтун хэмээвээс, хаан нь

– Үүнийг бүү ал хэмээн зарлиг болоод,

Үүнд гэмгүй, Хааны охиныг гуйлгачин авна. Гуйгачингийн охиныг хаан авна. Түүнийг суулга. Гадагш бүү гарга. Төдий хааны хатан нь хааны дэргэд ирэв. Хаан нь хатандаа

Энэ хүн манай охиныг гуйхаар ирсэн ажгуу хэмээвээс, хатан нь ихэд хилэгнэж

– Энэ галзуурсан хүн буй за. Үүнийг ал хэмээв. Хаан Үүнийг бүү ал. Үүнд гайгүй хэмээвээс, төдий хааны охин тэнд ирсэнд хаан наадмаар охиндоо

Чамайг энэ хүн надаас гуйж байна. Чи үүнд одогтун хэмээн зарлиг болбоос охин нь уйлахад

Эвий, бүү уйл. Энэ миний наадам буй. Үүнд эс одвоос хойно ямар хүнд одох вэ? Охин хүн эцэг эхийн ясыг барих хэвгүй буй за хэмээвээс,

– Би ийм гуйлгачин хүнд одох буюу хэмээсэнд

– Тийм бөгөөс чи ямар хүнд одох вэ хэмээвээс, охин

– Торго хивээр гутал хийх хүнд одно би хэмээвээс, Тийм бөгөөс энэ хүний гутлыг тайлж үз хэмээн зарлиг болбоос тэр хүний гутлыг тайлж үзвээс гутал дотроос торго хив гарсанд хамгаар түүнийг гайхаж, юу ч эс өгүүлэв. Хаан нь

– Энэ хүн эгэл хүн бус болой хэмээгээд, нэгэн үе суулгав. Төдий хааны хатан нь

– Энэ хүн энд сууваас охиныг минь авах магадгүй. Үүнийг аргалж алсугай хэмээн сэтгээд тэр хүнээс

Чи хааны охиныг ямар шалтгаанаар авах вэ? Эд таваар өгч авах буюу. Хүчээр авах буюу хэмээвээс, тэр хүн

Надад эд таваар үгүй, би хаан хатанд хүчээ өгч авна хэмээх тэр үед тэрс номтны нэгэн хаан нь тэр хаанд цэрэглэж ирсэн бөлгөө. Төдий хатан нь тэр хүнд

– Энэ цэргийг хариулж чадваас чамд охиноо өгсүгэй бид хэмээвээс,

Түүгээр болтугай. Надад сайн морь, хуяг, нум сумыг өгтүгэй. Хатан нь тэдгээр үгийг зөвшөөрөөд хуяг нум сумыг өгөөд нэгэн хатуу амтай морь, биед нь архи өгөөд илгээв. Төдий өөрийн цэргээс аван одоод

– Өдгөө чи явагтун хэмээгээд тавьж орхивоос, мориныхоо аманд хүч хүрэн ядаж, нэгэн шугуйд авч орсонд «үхнэ» хэмээн нэгэн модны гишүүнээс ноцсонд модны язгуур булгараад цаад талын цэргийн олон хүнийг цохилж орхивоос тэр цэргүүд,

Энэ эгэл хүн бус, нэгэн хувилгаан хүн ажгуу хэмээн буруулан зугтаав. Тэдний хуяг морьдыг авч ирээд хаанд өргөвөөс хаан нь маш баясаж,

Охиноо өгсүгэй хэмээсэнд хатан нь эс болж

– Бас хүчээ өгөгтүн хэмээв. Тэр хүн

Хэрхэн хүчээ өгөх вэ хэмээвээс, хатан нь

Манай ууланд есөн төө нэгэн үнэг нуруун дээрээ ов тов цоохортой буй. Тэр үнэгийг алж арьсыг авч ир хэмээвээс, төдий морьгүй, нум сум хийгээд хүнсээ авч одоод, олон өдөр болтол үнэгийг эрж эс олоод, нааш харьж хотод хүрч ирэхийн үед нумаа гээснийг мэдээд «үнэг зс олдсон дээр нумаа гээсэн минь муу болов» хэмээгээд нумаа зрэхээр одвоос, нэгэн давааны дээр амарч суусан газарт нь нум хоцорсон ажгуу. Тэр хүнийг хүрэхийн урьд үнэг нумын хөвчийг тас хазваас, нуманд нь үнэг магнайгаа цоо тийртэж үхэв. Үнэгний арьсыг авч ирээд хаан хатанд өргөвөөс, хаан хатан хоёр

– Бас хүчээ өгөгтүн, чамд охиноо лав өгсүгэй хэмээв.

Хүн өчрүүн:

– Ямар хүч өгөх вэ? хэмээвээс

– Умар зүгт монголын долоон морьт албин бөлгөө. Түүнийг авчир хэмээв. Охин нь түүнд сайн хүнсийг бэлдээд нухсан гурилыг долоон хэсэг хар гурил, долоон хэсэг цагаан гурилыг өгөөд, нэгэн хүлэг морийг унуулж илгээлээ. Долоон хоногийн зуур долоон хэсэг гурилаа идээд төдий монголын улсад хүрэв. Төдий нэгэн далайн дундах толгой дээр буугаад долоон хэсэг цагаан гурилаа гаргаж үзээд, нэгэн хар өнгөтийг идсүгэй хэмээж алиныг идэхээр ядахын зуур, монголын долоон морьт албин хүрч ирвээс, тэднийг үзмэгц гурилаа хаяж зугтаан одвоос хойноос нь хөөхөд, нэг нь

Үүнийг хөөж юу хийх вэ. Уналга хүнсийг нь авья хэмээж хойш харьж ирээд долоон хэсэг гурилыг нэг нэгээр идвээс долоон хувь гурилын дотор хор хийсний тул долоон албин хордож үхэв. Тэр хүн хойш харьж ирээд, долоон морь, саадаг нумыг авч одоод хаанд өргөвөөс, хаан маш баясаж охиноо өгөөд, өөртэйгөө адил тавцан засаж их улсаа хурааж их хурим хийж, улсынхаа хагасыг өгч, түүнээс эхэлж хаанд зүрх мэт их хайрт болов хэмээсэнд Сайн амгалант хаан

– Эцэг Санагба сайн газрыг олсны тул, тийн сайн болжээ хэмээвээс

– Заяагаа барсан хааны амнаас дуу гарав. Сарвад үл сууна би хэмээж огторгуйд нисэн одов.

АРСЛАН ҮХЭР ХОЁРЫН ХОРЬДУГААР БҮЛЭГ

Тэндээс одох ёсыг урьдах мэт үйлдэж, Сэрүүн үхээрийн ойд шидэт хүүрийг авахаар хүрээд, үүрч ирэхэд бас хүүр энэ үлгэрийг өгүүлрүүн:

– Бас эрт урьд цагт, энэтхэгийн умар зүгийн нэгэн цаст ууланд арслан хороонд нэгэн өлөгчин арслан төрөөд, идэх юм эс олж зулзагаа идэх завдаад, тэвчиж идэн ядаж, уул далайн завсар идэш эрж одсонд, нэг сүрэг үхэр арслангийн үнэрийг үнэрлээд зугтааж одоход, нэгэн үхэр нь эс дутаав. Өлөгчин арслан харайж тэр үхрийг бариад цусыг сорж мах ясыг аваад одвоос, тугал нь түүний хойноос дагаж одоод, арслан цусыг ууж согтоод хэвтсэнд арслангийн зулзага, тугал хоёул арсланг хөхжээ. Арслан согтуурсны тул тэр хоёрыг еөрийн зулзага мөн хэмээн тэжээв. Төдий болоод арслан араагаа гөрөөсний ясанд хатгуулж өвчин болоод үхэхэд ойртвоос, хоёр хөвгүүндээ

– Та хоёр өөр зуураа сайтар явагтун. Дайсан ирвээс хүчээ нэгтгэ, бус муу хэний ч үгэнд үл орогтун хэмээн гэрээслээд үхэв. Төдий арслангийн зулзага ойд явав. Тугал нь уулын өлгөд явав. Ус уух цагтаа хамт уугаад наадан тоглож хамт яван атал нэгэн төдий болсны хойно, арслангийн алсан гөрөөсний махыг нэгэн үнэг хойноос нь дагаж идэн яваад нэгэн учирт арслан үхэр хоёул усыг хамт уун суух цагт үнэг нь «энэ хоёрыг хатгаж хагацуулсугай, арслангийн хишгийг би идэх бөлгөө. Өдгөө энэ үхэр ирвээс идэлцмүү» хэмээн сэтгэв. Нэгэн едер арслан нэгэн гөрөөсийг барьж идээд цусыг ууж хэвтэхэд, үнэг нь арслангийн барьсан гөрөөсний махыг үл идэн арслангийн дэргэд ирээд сүүлээ буулгаж, чихээ дэлдийлгэж байваас, арслан

– Үнэг чамд юу болов. Тэр махыг ид хэмээвээс, үнэг нь Тэр махыг идэж яаж болох вэ. Чамд минь нэгэн дайсан буй бөлгөө. Түүнд муу санаж чиний төлөө сэтгэл минь зовно хэмээвээс, арслан

– Надад дайсан хэн ч үгүй. Чи махыг дуугүй идэгтүн. Үнэг

Нагац миний үгэнд эс орвоос хойно гэмших болно чи хэмээгээд хэвтэв.

Тийм бөгөөс надад дайсан хэн буй хэмээв. Тэнд нэгэн үхэр ажгуу. Миний эхийг арслан алсан бөлгөө. Өдгөө би арсланг алсугай хэмээмүү. Арслан

– Тэр бид хоёр ах дүү хоёр бөлгөө. Надад гайгүй хэмээв. Үнэг

Чи үл мэднэ. Түүний эхийг чиний эх алсан нь үнэн бөлгөө хэмээвээс, арслан нь «энэ үнэг миний нагац мөн ажгуу» хэмээн сэтгээд

– Тэр намайг хэрхэж алах вэ? Надад өгүүл гэхэд үнэг

Тэр үхэр маргааш эрт босоод, эврээрээ газар сэжиж биеэ сунган сүүлээ саадаглаад мөргөж байваас чамайг алахын бэлгэ тэр буй. Арсланд муу сэтгэл төрөөд

– Тийм бөгөөс би сэрэмжилнэ хэмээв. Төдин бас уулын өлөгт гарч, өвс идээд хэвтэх үхрийн

дэргэд одоод сүүлээр газар занчиж чихээ дэлдийлгэн уйлан байваас

Үнэг чамд юу болов хэмээн асуухад,

Дүү минь чамд дайсан буйн тул нагац чинь би зовж уйлна.

Надад ямар ч дайсан үгүй. Намайг үл чадна хэмээвээс, Үнэг Энэ уулын ард нэгэн арслан буй бөлгөө. Тэр нь

– Урьд эх минь түүний эхийг идлээ. Өдгөө би түүнийг идсүгэй хэмээмүү.

Чи дуугүй суугтун. Тэр бид хоёр ах дүү хоёр бөлгөө. Надад дайсагнах санаа үл үүсгэнэ хэмээвээс үнэг:

Өдгөө чи миний үл орох бөгөөс хойно гэмших болно гэв. Үхэр «Энэ миний нагац лав мөн ажгуу» хэмээн сэтгээд

Тийм бөгөөс арслан намайг хэрхэн алах вэ? Надад өгүүл хэмээвээс:

Маргааш эрт босоод, биеэ суниаж зогдроо сэрвийлгэж хумсаа гаргаж хөлөө газар малтваас чамайг алахын бэлгэ нь тэр болой.

Тийм бөгөөс би сэрэмжилсүгэй хэмээгээд маргааш эрт босоод нэг нэгнээ үзвээс үнэгний ямар өгүүлснээр үзэгдэв. Төдий хоёуланд хилэн төрж, наран мандахад хоёул хамт ус уухаар ирвээс тэр хоёрын босохдоо өөр өөрийн ёсон бөгөөтөл нэг нэгнийхээ занг эс мэдсэний тул үнэгний хатгасан үгэнд ороод, арслан довтолж үхрийн хүзүүнээс ноцвоос үхэр нь арслангийн хүйс өөд эврээрээ цоо мөргөж арслан үхэр хоёулаа үхэхэд, огторгуйгаас хоосон дуун гарав.

«Муу нөхрийг үл шүтэгтүн, Муу нөхрийг шүтвээс арслан үхэр хоёрыг үнэг хагацуулсныг үзэгтүн» хэмээвээс, Сайн амгалант хаан

– Амраг ах дүү хоёрыг муу үнэг хагацуулсан ажгуу хэмээн дуугарваас

– Заяагаа барсан хааны амнаас дуу гарав. Сарвад үл сууна би хэмээн огторгуйгаар нисэн одов.

БИЛИГТ ТУУЛАЙН ХОРИН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Тэндээс бас урьдах мэт үйлдэж, Сэрүүн үхээрнийн ойд шидэт хүүрийг авахаар хүрээд үүрч ирэхэд, бас хүүр энэ үлгэрийг өгүүлрүүн:

– Эрт урьд цагт энэтхэгийн умар зүгийн Балбын оронд Алтан өнгөт хэмээх нэгэ голд эмгэн өвгөн хоёр хөвгүүнгүй, нэгэн охинтой ажгуу. Өвгөн эмгэн хоёр өтөлсний тул охиноо нэгэн сайн хүргэнд өгөөд, эд агуурсаа эзлүүлсүгэй хэмээхэд, нэгэн гуйлгачин өвгөн эмгэн хоёроос нэгэн хөвгүүн төрсөн бөлгөө. Түүний хөвгүүнд охиноо өгөөд, хүргэн болгож гуйлгачин өвгөн эмгэн хоёрт эд таваар өгөөд хариулав. Төдий болсон нэгэн учирт гуйлгачингийн хөвгүүн охиныг аваад эцэг эх хоёртоо золгохоор одов.

Эцэг эх хоёроо үл олон хамаг улсад бядан явж хүрсэн бөлгөө. Тийн атал нэгэн их хаан хамаг гуйлгачин нарыг хурааж өөр өөрийн тааллаар өглөг өгөхөд, тутарганы архийг уугаад хааны өглөгийг аваад тархаж одсонд, төдий хөвгүүн эхнэртээ:

– Энэ ертөнцөд баян болбоос эд идээгээ хадгалж үл чадан, мал болбоос адуулж үл чадан, хаанд албыг өгнө. Түүнээс гуйланчилж хамаг улсад хүрээд, юу хүссэнээ гуйж идээд, хулгай дээрмээс үл айн, эд малаа хадгалахын зовлонгүй. Түүнээс энэ мэт гуйланчилж идэх минь жаргал бус уу. Чиний эцэг эх хоёр үхвээс хойд гэр малыг бид хоёр эзлэвээс эцэст барагдана. Үл барагдах идээ гуйж идэгч энэ идээ бөлгөө гэв. Олон балгадад одож гуйланчилж идээд явах үест эхнэр нь нэгэн хөвгүүн төрүүлэв. Эхнэр

– Эцэг эх баян бөлгөө. Өдгөө тэнд одвоос зохино. Энэ хөвгүүнээ үүрвээс үл даана. Орхивоос үл зохино. Эцэг нь аглаг хөдөө тэр улсад архигүй тул сууж үл тэснэ. Эхнэр нь түүнд юуны хань болох эв. Эцэг эх хоёроосоо нэгэн уналга аваад, хөвгүүнийг унуулж гуйланчилсугай хэмээвээс, эр нь тэр үгийг зөвшөөрч Алтан өнгөт голыг уруудаж ирвэл эцэг эх хоёр нь үхэж эд таваар юу ч эс үлдсэний тул, харин хойш хариад гуйланчилж яван атал нэгэн их өндөр уулын үзүүрт бутанд хонины унгас торж унасныг аваад үүнийг хурааж, түүгээр нэгэн цэмбийг нэхсүгэй. Тэр өндөр дээр гарч олон улсыг үзээд, тэднээс арвай тутаргыг гуйж аваад цэмбээ нэмж нэгэн илжиг аваад хөвгүүнээ унуулваас жаргал бус уу. Хэрэв илжгийг авбаас эм илжгийг авагтун. Түүнээс унага төрвөл хоёр болно гэхэд эцэг нь

– Тэр үнэн. Эм илжгийг авбаас хоёр болох буй. Төдий гуйланчийн хөвгүүн

– Хэрвээ унага төрвөөс би түүнийг унаж гуйланчилсугай хэмээвээс эх нь

Унаганы нуруу хугална чи гээд модоор хүүхдийнхээ толгойг цохивоос хүүхэд нь үхэв. Эмийн эцэг эх хоёр нь охин хүргэн эс ирсэнд үхсэний хойно, эд малыг эзлэгч хэн ч үгүй тул, түг түмэн хонийг нь чоно хийгээд цөөвөр барьж идэв. Түүнээс ганц хурга үлдээд нэгэн нүхэнд орж өдөр нүхэндээ хэвтэж, шөнө нүхнээсээ гарч өвс идэж явах белгөө. Нэгэн учирт тэр нүхний амсарт нэгэн бүтэн уруулт туулай ирж, мөрийг нь үзээд «энэ нүхэнд нэгэн амьтан буй ажгуу» хэмээхийн зуур хурга гарч ирвээс туулай

– Чн хэн бэ? хэмээн асуув. Хурга

– Нэгэн баян хүний олон олон хониноос үлдсэн билээ би. Туулай,

Чнний эзэн хаана одов хэмээвээс хурга:

Эзэн минь хөвгүүнгүйн тул сэтгэл нь зовож үхэв. Түг түмэн хонийг цөөвөр чоно барив. Өдгөө би түүнээс үлдэж харанхуй нүхэнд хоцров. Энэ өдөр эхэлж туулай чамайг аврал болгосугай хэмээн шүлэглэж өгүүлэв. Туулай

Энд ганцаар сууж болохгүй. Бн чамайг хонь ямааны сүрэгт нийлүүлсүгэй хэмээхэд хурга:

Аяа, туулай чи чоно ирвээс амийг минь аварч чадах уу? гэвэл туулай

– Гайгүй, би чамайг хүргэж өгнө хэмээгээд, арван тавны шөнө саран ургахад авч одвоос, зам дээрээс утасны ээрүүлийг олоод, хурганд

Үүнийг ав хэмээгээд авахуулав. Тэндээс бас одвоос нэгэн хэсэг шар нөхөөсийг олоод, хурганд бас авахуулав. Тэндээс одоод нэгэн бичигт цаасны хуудсыг бас авахуулав. Тэгээд цааш одвоос нэгэн чоно учрав. Чоныг үзмэгц туулай:

– Миний ширээг авчирч зас. Улаан дэвсгэрийг минь дэвс. Арван тавны сарны өгсөн бичгийг минь авч ир хэмээсэнд ширээн дээр туулайг суулгаж бичгийг хурга өргөв. Туулай бичгийг үзээд,

Хурмаст тэнгэрийн зарлиг бичгийг хувь ёст туулайд өгөхийн учир

Хорт мянган чонын арьсыг өвчөөд авч ир.

Хурднаа ширээнээс буугаад арьсыг авсугай хэмээгээд, хоёр чихээ сэртийлгэн хөөвөөс чоно хойшоо харалгүй, буруулан дутаав. Түүний хойно тэр хургыг авч одоод Балбын хонины сүрэгт тавьсан бөлгөө. Төдийгөөс өдгөөс хүртэл Балба

улсын хонийг туулай адгуулахын ёс түүнээс болсон бөлгөө хэмээсэнд Сайн амгалан хаан нь

Билигт туулай бол хэмээсэнд,

Заяагаа барсан хааны амнаас дуун гарав. Сарвад үл сууна бн хэмээж огторгуйгаар нисэн одов.

ИЛЖГЭН ЧИХТ ХААНЫ ХОРИН ХОЁРДУГААР БҮЛЭГ

Тэндээс одох ёсыг урьдах мэт үйлдэж, Сэрүүн үхээрийн ойд шидэт хүүрийг авахаар хүрээд үүрч ирэхэд, бас хүүр энэ үлгэрийг өгүүллрүүн:

Бас эрт урьд цагт Энэтхэгийн дорно зүгийн хар хятадын Тайван хаанд нэгэн хөвгүүн бөлгөө. Тэр хөвгүүн нь хаан ширээнд суугаад, хүнд биеэ нэгээхэн бээр үл үзүүлэгч бөлгөө. Өдөр бүр улсаас нэг сайхан хөвгүүнийг авч одоод, үсээ шүүрдүүлээд алдаг байжээ. Олон жил болтол тийн алваас нэгэн өдөр нэгэн эмгэний ганц хүүгийн ээлж болжээ. Хааны үсийг шүүрдэх хувь нь тэр хөвгүүнд хүрвээс, «алагдах цаг ирж» гэж уйлан хайлаад, эх нь хөвгүүндээ шинэ хувцсыг өмсгөөд, өөрийн хөхнийхөө сүүг гурилд зуураад моголцоглож өвөрт нь хийж өгөөд, Хааны үсийг шүүрдэхдээ үүнийг бага багаар идэж шүүрд. Чамайг алахгүй ч байж магадгүй хэмээвээс, хөвгүүн нь хааны дэргэд очоод, алтан хатгуураар үсийг самнахад хааны чих нь илжигний чихтэй адил болохыг мэдэв. Түүнийгээ хүнд мэдэгдэх вий хэмээгээд алахын учир тэр бөлгөө. Хааны үсийг шүүрдэхдээ гурилаа идэж суухад хаан

– Чиний энэ идэгч идээ юу вэ хэмээвээс,

Тугарганы гурил бөлгөө хэмээн өчвөөс, хаан нь

– Надад өгөгтүн хэмээв. Төдий нэгэн хэсэг гурилыг хаанд өргөвөөс, хаан зооглоод,

– Үнэр амт нь маш сайхан, үүнд юу хольсон бэ? гэхэд, хөвгүүн

– Эх минь өөрийн сүүндээ зуурч өгсөн билээ хэмээн өчвөөс хаан нь:

Үүнийг алж үл болно. Энэ бид хоёр нэг эхийн сүү уусан бөгөөтөл төрлөө алах ёсон билээ хэмээн сэтгээд

Би чамайг алахгүй. Намайг илжгэн чихт гэж бус хүнд бүү хэл хэмээвээс

Аяа, хаан минь! Би хэнд ч хэлэхгүй. Тийм бөгөөс эхдээ ч бүү хэл. Хэрвээ хүнд хэлсэн байвал би чамайг ална хэмээн захирав. Үүнийг бус хэн ч мэдсэнгүй. Тэр хөвгүүн гэртээ харьж одов. Түүний дараа шүүрдэгч хөвгүүдийг урьд ёсоор алав. Бүгдээрээ эмгэний хөвгүүн жаргалтай хэмээн гайхалдав. Хамаг бүгдээр түүнээс асууваас, эх болон бүгдэд юу ч эс егүүлээд, хааны чих нь бусдаас үлэмж болохыг өөр хэнд ч хэлэлгүй, дотроо санасны тул тэр хөвгүүн их хатуу өвчин хүртэж эм, дом тэргүүтэн юуг ч үйлдвээс тус эс болжээ. Төдий үхэхэд хүрвээс нэгэн отчийг залж ирээд судсаа бариулав. Эмч нь:

Чамд сэтгэлийн өвчнөөс бус өвчингүй гээд энэ өвчинд эм тус болохгүй. Сэтгэлд санаснаа аманд гаргаж хэлбээс, эдгэх бөлгөө хэмээвээс, хамаг бүгдээр нэгдэж

Үг буй бөгөөс өдгөө өгүүл. Үхэхдээ эс өгүүлснийг хойно хэзээ өгүүлэх гэхэд тэр хөвгүүн «Үгүй» хэмээн эс хэлсэнд эх нь шамдаж асууваас, эхдээ

– Нэгэн өгүүлэх үг буй бөлгөө. Хэрвээ өгүүлвээс хаан засаглана гэхэд эх нь

Тийм бол хүнгүй аглагт одоод, газар чулуу хийгээд модны нэгэнд өгүүлвээс эдгэнэ гэв. Хөвгүүн нуугдаж одоод нэгэн оготны нүхэнд амаа тулгаж,

Манай хаан илжгэн чихтэй бөлгөө хэмээн олонтаа давгаж өгүүлвээс, тэр мөчөөс эхлэн тэр хөвгүүн эдгэв. Тэр нүхэн дэх оготно түүний үгийг сонсоод оготноо дуун гарваас салхи лугаа нийлж хааны чихэнд сонстов. Төдий «Энэ үгийг тэр хөвгүүн хэлсэн ажгуу» хэмээн элч илгээж тэр хөвгүүнийг хааны дэргэд авч ирээд хаан зарлиг болруун:

– Би чамайг хүнд бүү хэл хэмээж захирсан билээ. Өдгөө чиний заяа хүрсний тул, тийм үг өгүүлэв үү хэмээн асууваас, хөвгүүн

– Би өөрөө нэгээхэн ч хүнд хэлсэнгүй билээ хэмээвээс хаан

– Нэгэн хүнд хэлсэн ажгуу, чи. Тэр үгс чинь надад сонсдов. Эс хэлвээс надад хэрхэж сонсдох хэмээвээс, хөвгүүн

– Гэртээ хариад надад хатуу өвчин хүрч, ураг элгэн бүгдээр яав ийв гэхэд би юу ч хэлээгүй билээ. Тэгээд үхэхэд ойртоод нэгэн отчийг залж судсаа бариултаас отчийн өгүүлсэн, эхийн хэлснийг үнэнээр нь өчөөд, оготнын нүхэнд хэлснээс бус хүнд хэлсэнгүй билээ. Муу үгийг салхи хэлснээс бус хэн өгүүлэх вэ гэв. Төдий хаан нь

– Би чих болон хий лүгээ хольцсоныг сонссон бөлгөө хэмээгээд, үүнийг алж юу хийх вэ? Өдгөө энэ миний чихэнд аргалах арга чамд бий юу хэмээвээс, хөвгүүн

– Аяа, их хаан миний үгэнд орох бөгөөс надад нэгэн арга бий гэв. Хаан нь

– Хөвгүүн чи тэр аргаа надад хэл. Би сонсьё гэхэд хөвгүүн

Аяа, их хаан тэргүүндээ нэгэн малгайг хийгтүн. Түүний хоёр талд чихээ далдлах эвэртэй малгай хийж өмсөөд дэргэдэх нөхдөд бас тэр ёсоор өмсгөж хурваас зохино хэмээн өчвөөс тэр үгийг зөвшөөрч малгай хийж нэгэн сайн өдөр өмсөөд, хаан ширээн дээр сууж, харцас бүгд чуулаад тэр малгайг бүгдээр гайхалдаж магтаад, бүгдэд алдаршив. Төдий бүгдээр хааны чих илжигний адилыг эс мэдээд чимэг болгож эвэрт малгай хэмээн алдаршуулжээ. Өдгөө Тайван хааны дэргэдэх ямуданд тийм малгай буй бөлгөө. Эмгэний хөвгүүн засгийг баригч түшмэл болоод, хүн алахаа тэр үеэс болив. Төдий хамаг их улс амар жаргажээ хэмээсэнд Сайн амгалант хаан

– Ганц хааны чихний тул тийм олон хүний аминд орсон эмгэний хөвгүүн сайн билигт бол хэмээвээс

– Заяагаа барсан хааны амнаас дуу гарав. Сарвад үл сууна би хэмээж огторгуйгаар нисэн одов.

ГАНЬ ХӨВГҮҮНИЙ ХОРИН ГУТГААР БҮЛЭГ

Тэндээс одох ёсыг урьдах мэт үйлдэж, Сэрүүн үхээрийн ойд шидэт хүүрийг авахаар хүрээд үүрч ирэхэд бас хүүр энэ үлгэрийг өгүүлэв.

Эрт урьд цагт Энэтхэгийн өрнө зүгийн гичийн оронд, эмгэн өвгөн хоёрт нэгэн маш их тэнэг хөвгүүн байжээ. Эцэг эх хоёр нь

Манай энэ хөвгүүн маш их тэнэг тул амь зууж үл чадна. Үүнд нэгэн баян хүний охин олж гэргий болгосугай хэмээн ярилцаад, авч өгөөд хөвгүүний эцэг эх хоёр нь үхэв. Тэр хөвгүүн идэх унтахаас өөр юу ч үл мэдэх бөлгөө. Эд идээгээ бараад дараа нь тариалангийн газраа худалдаж бас идэв. Юу ч үгүй болсон учир эхнэр нь

– Бид хоёр юу ч үгүй суусаар турж үхнэ. Миний эцэг эх хоёрт нэгэн бэлгийг олоод хоёулаа очвол, бидэнд амь тэжээх юмыг өгөх буй за хэмээгээд, бэлэг болох юм илүү олохоор, эрийгээ

Чи энэ усыг өгсөөд жуучнуудад тусалваас нэгэн загасыг өгнө. Түүнийг бэлэг болгож аван одсугай гээд, эр нь жуучинд очиж тусалваас, нэгэн амьд загасыг барьж өгөв. Түүнийг гэртээ авчирваас эхнэр нь нэгэн тавганд ус хийж тэр дотор загасыг тавьж, эрдээ бариулаад өөрөө түрүүлж, эрийгээ

Чи хойноос ирзгтүн. Би урьд очье хэмээгээд одвоос төрхөм нь

Охин минь ирэв хэмээн баясаж угтан ирвэл охин нь

Эр минь хойноос ирнэ хэмээвээс бас түүнийг угтсугай хэмээгээд угтаж хүлээвээс эс иржээ. Өнө болсны хойно угтаж одвоос тэнэг хүргэн нь усыг гаталж явтал тавган дахь загас цолгивоос загасаа алджээ. Хувцсаа тайлаад загас нь үл үзэгдэх бөгөөтөл эрсээр явах ажгуу. Ургууд нь

– Үүгээр хөөцөлдөж юу хийх вэ, Одоо манайд очье хэмээвээс үл болон

– Миний хүргэх шүүс бөлгөө хэмээгээд, бас хөөхөд ус булингартсаны тул юу ч үл үзэгдэнэ. Хадам эх нь бас ирээд

Манай гэрт очье гэхэд

Шүүсгүй очиж болохгүй гээд эс болов. Тэр усан дотор бүгдээр эрвээс чулуунаас бус юу ч үгүй ажгуу. Төдий

– Чиний шүүс ямар дүртэй вэ? хэмээн асууваас, загасны дүрийг өгүүлэхээ үл олон, нууц орны (бэлэг эрхтний) толгойноос барьж ийм бөлгөө гэсэнд хадам эх тэргүүлэн эмийн төрөл бүгдээр

– Ийн тэнэг хүн ажгуу хэмээн ичиж гэртээ харьж ирээд, охиноос

– Тэр юу вэ хэмээн асууваас

– Загас гэв.

Төдий төрөл бүгдээр

– Энэ хоёр яаж амь зуух вэ хэмээгээд, хүнс хийх идээг өгөөд

– Үүнээс хойш манд бүү ир. Манай нэрийг гутаах бөлгөө хэмээгээд хариулав. Төдий эхнэр нь төрхмөөсөө цөхрөөд, бус улсад одож, өрмөгийг нэхэж амиа тэжээхэд эрээ сургасны тул хэрсүүжиж, худалдаа хийж юмыг олов. Түүний эхнэрт бас нэгэн хэсэг сувд байв. Худалдааг сайтар хийж нэг морь олов. Төдий эмдээ:

– Чиний төрхөм манийг эс тоож хөөсөн бөлгөө.

Өдгөө түүнээс нэгэн өшөөг авсугай хэмээгээд, сувдаа аваад морио унаж одвоос, хадам нь хаалганд угтаж ирээд, гэртээ хөтөлж буулгаваас, тэр хүн мориныхоо толгойд таарцгийг өмсгөж, тавиваас тэдгээр нь

– Чи энэ мориндоо өвс өгтүгэй хэмээбээс,

Миний морь өвс иддэггүй гээд, архи идээг идэж гадаа гарч морины дэргэд очоод, мориныхоо бааснаас аваад, сэмээр сувдаа нийлүүлж нэгэн саванд хийж хадгалав. Төдий хадмууд нь

– Энэ чинь юу вэ? гэхэд

Энэ миний морь бол чандманьт морь буюу. Үүний бааснаас эрдэнэ гарна. Үүнийг хүнд үл өгнө хэмээвээс, негөөдүүл нь «үзье» гээд үзвэл аргал лугаа сувд хольсныг үзээд

– Үүнийгээ чи бидэнд худалд гэв. Эс болбоос эд таваар маш ихийг өгөн худалдаж аваад хүргэнээс

– Энэ морийг хэрхвээс эрдэнэ гарах вэ хэмээвээс

– Долоо хонотол ус бүү өг. Өчүүхэн буурцаг егвөөс гарна. Түүний хойно олон дахин егвөөс сувд олон гарна гээд, харьж одсоны хойно долоо хонотол усыг үл өгөн буурцаг өгвөөс морь нь үхэв. Түүний хойно хуурсныг мэдээд хүргэнийгээ эрж олоод, хоёр гарыг нь ард нь хүлж, авч ирэхдээ замын нэгэн балгадад хүргэнээ таримал модонд хүлж орхиод, хадмууд нь тэр балгадад архидаж одсоны хойно тэргүүн нь газарт хүрсэн мэт бөгтөр хүн нэгэн сүрэг арван гахай хөеж ирээд, модонд хүлсэн хүнийг үзээд:

– Чи юун хүн бэ? гэхэд

Би оточ хүн бөлгөө. Бөгтөр хүнийг энэ модонд хүлвээс шударга болно гэв. Бөгтөр өгүүлрүүн:

Тийм бөгөөс миний нурууг залж шударга болго хэмээвээс, түүгээр болсугай гээд, намайг тайлагтун гэв. Бөгтөр хүнийг модонд хүлж тавиад ингэж захив.

Намайг хүрч иртэл чи дуун бүү гарга. Гахайг чинь би адгуулсугай гээд, гахайг аваад гэртээ

харив. Хадмууд нь ирээд урьд хүргэнээ мөн хэмээн андууран авдарлаж модны дэргэдэх нэгэн их гүн худагт орхиод тэд өөрийн гэртээ харьж одсоны хойно, хүргэн нь гэртээ их олзтой хүрэв хэмээн сонстлоо.

Тэр худал буй за, Үнэн бөгөөс тэр нэгэн нүгэлт хүн ажгуу хэмээгээд очиж үзээд

– Чи яаж ирэв гэж асуувал

Та нар надад дайсагнаж намайг усанд орхив. Усан дотор лусын хаад хурим хийж суух ажгуу. Намайг үзээд ертөнц дэх хүн энэ бярманд юу таалсныг өг хэмээн зарлиг болов. Төдий надад нөхөр үгүй тул олон малын захаас арван гахай хөөж ирлээ. Дахиад энд ирвэл нэгэн саванд их чулуу хийж авч ирэгтүн. Түүн лүгээ сацуу эрдэнэсийг өгнө хэмээн амлалаа. Өдгөө би долоо хоноод явна хэмээсэнд тэд бүгдээр сонсоод, хадмууд нь «тааран дотор чулуу хийж үүрээд долоо хоногийн урьд очъё гээд нэг нэг худаг уруу харайсаар бүгд үхэв. Тэдний гэр газрыг хүргэн охин хоёр эзлэв. Төдий Сайн амгалант хаан

– Олон сэтгэлт гань хүнд, ганц сэтгэлт олон цэцэн хүн хууртлаа хэмээвээс

– Заяагаа барсан хааны амнаас дуу гарав. Сарвад үл сууна би хэмээн огторгуйгаас нисэн одов.

ТУЛАМ ҮҮРСЭН ЭРЭЭЛЖ ЧӨТГӨР, СУУЛГА ҮҮРСЭН ХҮН ХОЁРЫН ХОРИН ДӨТГӨӨР БҮЛЭГ

Тэндээс одох ёсыг урьдах мэт үйлдэж, Сэрүүн үхээрийн ойд, шидэт хүүрийг авахаар хүрээд үүрч ирэхэд бас хүүр энэ хуулийг өгүүлрүүн:

Бас эрт цагт Энэтхэгийн дорно зүгийн хаанд нэгэн өчүүхэн хөвгүүн бөлгөө. Ам гарахын урьд нэгэн хатуу өвчин хүртэж арга чарга юуг үйлдвээс тус эс болжээ. Үхэхэд ойртвоос түүнд зэтгэрлэсэн нь, тэр оронд эрээлж хэмээх, хүний арьсан тулам үүрсэн тэр энд тотгорлосон бөлгөө. Түүнийг хэн ч эс мэджээ. Тэр балгадад нэгэн хүн бусдад тарианы үрийн төлөөсөө авахын тул, шөнө нэгэн суулгыг барьж явах зуур замд, эрээлж чөтгөр учрав. Тэр хүн суулгыг тэргүүн дээрээ өмсөөд чөтгөрийг хөөхөд чөтгөр

– Чи хэн бэ? Надад хор битгий хий. Хоёулаа нөхөр болсугай. Чамд юу хэрэгтэйг чинь би өгье хэмээгээд, чиний нэр хэн вэ? хэмээн асуухад, хүн

– Миний нэр Суулга үүрсэн үүрэгч гэв.

Чөтгөр чиний нэр хэн бэ? гэхэд

Миний нэр хүний арьсан тулам үүрсэн эрээлж хэмээв. Эрээлж

– Чи суулгаа тэнд тавиад нааш ир гэсэнд суулгаа тавиад, очвол тулам дотроос цагаан хив торгыг гаргаж тэр хүнд өгөөд, үүнээс хойшид суулгыг тавьж наашаа ирж бай. Юу хүссэнийг чинь өгсүгэй. Би суулганаас чинь айна гэв. Хүн

– Өдгөө бид хоёр ах дүү хоёр боллоо. Чиний суух орон чинь хаана байна. Надад зааж аль гэхэд чөтгөр нь,

Надад суух орон үгүй, Миний орон огторгуйд бий гэв.

Чи юунаас айна гэхэд бас чөтгөр

Намрын цагт тариа болж үр дүүрсэн нүд болж бүлтийж байхаас айна. Бас чиний суулганаас айна, түүнээс бус юунаас ч айхгүй гэв. Булсан тарианы дэргэд очихгүй. Түүнээс бус хаана ч түдэлгүй явна гээд

Хүн чи юунаас айх вэ? гэвэл хүн

– Би чиний үүрсэн туламнаас айна. Чи тулмаа орхи. Би суулгаа орхисугай. Түүний хойно бид хоёр нөхөр болсугай. Эрээлж

– Би энэ тулмаа орхиж болохгүй. Хамаг бүгдэд өвчин болгоод амийг авагч бөлгөө. Би едгөө үүнийг орхивоос амиа юугаар тэжээнэм. Тэгтэл хүн нь нэгэн эврээр хийсэн савыг тариагаар дүүргээд, ёроолыг нь цоолж чөтгөрт өгвөөс, чөтгөр түүнийг авч орондоо харив. Түүний хойноос тэр хүн зул барьж, тариа цувруулсан мөрөөр мөрдвөөс их хөндий хадны амсарт тэр

чөтгөр суудаг ажээ. Хөндий дотор нэгэн хүүхэд «би өлсөж байна» гээд уйлж суув. Төдий эцэг нь

– Эвий, бүү уйл, Энэ өдрийн хувийг нэгэн муу хүнтэй ураг болж өгөв. Маргааш хааны хөвгүүний золигт олон мал ална. Түүнийг зэтгэрлэгч би бөлгөө. Тэр малын мах цусыг би авч ирээд чамд өгье гэхэд, хөвгүүн нь ийн өгүүлрүүн:

– Ахай, тэр хан хөвгүүний өвчин юу вэ? түүнд юу тус болох вэ? гэвэл, эцэг нь түүнийг зэтгэрлэсний тул

– Юу ч тус болохгүй, үхнэ гэв. Хүүхэд нь

Ахай, ямар өвчнийг өгөв хэмээв. Эцэг нь

Би аалз бариад чихэнд нь хийсэн бөлгөө. Өдгөө тэр хан хөвгүүний чихэнд үүр засаад төрсний тул, түүний арга нь хялбар бөлгөө. Өөр хэн ч аргалж чадахгүй.

Ахай түүний арга нь юу вэ гэхэд

Түүний арга нь улаан үхрийн халуун цусыг ханаж аваад тэвшин дотор хийвээс хөөс гарна. Түүний дэргэд хан хөвгүүнийг баруун чихээр бариад, цан хөөрөг дэлдэн бялар бишгүүрийг татваас «зун болж» гээд хорхой нь чихний гадна гараад, зулзагануудаа «зун болов» хэмээн авч ирээд цусны хөөсийг цэцэг хэмээн харайж одвоос эдгэх нь тэр бөлгөө. Төдий тэр хүн тэдгээр үгийг далдаас чагнаж сонсоод, нааш ирж хаанд өчрүүн

Аяа, хаан чиний энэ хан хөвгүүнийг би эдгээе гэхэд, хаан баясаж тэр хүнд үзүүлэв. Тэр хүн чөтгөрийн ямар өгүүлснээр хийхэд, хан хөвгүүн эдгэв. Хаан нь тэр хүнд ачилж ихэд өглөгийг өгөв. Түүний хойно хүн чөтгөр хоёр учраад чөтгөр нь туламнаас идээ гаргаж хүнд өгөөд,

– Нөхөр чи энэ тулмыг минь хадгалж байгтун. Би нэгэн хүнийг зэтгэрлэж ирсүгэй хэмээгээд одсоны хойно, тэр хүн тулмыг аваад нэгэн их тарианы дотор буруулав. Төдий чөтгөр ирээд тарианы гадуур эргэж яваад дуудваас дуу эс гарав. Чөтгөр тэнд олон идээг тариалангийн захад тавиад гомдож гэртээ харив. Тэр хүн тулмаа суулган дотор хийж, амсар дээр нь нэгэн цэцэг тавиад, гэртээ авч ирэв. Түүнээс эхэлж өвчтнүүд тэр тулмыг толгойдоо өмсөөд авбаас эдгэв. Тийн олон өвчтөнийг эдгээгээд, юу хэрэгтэй эд таваарыг ихээр олов. Төдий тэр үхэх цагтаа

Надад хөвгүүн үгүй, энэ тулмыг тавиваас чөтгөр авчихна гээд тулмыг хэсэг хэсэг огтчиж усанд хаяв. Тэр чөтгөр түүнийг мэдэж их далайд хүрэхийн наана ирж туламынхаа хэсэг хэсэг болсныг олж аваад хүний шөрмөсөөр оёж нийлүүлээд бас хүмүүст зэтгэр хүргэв. Тэр тулмыг галд түлвээс хүн урт наст болоод насандаа хүрч үхэхээс бус зуур зэтгэргүй бөлгөө. Усанд хаясны тул насад зэтгэрлэгч түүнээс боллоо. Төдий Сайн амгалант хаан нь

– Тэр тулмыг галд түлвээс хамаг амьтан амрах белгөө хэмээвээс

– Заяагаа барсан хааны амнаас дуу гарав. Сарвад үл сууна би хэмээж огторгуйгаар нисэн

МАЛИА УУЛААС ДӨРВӨН ХҮНИЙ ШИД АВСАН ХОРИН ТАВДУГААР БҮЛЭГ

Тэндээс одох ёсыг урьдах мэт үйлдэж, Сэрүүн үхээрийн ойд шидэт хүүрийг авахаар хүрээд, үүрч ирэхэд бас хүүр энэ үлгэрийг өгүүлрүүн:

Эрт урьд цагт энэтхэгийн өмнө зүгийн Малиа хэмээх уулын дэргэд Олон эдэт хэмээх нэгэн баян бөлгөө. Тэр хүн мянган үнээтэй бөлгөө. Тэдгээр үнээний дотроос зургаан эвэртэй их хайртай үнээ нь алга болоход, тэр үнээгээ эс олвоос, бусад үнээгээр юу хийх хэмээн, нэгэн шарыг унаад эржээ. Төдий олон ядахын зуур их шуурга болоод, Малиа уулын нэгэн булаг хадны дэргэд нойрсож, хэвтгээд шөнө босож тэр ууланд сан тавиад

Би зургаан эвэрт үнээгээ эс олов. Энэ шөнө надад нэгэн сайн зүүдийг өгч соёрх хэмээгээд хэвтэв. Төдий зүүдэнд нь тэр булгийн эзэн нэгэн лусын хаад байж гэнэ. Түүний цаана нь жамба хэмээх албин байжээ. Тэр албинд лусын хаад

Энэ хүний тавьсан сан нь ийм амттай буюу Бид хоёр үүнд нэгэн шидийг өгье хэмээсэнд, албин ирээд хоёул тэр хүнд төлгөний утсыг өмсгөж тавив. Маргааш сэрээд төлгөний утас тавьсныг үзээд баясаж төлгийг үзвээс «энэ уулын дорно зүгт буй» гэснээр үнээгээ олж авав. Түүнээс хойно хамаг улсад төлгийг үзвээс үл эндэх тул зен билигт төлөгч хэмээп алдаршив. Хамаг бүгдээр гайхаж

– Ийм мэргэн төлгөч болсон чинь юунаас болов гэвэл тэрээр

Зургаан эвэрт үнээгээ алдаж эс олоод, Малиа ууланд хоносноо дэлгэрэнгүй өгүүлвээс төдий нэгэн баян хүн гурван хөвгүүнтэй юм байжээ. Тэр баян хүн зүйл бүр идээний дээж аваад, тэр булаг хадны дэргэд одоод, урьд хүний ёсоор сан тавьж, «Малиа уул надад нэгэн төлгийг буулга хэмээн хэвтсэнд, шөнө зүүдэнд нь лусын хаад албинийг уриад

– Үүнд нэгэн төлгийг буулгагтун хэмээвээс, албин ирээд тэр хүний эрийн бэлгийг аваад, эм болгожээ. Тэгтэл тэр хүн ичгүүрт болоод бус оронд одвоос, нэгэн гуйланч хүн түүнийг аваад, гурван охиныг төрүүлэв. Тэр цагт тэр хүн

– Би залуу цагтаа эр болж гурван хөвгүүний эцэг болсон бөлгөө. Өдгөө би эм болж, гурван охины эх болов хэмээн, зовлонт үгсээр өгүүлэв. Бас нэгэн удаа нэгэн толгойдоо ашигт (уртай) хүн ирээд, тэр булагт сан тавьж усаар угаагаад «Малиа уул миний ашгийг авагтун» хэмээн хатуу залбирч хэвтвээс, тэр шөнө зүүдэнд лусын хаад ирж тэр этгээдийн албиныг дуудаад

– Аяа, албин чи махыг хэрэглэх бөгөөс илүү махыг өгсүгэй хэмээхэд, албин ирээд тэр хүний ашгийг огтолж аван идэв. Маргааш тэр хүн сэрвээс ашиг нь үгүй болсон ажгуу. Баясан гэртээ хариад баярын хурим хийвзэс, хамаг бүгд гайхаж хоёр толгойтой адил бөлгөө. Энэ хэрхэж үгүй болгов хэмээн гайхалдав. Бас түүнээс өөр нэгэн хүний толгойд уртай ажгуу. Тэр хүн урьд ёсоор булгийн дэргэд одоод сан тавьж залбиран хэвтсэнд, лус нь бас тэр этгээдийн албиныг дуудаад

– Чамд нэгэн махыг өгсүгэй хэмээсэнд, албин нь урьдын ашиг махаа авч ирээд

– Энэ бузар мах бөлгөө. Үүнийг би авахгүй гээд урыг нөгөө баянд нааж тавив. Маргааш сэрмэгц толгойгоо даан ядаж урьд ур дээр нэгэн ур нэмсэнд гурван толгойтой болоод, сэтгэлдээ гэмшиж гэртээ харин одов хэмээхэд төдий Наганжуна багшийн дэргэд ойртсон атал Сайн амгалант хаан

– Хойд хоёр хүнийг гайхалтай хэмээвээс Заяагаа барсан хааны амнаас дуу гарав. Сарвад үл сууна би хэмээж огторгуйгаар нисэн одов.

ШИДЭТ ХҮҮРИЙН ҮЛГЭРИЙН ХОРИН ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Тэндээс одох ёсыг урьдах мэт үйлдэж, Сэрүүн үхээрийн ойд шидэт хүүрийг авахаар хүрээд үүрч ирэхэд бас хүүр энэ үлгэрийг өгүүлрүүн:

Эрт урьд цагт Энэтхэгийн дорно зүгийн нэгэн хаанд дөчин түмэн балгад бөлгөө. Тэр хаанд бүжигч алтан мэлхий хийгээд урнаа өгүүлэгч тоть хоёр белгөө. Тэр хоёрыг сахигч нэгэн хүн байв. Мэлхий тоть хоёрыг өдөр бүр ээлжилж хааны дэргэд авч одоод, мэлхий бүжиг наадмыг өргөх ажгуу. Тоть нь уран сайхан згшгийг өргөж мэдүүлэх бөлгөө. Нэгэн хүн ирээд, хааны өмнө бүжиглэж наадваас хаан баясаж ихэд өглөг өгсөнд, тэр хүн

Өнөө маргааш хаанд надаас янаг хүн үгүй бөлгөө гэвэл, алтан мэлхий тотийг сахисан хүн

Аяа, чамаас алтан мэлхий тоть хоёр илүү буюу хэмээн мэлзэлдэж, маргааш нь хааны дэргэд очоод, дууч хүн дуугаа дуулав. Алтан мэлхийн бүжигт хаан эс ажраад, хүний дуунд баясаж инээв. Сахигч хүн дууч хүнд мэлзээгээ алдсаны тул, уур нь хүрч харьж ирсний хойно, бүжигч алтан мэлхийгээ гадагш гаргаж тавьтал, нэгэн хэрээ ирээд мэлхийг аван одоод, нэгэн хадан дээр идэхийг завдвас мэлхий нь

– Аяа, хэрээ чи намайг идэх бөгөөс усаар угааж идэгтүн хэмээсэнд хэрээ үнэмшиж,

Чиний нэр хэн бэ гэхэд мэлхий

Миний нэр Баатар сэтгэлт гэв. Түүнийг авч одоод, нэгэн хадны хөндийгөөс гарч байх усанд тавиваас, мэлхий хадны хөндийд орон одвоос хэрээ нь «Баатар сэтгэлт» хэмээн дуудвал мэлхий

– Би төгс билигт эс болбоос эрдэнэт аминаасаа тедий хагацмуу. Сэтгэлийн баатар уульхайг гурван эрдэнэ мэднэ гээд, хадны нүхэнд зугтааж одов. Хэрээ нь нэгэн едрийн идэш олсноо хууртаж алдав хэмээн гашуудаад нисэж одов. Урьд хадгалагч хүн ирээд, нүхийг сэндэлж малтвас, мэлхий

Чи энэ булгийн эхийг бүү уудал. Хаан намайг эрх үгүйеэ гууд барьсан белгөө. Хүн чи үүнийг бүү сэндэл. Өдгөө зовлонт боловч хойно чамд нэгэн их шидийг өгсүгэй. Хүн чи сайтар сонс. Би өгүүлсүгэй.

Би цагаан лавай тэтгэгч, лусын хаадын охин бөлгөө. Хааны охиныг угаахыг үзэхээр ирсэнд намайг алтан шанагаар утгаж авлаа. Тэр хүн хойш ирвээс тотийг нь харцага аван одсон ажгуу. Хаан уурлаад «тэр хүнийг аван одоод, засаглаж алагтун» хэмээн захирав. Төдий хааны сайн түшмэл хэмээх ийн өгүүлрүүн:

Энэ хүнийг алваас хойно бидэнд бүжигч дууч олдохгүй. Түүгээр үүнийг хөөж орхивоос зохино хэмээхэд тэр үгийг зөвшөөрч, гурван хүнээр хөөлгөн нэгэн хайнагт хүнсийг ачиж, чулуун гутлыг өмсгөөд, энэ гутлаа элтэл нааш бүү ир хэмээн хөөж орхив. Төдий тэр хүн

– Би зовлонт хүн бөлгөө. Миний адил та гурав юунд зовно. Энэ чулуун гутлыг ус сүрчээд

чулуугаар үрвээс элэгдэнэ гээд тэр гутлыг үрвээс элж цооров. Төдий гурван хүн харьж одов. Тэр хүн хайнагаа хөтөлж, нэгэн их усны захад хүрээд хайнагаа алж идээд, махыг барсны хойно, эврээр үндэс ухаж идэн атал нэгэн шар шувуу цагаан могойг бариад нисэж явахыг үзэж, тэр хүн бүсээ тайлж амандаа зуугаад хөөж явахдаа

Амнаас минь гал шатав гээд зуусан бүсээ газарт орхивоос, шар шувуу зуусан могойгоо алдахад тэр хүн могойг авч ирээд, нэгэн хэсэг евсөнд малгайгаараа бүрхэж тавив. Төдий тэр усан дотроос олон лусын хаад морийг унаад усны хязгаарт гарам эрж эс олоод, нэгэн цагаан морь унаж, цагаан хувцас өмссөн, цагаан хүн ирээд, тэр хүнд

Би цагаан лавай тэтгэгч лусын хаан бөлгөө. Хөвгүүнээ алдаж эс олов. Хүн чи үзэв үү хэмээн асууваас, хүн

Хөвгүүн чинь ямар бөлгөө гэв.

Миний хөвгүүн цагаан могой бөлгөө гэв. Тийм бөгөөс нэгэн цагаан могойг гарьд шувуу авч одон атал, би алдуулж авав гээд, хөвгүүнийг нь гаргаж өгвөөс, лусын хаад баясаж хөвгүүнээ аваад, тэр хүнийг мориндоо сундалж, орд харшдаа авч одоод, хөвгүүнээ олсны тул хамаг лус хурж баярын хуримыг хийв. Төдий тэр хүн суун ядаж,

Би өдгөө харьсугай хэмээж өчвөөс, цагаан лавай тэтгэгч лусын хаан

– Чи надад сайн үйл хийв. Урьд охиныг минь тавьж өгөв. Өдгөө ганц хөвгүүнийг минь олж өгөв. Би чамайг ачилсугай хэмээгээд тэр хүнд нэгэн улаан зүстэй өлөгчин нохой, нэгэн эрээн мяраалж, нэгэн дун таягийг егөөд, үдэж усны захад гаргаад ийн захив.

Эд идээ эрэх бөгөөс дун таягаар мяраалжийг дэлдвээс хамаг зүйл идээ гарна, Чамаас энэ замбутивийг эзлэх дөрвөн хаан төрнө хэмээн удиргуулсныг зааж өгөөд харьж одсоны хойно, нохойгоо хөтөлж одоход өлөгчин нь шөнө охин болж эм нь болоод, өдөр нь нохойн арьсыг нөмөрсөн өлөгчний дүрээр явав. Нэгэн удаа эр нөхрөө явсны хойно, өлөгчин арьсаа мартаж тавиад, маш гуа үзэсгэлэнт биеэ усанд угаахаар одсоны хойно эр нь ирээд нохойн арьсыг түлж орхив. Охин ирээд эрдээ

Өдгөө чи намайг авч явж чадахгүй хэмээн олонтаа сэтгэл зовох мэт үгсийг өгүүлэв. Бас нэгэн удаа их усанд тэр охин биеэ угаахаар одвоос, нэгэн хэсэг үс тасраад усанд одов. Тэр голын адагт ус авахаар ирсэн нэгэн их хааны шивэгчний шанаганд үс нь орвоос шивэгчин аваад тэр үсийг үзвээс, тэр үс таван өнгө болоод, долоон эрдэнээс бүтсэн ажгуу. Шивэгчин тэр үсийг хааны дэргэд авч одоод хаанд өргөвөөс хаан

– Энэ усны эхэнд энэ үсний эзэн нэгэн сайхан охин буй ажгуу. Түүнийг та цэрэг авч очоод авч ирэгтүн хэмээн захиран илгээв. Төдий тэр цэргүүд ус өгсөн явтал тэднийг үзээд эм нь эрдээ

– Аяа, өдгөө бид хоёр хамт явж үл болно. Бус арга үгүй. Нэгэн жил болтол би чамайг аргалж хүлээнэ. Тэр өдрийн болзоо нь бус сарын арван тавнаа би хотын асар дээр гарна. Чи шаазгайн арьсаар дах хийж өмсөөд манай доор ирж бүжиглэн наадагтун. Тэр цагт аргыг би мэдсүгэй хэмээхийн зуур цэргүүд ирэн авч одоод хаанд өргөв. Тэр хүн эхнэрийн үгээр

шаазгай урхидаж алаад арьсыг авч дах хийж өмсөн хойд жилийн бус сарын арван тавны өдөр очиход хаан хатан хоёр хотын асар дээр гарч байсан ажгуу. Дахаа өмсөж ирээд наадан бүжиглэвээс хатан түүнийг үзээд ихэд инээв. Хаан нь хатандаа

Манайд өдий жил болоход элдэв зүйлээр юу үйлдвээс чи үл инээх бөлгөө. Энэ муу хүний наадамд юуны тул инээв хэмээн асууваас хатан:

Тэр дахыг энэ муу хүн өмссөнд өдий чинээ инээв би. Хаан чи өмсвөөс хэдий чинээ инээмүй би гэв. Хаан тэр үгийг зөвшөөж тэр хүнийг дээсээр татаж аваад тэр дахыг хаан өмсөж доор оров. Нөхөр нь хаан болоод тунхаг тараав.

Гаднаас зүс буруу хувцсыг өмссөн хүн би хаан гэж ирвээс нохой тавьж нааш бүү илгээгтүн хэмээн захив. Тэгтэл шаазгай дахт хүн «би хаан байна» гэж ирвээс, нохой тавьж бүгдээр даруй алав. Тэр шинэ хаанаас дөрвөн хөвгүүн төрөв. Түүний их хан хөвгүүн нь нэгэн өдөрт тэнгэр хүний мянган хэлээр номыг орчуулж түг түмэн сүмийг байгуулаад энэтхэгийн номын хаан хэмээн алдаршив. Түүний дүү нь маш идэр аугаа хүчин төгссөн, нэгэн цагт дөрвөн түргэнийг харвасан сумыг хөсөр унагаалгүй барин чадагч эрхийт монголын хан хэмээн алдаршив. Түүний дүү нь нэгэн шар үсний нүхнээс түг түмэн цэргийг хувилгаанаар гаргагч цэргийн ноён гэсэр хаан хэмээн алдаршив. Түүний дүү нь нэгэн өдөрт дөрвөн зүг дөрвөн сартваахь ээлжлүүлж худалдааны хүслийг хангагч чандмань эрдэнэ авч ирүүлэгч барс ирвэс хэмээх эдийн хаан хэмээн алдаршив. Тэр цагт замбутив ертөнц дэлгэрсэн бөлгөө. Тэр цагт Наганжуна багшийн дэргэд шидэт хүүрийг хүргэж ирсэн бөлгөө. Өдгөө энэтхэгийн өмнө зүгийн дундад уулан дахь сэрүүн ой хэмээхийн хадны хөндийд, үхээрийн хүүр нь шидэт алтан хэмээн алдаршиж өдгөөд хүртэл буй бөлгөө. Түүний хойно хүний насны хутаг нэмээд үйлс нь дэлгэрч төр шажин хамаг зүгт дэлгэрсний учир ийм бөлгөө.

БҮЦҮЙ БУЮУ «ХӨВГҮҮН НОМ»-ЫН ДОТОР ГАРДАГ ШАГНЫ АРВАН ГУРВАН ГИШГҮҮРИЙН ҮЛГЭР БУЮУ ШИДЭТ ХҮҮРИЙН ҮЛГЭРИЙН ХОРИН ДОЛДУГААР БҮЛЭГ ОРШИВ.

Тэр ч хаан урьд мэт одсоноос хүүр үлгэр өгүүлсэн нь: Эрт урьд Варнаси улсад Сайн буянт нэрт нэгэн сартваахь байжээ. Түүнд хоёр шувуун түшмэл байв. Нэгэн шувууны нэр нь бядан явагч Сролон хэмээх буй. Нөгөөгийн нэр нь Оюу зүрхт нэрт тоть буй. Тэр сартваахийн Мэкүвал нэрт хатагтай нь өнгө зүс аялгуу тэргүүтэн төгс сайн ажгуу. Түүнд саваагүй нэгэн шивэгчин байв. Тэр шивэгчин нь хичээж бэрх үйлийг хийх бөгөөтөл итгэмжгүй нэгэн бөлгөө. Тэр Варнасийн умар талд Сайн буянт нэрт сартваахийн амраг анд болсон Сайн буянт хэмээх нөхөд байснаас тэр сартваахь нь таван зуун худалдаачныг дагуулж их далайгаас эрдэнэ авч хамаг үгээгүй ядангид тэргүүтнийг тусалъя хэмээн сэтгэж түшмэл эл шивэгчин тэргүүтний ааль явдал итгэлтэй эсэхийг шалгасугай хэмээн Сайн буянт гэрийн эзэнд

– Та намайг одсон хойно хатагтайг шинжлэн үзээд бус өөрийг сахигтун хэмээн зүрхний үгсээр захирч Сролон шувуунд гадаад үйлийг захирах ба Оюу зүрхт тотид дотоод үйлсийг захирч

– Та хоёр гадаад дотоод бүгдийг сайтар хичээ. Мэкүвал хатагтай биеэ хичээсүгэй. Шивэгчин зарахын үйлсээс өөр үгүйн тул, эс захирсан үйлсэд үл орогтун. Би гадаад их далайд эрдэнэ авахаар яваад ирэхийн зуур намайг сайн сэтгэ та хэмээн захираад одсоны хойно, тэр орны хаан Сайн буянт нэрт хамаг ард лугаа найралдах арван гурван өдрийн гайхахаар үзэх мэт үйл хийсэнд балгадын дээрэнгүй ардууд баясгалангаар сайн морь унаж дэзл гутал чимгээр чимсэн олон нехөд сэлт хуран чуулж гайхан үзээд «Би сайн, чи сайн» хэмээх бөлгөө. Мэкүвал нэрт ба шивэгчин хоёр ч үлэмж сайн чимгээр чимж гайхах газар одсонд Сролон шувуу

Эм хүний биед дайсан олон буй. Үйл хөөвөөс нүгэл удирдах буй. Хойно зэм ирэхийн тул өдгөө одохоо боливоос сайн. Ай Мэкүвал чи сартваахийн хатагтай бус уу? Гадаад захирах үйлст намайг захирагтун, захирсны ёсоор хийтүгэй гэхэд саваагүй шивэгчин

Муу шувуу хүний үйлийг яахан захирна. Олон үг бүү өгүүл. Идэш эрээд унгасаа (ноосоо) өрвийлгөж гэртээ суу хэмээгээд, хатагтайн морины цулбуураас хөтөлж одов. Сролон

Ай тотио! Миний идээний хувь ба үйлийн хувийг чи хийгтүн. Муу эм тэр хоёр дайсныг даллаж ирэх буй. Би сэрэмжлэх арга болгоосугай хэмээгээд нисэж одов. Балгадын бэлчирт хүрвээс тоо томшгүй хүмүүс чуулж дуу дуулан олонтаа бүжиглээд «Хэн сайн, хэн муу, хэн нь гайхамшигт бэ?» хэмээн олон үгийг дурдалцана. Тэндээс хуран чуулсны өмнө дэх зовхист арван гурван үест суварга бий. Түүний тэргүүн үе сууж шинжилвээс «Сайн буянт нэрт гэрийн эзэн тэр чуулганы дотор үлэмж гайхамшигтай» хэмээн магтмуй. Тэр нь Мэкүвал хатагтай, шивэгчин хоёрын дэргэд ирээд тэр чуулганы дотроос гарч суварганы дэргэд очоод тэр гэрийн эзэн:

– Энэ өдөр олон хүн чуулсны дотор бид хоёроос үлэмж нь үгүй тул бид хоёр амраг болж явсугай хэмээвээс Мэкүвал хатагтай

Ер гэр дэх аливаа үйлийг эм хичээх бөлгөө. Ялангуяа их сартваахь эзгүй хойгуур энэ үл

зохино. Эр чинийх бус. Цааш харьж одтугай гэхэд шивэгчин

– Хатан минь ээ, тийм үг бүү хэл. Их сартваахь мэнд харьж ирэх үл ирэх нь мэдээгүй буюу. Мэнд ирвээс бидний бие эс үхвээс бие маань үл барагдах буй заа. Та хоёроос үлэмж хэн ч үгүй ажгуу. Энэ шөнө би таныг хүндлээд идээг бэлтгэсүгэй. Гэрийн эзэн юунд ч сааталгүй бидний харшид ир. Хатан ч үүнийг бүү хуур хэмээхэд Мэкувал хатагтай хүзүүн дэх нэгэн оюуг авч тэр гэрийн эзэнд соёрхов.

Тэр Сролон шувуу түүнийг эс таалаад өөрийн гэртээ харьж ирээд Оюу зүрхт тотид

«Сайн нөхрийг олохуйяа маш бэрх

Сайтар итгэгдэх нөхөр бөгөөс нөхдийн майлан буй

Сааралгүй хаалгыг батлаад түлхүүрийг хадгалтугай

Самуун эм дайсныг урьж ирэх буй»

хэмээвээс Оюу зүрхт тоть нь түлхүүрүүдийг авч хадгалаад хаалгыг батад цуургалаад харахад бус өөр дайсан ирэхгүй буюу. Хатагтай шивэгчин хоёрыг ирснийг үзэж тийм үйлийг эс мэдсэн мэт хаалгыг нээж дотор орсон даруй хаалгыг батлан цуургалаад түлхүүрийг нууж тавьсанд шивэгчин

Хоёр шувуу минь ээ, энэ шөнө сэмээр далд аглаг оронд хэвг. Энд их зочид ирэх буй хэмээвээс Бядан явагч шувуу ийн хэмээн шүлэглэн өгүүлрүүн:

«Удирдагч Сартваахийг одсоны хойно

Олон зочдыг хүндлэх үйлс надад хамаагүй буй

Олон өгүүлэхээ байж өөрийн үйлийг хийтүгэй

Өөдгүй шивэгчин хатнаа үл аргадтугай»

хэмээгээд харшийн дээр нисэж одов.

Арван гурван гишгүүртэй шат байсны тэргүүн гишгүүрт суугаад түүнээс шөнө дүлийн цагт зочид хаалганы ойр хүрч ирвээс хаалга нээж зс чадсан тул шивэгчин өгүүлрүүн:

Муу шувууд хаана хэвгэв? Түлхүүрийг авч ир, Зочид хүрч ирэв хэмээвэл Оюу зүрхт тоть

Зочид ирэх ажгуу хэмээн сэрж хаалга баталсан буй. Шөнийн цагт зочид ирвээс дайсан буй заа. Дуугүй суугтун чи. Өдгөө миний сургасан үгээр явтугай хэмээгээд дуугүй болов. Зочид тэр шөнө дүл болтол хүлээгээд хаалга эс нээсэнд харьж одов. Одсон хойно хатагтай

– Их түшмэл ээ, чиний зарлиг зөв буй заа. Энд ирээд идээ зоогло хэмээгээд зул шатаасанд, бядан явагч шувуу шүлэглэж өгүүлрүүн

.«Ичгүүргүй нөхдийг яахан нөхөр болгон итгэнэ

Ялангуяа их сартваахийг одсоны хойно

Ямагт шивэгчин хатны нэрийг хугалан ядав

Идээ умдааныг идэхүйеэ маш бэрх ажгуу»

хэмээн өгүүлвээс тэр шивэгчин

Муу шувуу дуугүй суу. Энэ шөнө муу үйл хийв та хэмээвээс бядан явагч шувуу:

«Сайн шивэгчин ээ. чинийх зөв бөгөөтөл муу үйл хийн ядав чи

Самуун чиний ам чинь саваагүйн тулд

Сайн хатагтайн нэрийг муу болгон ядна уу чи

Сартваахийн ямарваа захирсны ёсоор чин нот Ядам болгон сахив»

Хоёрдугаар өдөр ч урьд мэтээр Мэкүвал шивэгчин хоёр тэнд очсонд бядан явагч ч урьдчилан Оюу зүрхгэд өгүүлснээс суварганы хоёрдугаар үеийн дээр сууж шинжилснээр урьд мэт гэрийн эзэн ба Мэкүвал хатагтай шивэгчин хоёр суварганы дэргэд сууж

Урьд шөнө намайг ирсэнд юунд хаалгаа эс нээв. Бас энэ шөнө одсугай хэмээн зэмлэн өгүүлвээс тэр хатан

Би урьд өдрийн үгсээс үл давна. Тэр мэт үг бүү хэл. Олон хүний дотор тийм гавьяагүй өгүүлвээс муу үг тархаснаар одоо сартваахийн чихэнд сонствоос маш зохисгүй болно хэмээн өгүүлэв. Шивэгчин:

Урьд шөнө муу шувуу уршиг болов. Энэ шөнө магад өөд болж ир хэмээгээд бас хатагтайн хүзүүнээс нэгэн оюу авч түүнд өгөв. Тэр бядан явагч шувуу Оюу зүрхгэд өгүүллрүүн

Ай, урьд шөнөөс нэн үлэмж хичээтүгэй хэмээн өгүүлэн атал хатан шивэгчин хоёр хүрч ирмэгц, хаалгыг батлан цуургалаад түлхүүрүүдийг нуух тэргүүтэн бүгд урьд адил үйлдэв. Шивэгчин

Энэ шөнө хаалгыг батлан цоожилвоос үнэн хэрүүлтэй болох буй хэмээвээс, бядан явагч шувуу

Би үнэнээр хаалгыг үл нээнэ хэмээн өгүүлвээс тэр шивэгчин уурлаж бядан явагч шувууг бариад хол хөсөр хаясанд цогтой үнсэн дээр унав. Бядан явагч шувуу түүнээс эмээлгүй

Огторгуйгаар явагч жигүүртэн би орхин цохивоос зөөлөн үнсэн дээр унав. Үнсийг халдваас гүвж болно биз ээ. Удирдагч сартваахь баясваас ач нь тэр буй хэмээн биеэ сэжин гөвөөд, бас харшийн дээр явах арван гурван гишгүүрт шатны хоёрдугаар гишгүүрийн дээр сууж

«Аяа, Мэкувал аа, их удирдагч сартваахийг иртэл маш их хичээгээд бие сэтгэлээ сургагугай. Уйдваас сэтгэлийг чинь сэргээх нэгэн үлгэр өгүүлсүгэй. Ер их сартваахь бусдын тусын тулд гадаад их далайгаас эрдэнэ авахаар одоод Варнаси дахь хамаг үгээгүй ядуусыг аварсугай хэмээн одсон бөлгөө. Бас ялангуяа бид нарын гэр дэх ямарваа үйлд хичээгээд урьдах хураасан эд таваараа идүүлж хожим хэрэглэхээ эрдэг мөн буюу. Түүний дотроос хатагтай чиний үүрэг их буй. Урьд хураасан эд таваараа хор хомс үл болгон, хойшоогоо ураг садан олон нөхдийг тэтгэхийн тулд шөнө барай бүрий ба үүр гийхэд үл унтан их хичээнгүйгээр хичээж ямарваа үйл үйлдэж өөрийн сангийн мухарт хурах ба над мэт хатагтай болчимгүй хэмээн бусдад яруу зөөлөн үгсээр өгүүлээд, нөхдийг тэтгэхдээ мэргэн ба ихсийг өргөн хүндлэгтүн. Хэрвээ залилагч гарваас чи энэ мэт залхуу хойргоших болбоос эмийн үйлийг үл гүйцмүй. Өөрийнхийгөө тэтгэн үл чадан, өөрийн амиа зуун ядмуй. Тиймийн тул шулуун цэцэн явдлаар явах хэрэгтэй ажгуу. Тэд нөхөд эс болбоос, гэргий та хатагтайн явдал нь бус эр лүгээ амраг болохыг тэвчих хэрэгтэй бүхийн тул садар самууны үүдийг боож, өөрийн ганц биеэ чадан ядан хадгалах хэрэгтэй буй за. Би их сартваахийг ирэхийн өмнө захирсан үйлийг нь үл орхино. Чиний явдлыг үл таална би. Энэ үесэд залхуу хойргошвоос өөрийнхөө гэм бурууг уудлан зэмлэгдэхээс өөргүй. Миний явдал бүгд бусдын тул баталж явдаг мөн буй. Өдгөө нэгэн хуучин хуулийг өгүүлсүгэй.

Эрт урьд энэ оронд эр ганц Ранза нэрт нэгэн хүн бөлгөө. Үйлс нь итгэл явуулах, эд нь сүсэг ба эд гуйж амиа тэжээдэг нэгэн бөлгөө. Тэр нь нэгэн цагт төвдийн хязгаар дахь улсад одоод нэгэн гэрийн эзнээс идээ гуйваас тос гурил хольж

өгсөнд түүнийг авч явгал нэгэн хөгшин гуриухадсан нохой замын уулзварт хэвтэхийг үзээд «Аяа, энэ нохой хүний идээ идэх бөгөөтөл өдгөө ямар ч идэшгүй хэвтэх нь хөөрхий» хэмээн сэтгэж, гар дахь идээг хийгээр ариулж түүнд өгөв. Тэндээс нэгэн улсын төвд одвоос өдий төдий хүмүүс хатгалга өвчнөөр үхсэнийг үзэв. Бас нэгэн сайн харшийн дотор орвоос олон хайнаг морьдын дотор боол шивэгчин үхсэнийг үзэв. Зарим эмс идээ бэлтгэхийн зуур үхсэнийг үзэв. Идэр

залуу хөвгүүн завсар завсарт үхсэнийг үзэв. Ноёд орондоо сууж, идээ идэн байгаад үхсэнийг үзэв. Тэр цагт Ранза нэрт хүн ийн өгүүлрүүн

«Энэлгээт үхлийн эзэн ирсэн цагт

Эмс залуус үзэсгэлэнт болбоос бээр

Эрхгүй хоромхноо үхсэнийг үзэв

Эрхэт хаад ноёд бээр үтэр түргэнээ

Тансаг идээнээс хагацаж бусчир болов

Дахь зарц шивэгчнийг тэсэхгүйгээр

Даруй төдий түргэн үхсэнийг үзэв би

Тийм ёсоор хэзээ үхэх цагт

Гурван эрдэнэ намайг айлдан соёрх

Хуухай эдгээр гэргий таны буян хийхийн тулд

Хурднаа тахилын орон ламыг эрэхээр одсугай

Хутагтныг олмогц энэ гэртээ авч ирье»

хэмээн өгүүлээд гадна гарч төдий нэгэн замд орж одвоос тэмдэгтэй еэ гурван азар лугаа учирч, тэндээс ийн хэмээн үгсийг асууруун:

«Сэжиг алдарсны ёс барьсан гурван азар аа

Сайн их аугаа хүчит буй л бөгөөс

Самуун гэрийн эздийг аминаасаа хагацсаныг үзэв

Сааралгүй тийм гэрт өөд бологтун»

хэмээвээс тэр гурван азар ийн хэмээн өгүүлрүүн:

«Тэмдэгтэйеэ очирт сууринд муутгаж

Дээд авшгийг олоод сайтар сайшаагдсан

Тиймийг үл жигшин таалмуй бид удирдагтун

Тийм харшид одъё»

хэмээсэнд Ранза нь удирдаж тийм гэрт авч одвоос үтэр гурван азар нэгэн хүүрийг эвдэж өндөр их догшин балин хийж гурвуул зулыг шатааж уншихад шөнө дунд болоход их биетэй олон нүдтэй их аймшигт хүн бус чөтгөр ирээд цонхоор үлээсэнд байшин дотор их зул унтраан бууж ирээд, тэр азруудыг үхүүлсүгэй хэмээн завдсанд төдий нэг нь балингаар цохивоос унасан даруй, тэр босоод гурвуулыг үхүүлээд Ранзад,

Тунамал бодь сэтгэлээр эс номхотговоос догшин хилэнгээр яахан номхотгож чадна. Чи гурван эрдэнийг муутгаснаар тонилов заа. Энэ шөнө болон маргаашаас чи аяа бус оронд нуугдваас яахан тонилоно чи, амьдраад идээндээ би одсугай» Аюулт тэр тийн хэмээгээд одов. Маргааш нь тэр их замаар орж одвоос өтөлсөн бинвадач нэг аяга тахимлиг лүгээ учирч түүнд

«Үлэмж амирлан номхотгосон сирван биет дээд богд оо. Нэгэн харшид хортон бээр олны амийг хагацуулаад, түүнчлэн урьд шөнө гурван сэжиг алдарсныг алав. Түүнд өөд болж сүнсийг залваас болно уу? Аугаа хүчин нь тийм болов уу» хэмээвээс аяга тахимлиг ийн хэмээн өгүүлрүүн:

«Аугаа хүчин хаана болох өвгөн надад

Аугаа хүчин их болоод чанарт шингэв

Тийн атал идээний тул тэр харшид одьё

Тэнд өвгөн би үхвээс юуны гай»

хэмээсэнд тэр Ранза сүсэг бишрэл төрөөд залан одвоос бинвад идээ бээр өргөн идүүлээд эдгээрийг үз хэмээн өчөөс, зул ба балин тэргүүтнийг ч хийхгүй хум пад пад тэргүүтнийг үл өгүүлэн илт тугдам сэтгэж суун бүхийд тэр Равза нь урьд шөнө гарсныг өгүүлээд

– Энэ шөнө ч хүн бус догшид магад энд ирэх буй. Ийм бясалгалаар чадна уу. Үл чадна уу хэмээн би айж байна хэмээн өчөөс аяга тахимлиг

Урьд шөнө нуугдсанд эс алсан бус, гурван эрдэнэ ивээсний тул болой. Гурван эрдэнэд сайтар залбир. Урьд би ийм ёсоор ширүүн догшдыг номготгосон юм. Би ийм явдлаар чамайг олонтаа тэтгэн асарсан билээ. Өдгөө ч энэ улсаас чиний тэр улсад модны жимсийг идээд модыг худалдахаар одох цагт би ийм явдлаар догшин амьтныг номхотгоно хэмээн номлоод жич бас цомцойж тугдам сэтгэж суун бүхийд, урьд шөнийн ёсоор тэр олон нүдэт ирээд цонхоор үлээвээс зулыг сөнөөж эс чадсанд доош бууж ирээд үлээхэд тэр аяга тахимлиг хуруугаа инчидсэнд тэр олон нүдэт гэдрэг унасанд тэр цагт аяга тахимлиг

– Чи миний эцэг эх өглөгийн эзэн тэргүүтнийг алаад, миний шавь гурван азарыг алав. Өдгөө тэр гурав хатуу үйлсийг хийсэнд чи товрог болгов. Бус бас энэ балгасан дахь өвчин тахлыг үл таслах бөгөөс бн чамайг товрог болгон нядална хэмээн зарлиг болбоос тэр тангаргаа өгч тангарагт ороод

– Балгасан дахь өвчин тахлыг тасалж үгүй болгосугай хэмээгээд таслав.

Аяа Мэкүвал аа, тэр цаг дахь Ранза хэмээвээс би бөлгөө. Аяга тахимлиг нь сартваахь бөлгөө. Балин хаягч азар болбоос чи мөн. Бус хоёр азар хэмээвээс Оюу зүрхт шувуу, саваагүй шивэгчин хоёр бөлгөө. Тэр цагт хүн бус догшны дүрээр номхотгон эс чадаад, бид нэгэн хамт хоол идэж агсанд хатуу хүчир зогширч болох буюу хэмээн өгүүлснээр шөнийг нөгчөөж үйлдэв.

Бас хойд шөнө ч урьдын ёсоор болсонд бядан явагч шувуу гутгаар гишгүүрийн дээр сууж эртний нэгэн хуучин үлгэрийг дурдмуй.

Эрт урьд энэ улсад Бадам хаан ба Удвал нэрт хаан хоёул байжээ. Удвал хаанд Давзэй нэрт охин. Бадам хаанд Гэсэр, нэрт хөвгүүн бөлгөө. Гэсэрт сайн аальтай эх бөлгөө. Тэр Бадам хаан нь их хүчтэй тул хамаг улс түүний эрхэнд оров. Тэр цагт Давзэй охиныг Гэсэрт өгсүгэй хэмээн тушаав. Бадам хаанд Брэдэ нэрт шивэгчин Удвал хаанд Жидма нэрт шивэгчин байв. Тэр хоёр өөр өөрийн гэр дэх ямарваа үгсийг бие биедээ хэлдэг байв. Тэгж хов хэлэлцсээр тэр хоёр хаанд эс зохилдов. Нэгэн цагт Бадам хаан халив. Тэр цагт Гэсэр түшмэд, харцас, эд таваар бүгдийг Удвал хаанд алдав. Брэдэ шивэгчинд уурлан

Урьд намайг бүгдээр сайн ааштай гэлцэнэ. Муу хэмээхгүй бөлгөө. Чи нааш цааш ховлосоор бид ийм болов гэхэд төдий Брэдэ нь Удвал хаанд оров.

Тэндээс Гэсэр, эхтэйгээ хоёул юмгүйн тул түлээ түүж балгасан дахь хүмүүст худалдаж амиа тэжээдэг байжээ. Нэгэн цагт цас орж түлээгээ авч эс чадаад идээ ч эс олж сэтгэл нь зовж суутал өчүүхэн чөлөө гарч сайн аалыг эх нь түлээ түүхээр одсоны хойно нэгэн Бинвадичийн хаалганы дэргэд ирвээс Гэсэр нь түүний долдойн дууг сонсоод төгс бишрэл төрөөд түүний дэргэд хүрвээс, Бинвадич зарлиг болруун,

– Гэсэр ээ, их эд агуурстай болоод, тэр эд агуурсаа эдлэн чадваас арилсан өглегийн ач үр бөлгөө. Хэрэглэх цагт өгвөөс бас хэрэгтэй цагт түүн лүгээ тохиолдох болой хэмээн зарлиг болбоос Гэсэр

Ач үр төрөхөд шалтгаан хэрэгтэй буй за. Үл зохилдох зүгт баригдаад, гавьяагүй болов хэмээвээс Бинвадич

Нэгэн тутаргаас өөр юмгүй боловч өргөгтүн хэмээн зарлиг болбоос Гэсэр гэр дотроо эрвээс өчүүхэн нэгэн атга тутаргыг олж маш баясаад Бинвадичийг дотогш залваас, тэр Бинвадич

Үүнийг зэс тогоонд чана хэмээн зарлиг болов. Тэр Варнаси дахь хорин ачмаг орох тогоонд чанаваас аривжаад тэр тогоо нь дүүрэв. Бинвадичад бадар аягыг дүүргээд өргөсөн цагт Удвал хааны харшийн орой дээр Давзэй охин буй ажгуу. Тэр түүнийг үзээд холоос нулимс унагасанд Бинвадичийн бадар аяганд тусаж буртаг болгов. Бинвадич атгаггүй идэн суун бүхийд Гэсэр сэтгэл нь зовж, «Буян эс хураасан муу охин, миний өргөн хүндэлсэн идээг буртаглав. Арилжваас хүнд болох, эс арилжваас буртагласныг идүүлэх буюу» хэмээн бодвоос тэр богд лам мэдэж Ариун сэтгэл хийгээд барилдуулсаи буртгийг арилгаад

Ачит орон хийгээд маш арилсан номын чанараар

Аху зуур хязгаар дорно сайн буян болоод

Аяа Гэсэр сайн хотол төгсөж жаргатугай

Эцэг эхийн ач тус. хариульа маш бэрх

Эх юүгээ дотор сайтар тахигдаад

Эгнэгт үл суун одоод олзыг эрэгтүн

Эд агуурсан олзыг би өгсүгэй

хэмээн сургаад үл үзэгдэн одов. Даруй эх нь гэртээ хүрч ирээд чанасан тутаргын тансаг амтанд баясаад амарсан тэр цагт хөвгүүн

Удирдагч адистидласан үүнийг идээд

Үнэн бишрэлээр гэртээ суу

Хөвгүүн би ламын зарлигаар одож

Улсыг авч ирээд өргөн хүндэлсүгэй би

хэмээвээс эх нь

– Тийм үг бүү өгүүл. Чи маш балчир байна хэмээв. Бас хөвгүүн

Өчүүхэн сүхээр модыг унагамуй

Өчүүхэн сумаар зааныг нэвт харван алмуй

Өчүүхэн биетэн их хотыг байгуулмуй

Үл үрэгдэгдэхүй өдгөө явсугай би

хэмээгээд дорно дахь их ой шугуйн дотор одон хүрвээс ямарваа хүслийг хангуулагч гутлыг олов. Бас өрнө дэх ойд хүрвээс өлзийт тэнгэрийн үгээр хүслийг хангуулагч тулмыг өгөв. Төдий өөрийн гэрт харьж ирээд, эхийгээ амьдруулж, хүслийг хангуулагч тулмаас хотол төгссөн эдийг гаргаж эхдээ өгөв.

Тэндээс Удвал хаан «Гэсэр эх, хөвгүүн хоёр эд таваараа үл үзэгдүүлэн жаргахын учир юу болов хэмээн сэтгээд түүнийг булаахын тулд Давзэй охиноо хамаг чимгүүдээр чимээд Гэсэрт буулгаж өгөв. Тэр Давзэй охин Гэсэрийн гэрт хүрсэн хойно үл таалах дүрээр царайгаа барайлгаж суусанд Гэсэр нь хүслийг хангуулагч нэгэн гутлыг Давзэй охинд өмсгүүлээд, нэгэн гутлыг өөрөө өмсөж сэтгэлдээ «Далайн тэр этгээдэд гарсугай» хэмээн сэтгэсэнд, нэгэн агшнаа тэнд гарав. Төдий Гэсэр

– Би чиний эзэн бөгөөтөл намайг үл дагах чинь юу вэ? Чи надаас хагацах бөгөөс өдгөө энд суу» хэмээвээс Давзэй охин маш айж

– Өдгөөгөөс хойш чиний зарлигаас бүү давсугай хэмээвээс төдий Гэсэр нь Давзэй охины өвөр дээр дэрлэж нойрссонд Давзэй охин Гэсэрийг тэнд орхиод хоёр гутлаа өмсөж, «Эцгийн харшид хүрсүгэй» хэмээн сэтгэмэгц хүрэв.

Гэсэр сэрж үзвээс охин гуталтайгаа алга болжээ. Огторгуйгаас

«Гэсэр ээ, ийм далайгаас айлгүй

Хэтэрхий хүчит нэгэн эвэрт амьтныг хөлөглөөд

Хялбар амгалангаар далайгаас гзтэлж

Гэм үгүй эх лүгээ түргэнээ уулзалдмуй. Тийн хэмээн дуу

гарсанд үзвээс нэгэн эвэртэй улаан амьтан дэргэд нь байсныг унаад далайн захад гарав. Төдий тэр амьтан үл үзэгдэн одов. Бас тэндээс халхавч мод олов. Түүнийг аваад нэгэн

балгасны төв дунд одвоос олон хүн чуулж хурим хийж байв. Идээ гуйваас эс өгсөнд зэргийн тэргүүнд суусан нэгэн хүн лүгээ хамт сууж идээ идвээс тэр хүн эс цадаад нэгэн цэцэрлэгт одвоос түүний хойноос дагаж одов. Улаан шар хоёр цэцэг байсны улаан цэцгийг идээд нэгэн бэч болж жимст найлзуур модон дээр авирч жимсийг идээд жич доош бууж шар цэцгийг идээд хүн болов. Гэсэр нь тийм хувилгахыг мэдэж улаан шар хоёр цэцгийг аваад Удвал хааны хаалганы дэргэд очоод их дуугаар

– Хаалганы дэргэд нэгэн их гайхамшигт бэч буй тул хэдэн хоног харшид суулгатугай. Харин хойно надад соёрхогтун хэмээн дуудаад, улаан цэцгийг идэж нэгэн бэч болоод хаалганы дэргэд сууваас түшмэдүүд бэчийг хаалганы дотор авч одвоос тэр бэч хаанд мөргөх ба өргөн хүндлэх тэргүүтнийг хийвээс хаан маш баясаж

– Энэ бэчийг Давзэй охинд минь бүү үзүүл. Үзвээс эзлэн баримуу. Бусдаар үл итгэмүй, хууртуузай хэмээн зарлиг болбоос түүнээс бэч Давзэй охин цааш нааш явахад сөгдөж мөргөх хүндлэх дүр олныг үйлдсэнд Давзэй охин баясаж эзлэн барив. Нэгэн цагт Давзэйн идээнд улаан цэцэг хольсонд идсэнээр Давзэй бэч болсон төдий Гэсэр өөрийн гутлаа аваад байшиндаа харив. Долоон жил бэчний зовлонг эдлүүлж үйлдээд түүнийг хүн болгон хувилгав.

Тэндээс Гэсэрийн тийм хувилгаанаас нь Удвал хаан маш айж түүний улсын эд агуурсыг урьдаас илүү болгон өгөв. Түшмэд айж, гэмүүдээ наминчлаад Гэсэрийг өргөн хүндлэв. Тэр Удвал хаан тэргүүлэн Удвалын хамаг улс ба өөрийн хамаг улсыг номд оруулав.

Аяа Мэкувал аа, аяга тахимлиг Бинвадич бол далайн дундах нэгэн эвэрт амьтан буюу. Нэгэн эвэртэн нь далайд явсан сартваахь буюу. Брэдэ шивэгчин нь саваагүй шивэгчин буй, Жидма шивэгчин нь Мэкувал чи буй. Давзэй охин нь хаалганы гадна сахин суугч гэрийн эзэн буй. Гэсэр хэмээвээс би буй. Сайн аашт эх минь хэмээвээс Оюу зүрхт тоть буй. Тэр цагт ч та хоёр Оюу зүрхт бид хоёрыг зовоосон. Ялангуяа саваагүй шивэгчин чи өөрийн жаргалант орд харшийг эвдсэн энэ ч түүн лүгээ адил гэм гарах тул үйл явдал тэдгээрийг тэвчигтүн хэмээн өгүүлээд шөнийг өнгөрүүлэв. хэмээсээр гадаад үүдний дэргэд хүрээлэн гэрийн эзэн дотор орж чадалгүй буцаад, хатагтай бээр нотод болов.

* * *

Бас хойд шөнө урьдын ёсоор дөтгөөр гишгүүрийн дээр сууж хуучин үлгэрийг ийн өгүүллрүүн:

«Бас эрт урьд өрнө зүг дэх хязгаар газарт ураг садан ба эм хөвгүүнгүй ганц үгээгүй хүн байжээ. Тэр хүн хоёр суулга тутарга тарьж өдий төдий итгэл явуулаад тэр тариаланг байн байн эргэн үзэх ажгуу.

Нэгэн туст сэтгэлт туулай түүний тариа тутаргыг идэж муу болгов. Нэгэн удаа тариагаа эргэхээр очиход тарьсан тутарга нь харагдахгүй болохоор сэтгэл хямарч одоод нум сумаа авч ирээд тариагаа манаж суутал нэгэн туулай ирээд идэхийг үзээд тэр эр ганц хүн

Би энэ тариагаар амиа тэжээх бөлгөө. Чи миний тэжээлийг үгүй болгов гээд харвахыг завдсанд тэр туулай

«Үгээгүй ядангид болсон амьтан аа

Үлэмж сайн хийвээс хариу нь жаргалант болмуй

Үл хямрагтун. Хямраваас зовлонгийн шалтгаан буй

Үгсийг минь сайтар сонсвоос түүгээр жаргах буюу

хэмээсэнд тэр хүн сэтгэлдээ, «адгуусан туулай дэнсэлгүй ном номлох нь сайн боловч тэжээлийг минь үгүй болгов чи. Тийм ач тус хүргэхийн ёсыг асуусугай» хэмээсэнд туулай

Тэгш гөрөөсний хаан туулай би, өөр бус өвсийг идэн атал үлэмж амтат болсон сал тутаргыг идэв. Улам улам идсээр дээд уруул минь сэтэрлээ хэмээгээд инээж суун бүхийд тэр хүн дээд уруул нь сэтэрснийг үзэв. Тэр хүн

«Энэ айлгүй нотлон суухын ёсыг шинжилж үзвээс, энэ нэгэн хувилгаан буй заа» хэмээн сэтгэж ахуйд туулай:

«Аяа, өдгөө тутаргаар дарсыг ихэд хийтүгэй

Аливаа нум сум хэрэгтнийг бэлдэгтүн

Алжааст хязгаар дахь тэнэг хаанд

Асури тэнгэрийн охин мэт нэгэн охин бөлгөө

Үзэсгэлэнт тэр охиныг чамд авч өгсүгэй

Өрнө өмнийн завсар дахь рагшанууд

Үлэмж эд таваар буй атал хүний махыг идмүй

Олон нүгэлтнийг үхүүлээд тэдний эд таваарыг

Сайн ачийг хариулахын тулд чамд өгсүгэй

Сэжгийг тэвчигтүн

Үнэнээр тиймийг хийсүгэй

хэмзэсэнд тэр хүн туулайн зарлигийн ёсоор сайтар бүтээж ардаа үүрээд хувилгаан туулай өмнө нь удирдан яваад хязгаар дахь хааны улсад буй усны захад хүрээд, тэнд аргал ба лонхны хагархай тэргүүтнээр дүүрэн болгож, тэнд олон нум сум хугарснаар хөсөр үлдэмгүй болгож дэлхэн тавиад, морины туурайгаар олон мөр болгож дүүргээд, хааны хаалганы дэргэд хүрвээс тэр хүнийг гадна орхиод туулай хааны дэргэд одоод ийн өгүүлрүүн:

Олон аймаг цэргүүд энэ оронд ирснийг

Улсын эзэн хаан чи эс мэдэв үү?

Үлэмж тэнгэр нар энэрэн сэтгэж

Үнэн үгүй бегөөтөл цэргүүдийг хариулав

Тийм тиймийг сэтгэж өдгөө бээр тахих өгөх

Тэнэгийн ёсоор хязгаарт сууваас

Тэмдэгтэйеэ емнө өрнийн завсарт оршсон

Тэнсэл үгүй эд таваарт

Рагшагийн хаан буй ажгуу»

Болгоохын тул чиний хаалганд ирж баймуй

Буцалгүй охиноо өгвөөс цэрэг үл болмуй

Бүгд улс бидэнд өлзий хутаг оршуулаад

Богд хаан чамд өлзий хутаг оршмуй

хэмээсэнд тэр хаан «Энэ лавтай тэнгэрийн хувилгаан буй за. Бус туулай ийнхүү номлож яахан чадна» хэмээн сэтгэж хариу ийн өгүүлрүүн:

«Хад уулын аглагт суусан

Хайран туулай биет дээд тэнгэрийн манлай чамайг

Гайхамшигт тахилаар тахьсугай энэ оронд суу

Халгар дэнсэхээр ирсэн тэр хүн дотор иртүгэй»

хэмээсэнд еөрийн нэгэн түшмэл тэр хүнийг урьж харшийн дотор авч ирсэнд хаан лугаа сацуу нэгэн дэвсгэр дээр суулгаж өргөн хүндэлвээс тэр хүн айн зүдээд хувилгаан туулайд өчүүхэн дуугаар

«Ай хувилгаан чи уран аргатай буй атал өдгөө ихэд эндүүрэх болуузай» хэмээвээс тэр хаанд сэжиг төрж

– Тэнгэр ээ, тэр юу өгүүлмүй? хэмээвээс туулай

– Хязгаар дахь хаан хэмээх нь эд агуурсаар ихэд омгорхох буй. Охиноо надад егехгүй бөгөөс амгалангаар жаргалангийн улсад одох хэрэгтэй учир, чи хаанд мэдүүлэгтүн хэмээх ажгуу хэмээвээс тэр хаан нь тийм үгсийг сонсож тэсэлгүй айн цочоод таван зуун морьтны хамт тоо томшгүй эд таваар лугаа сэлтийг инж болгон тэнгэрийн охиноо буулгаж өгөв.

Тэндээс хувилгаан туулай удирдаж өмнө, өрнийн зовхист хүн иргэн явж үл чадах Ланка нэрт рагшагийн улсад их хүчит олон цэрэг болон хувилж одоход хувилгаан туулай хүний нүдний үзүүрт урьд яваад, рагшагийн хонь үхэр тэргүүтнийг адуулагч олноор «Ийм юу болов» хэмээн удаа дараа ирсэнд хувилгаан туулай тэдэнд

«Тансаг эд буй атал хүний мах идэгч

Тэдгээр хилэнцэтнийг аминаас хагацуулагч

Тийм хүчит цэргүүд таныг эзлэхээр ирмүй

Та хүндлэхийн ёсоор эдийг авч одоод

Үтэр одож тэр хаанаас амиа гуйтугай

Олон цэргийн төвд цагаан дээл өмссөн

Үлэмжийн нэгэн бөлгөө.

Түүнд Та бидний хаан хэмээн

Үнэн баясгалангийн ёсоор сайн хэмээн магтаад өргө

хэмээн мал адуулагчдад хэр хэмжээ үзэхээр яваа хаанд баясгалангийн байдлаар эд малуудыг сануулсан ба тэндээс нөхөд одож ланкагийн хотын дээд голын эхэнд тийм хортон рагшанууд суух тэр оронд айхын ёсоор хүрч ийн өгүүлэв.

«Дэнсэл үгүй хүчит цэргүүд хүрч ирлээ энд

Хотол байлдваас үл чадмуй. Өөрөө бэрх орныг барь

Гурван эрдэнийг нэрлэж сайтар залбирагтун

Хохой халаг, далдлан нууваас амьтан нь тонилмуй за

Хурднаа зальхайг тэвчээд тийм үйлийг сэдэгтүн

Туулай тийн хэмээн рагшануудыг итгэлд удирдан одож сургасанд рагшанууд их аюултай цэргийг үзээд маш их айж есөн давхар гуу дотор зугтаагаад оров. Туулай ч давхар тутмын хойноос даган

Ивээгч бурханд итгэмүй

Ялангуяа дээд номд итгэмүй

Ил бурсан хуврагуудад итгэмүй

Ямагт нийцүүлэхийг магадаар залбирмуй.

Хохой, есөн давхарт суусан бурхныг эрэн итгэ

Гурван эрдэнэ хэмээвээс бурхан бөлгөө

Хотол бусдаас ивээн хэн бээр үгүй буй

Хойд заяаг сэтгээд бат оронд агсан бээр

Урьд нөгчсөн муу нүгэлт үйлийг наманчилтугай

Улам өдгөө гэмшиглэнт болбоос хожимдох болмуй за

Улам улам наманчилваас хувилгаан удирдмуй за, таныг

Онц гурван эрдэнийг өдгөө бас бас залбир»

хэмээн өгүүлээд нүхний мухарт хүртэл үдэж,

— «Эдгээр хааны цэргээр танай энэлэгдсэн нь урьд төрөл тутамд нүгэл хнйсний үйлээр болов хэмээн сэтгэж тийм олон гэмшиглэнт сэтгэл төрж, гурван эрдэнэд итгэл явуулбаас эдгээр цэргүүд нь үтэр хариад та нар дээр гараад тонилно. Миний идээ нь өвсний охийг идээд усны тунгалгийг ууна. Аглаг хөдөө дэх модонд оршино. Урьд хоёр хөл минь охор болоод өөд газар явахад хурдан буй» хэмээн сургаад дүүлэн дээш гарав. Төдий гэр есөн давхар нүхний амсрыг батад хааж, гэнэт ирсэн бүгдээрийг тоо томшгүй эд таваараар хүндлээд өөрөө авч ирсэн тэр хаанд дээл ба төгс сайн тавцанг засав. Тэр цагт туулай хоцорч үлдсэн хамаг рагша сэлтэст өгүүлрүүн,

Аяа бидний тэдгээр нүгэлт өвөг эцэг хязгаарлашгүй их хилэнц хийсний тул өдгөө тонилшгүй есен давхар нүхэнд ойчив. Өдгөө та нар үгсээ олшруулалгүй хааныг өргөн хүндлээд өдөр шөнө ийн хэмээн өгүүл; «Бурхан ном хийгээд бурсан хуврагуудад бөхийж итгэл явуулаад, манай заяаны эзэн богд хаан чи хүний дайсныг сайтар дарав. Бүгдэд ач тус их болоод биднийг ивээв» хэмээгээд өдөр шөнөгүй тийн унштугай. Тийн эс үйлдвээс амгалан тонилохын аминаас хагацах болно хэмээн захиран сургасанд тэдгээр нь маш айн эмээж насад өдөр шөнө гурван эрдэнэд итгэл явуулав. Бас хувилгаан туулай эчнээ тэр бусдаас далд тэр хаанд ийн сургав.

— Чиний амгалан жаргалан болсон нь гурван эрдэнэд итгэл явуулсанд дулдуйдаж болсон буй заа. Өдгөө өдөр шөнө насад итгэл явуулагтун. Бие дэх бөөснөөс дээших амьтанд хор үл хийгтүн. Миний өгсөн энэ эдээс бус өөр эдийг үл автугай. Тэнгэрийн охин хатнаас бус өөр хатныг үл автугай. Үгсийг үнэн зөв бөгөөд яруугаар өгүүлэгтүн. Ямарваа идээний дээжээр гурван эрдэнийг тахь. Үлэмж есөн давхар нүхний дотор оршигсдыг сүсэглүүлэн бишрүүлээд бурхан ба ном, бурсан хуврагт итгэмүй. Тэдний өр төлөөс ба амины төлөөс огоот арилгах болтугай. Гурван эрдэнэд шүтэж тэднийг огоот удирдан чадах болтугай. Өөрийн хамаг нөхдөд тийн захираад гурван эрдэнэд итгэл явуулах тэргүүтэн буянт үйлсийг эс үйлдвээс

чиний нөхөд ба эдгээр хамаг эд агуурс дайсан болон хөдөлнө» хэмээн захирсанд Дэнсэгч хаан, хувилгаан туулайн захирсан ёсоор дөрвөн үндсэн санваар хийгээд өдөр шөнө тасралгүй гурван эрдэнэд итгэл явуулав.

Төдий хувилгаан туулай нь их ой дотор есөн сар болтол оршсоны хойно Дэнсэгч хааны дэргэд ирвээс тэр хаан,

Өдий болтол дэргэд минь юунд эс ирэв хэмээн зэмлэвээс хувилгаан туулай үл хилэгнэн:

Ай, хаан чиний зөв буй за. Би залхуураад ирж эс чадав. тийн бөгөөтөл явдал минь бодьсад бүхийн тул бодь сэтгэлийг бясалгаж суув хэмээн зарлиг болов. Тэр цагт рагша нь хоёр заяанд жаргалант болов. Дэнсэгч хаан нь энэ ба хойд заяанд үлэмж болов. Түүний хамаг нөхөд ч ил эчнээ хоёрт улам үлэмж болов. Бас хамаг хүнийг жаргаланд оруулснаар жаргалант болов. Хувилгаан туулай нь хязгаар дахь хааныг сайн ураг лугаа барилдуулсанд их үлэмж болов.

Аяа Мэкувал аа, гэмшиглэнт үйлийг үл хийгтүн. Хувилгаан туулай хэмээвээс би буюу. Дэнсэгч хаан хэмээвээс Саваагүй шивэгчин буй. Хязгаар дахь хааны тэр охин хэмээбээс Оюу зүрхт тоть буй. Энэ Оюу зүрхт тоть нь төрөл тутам надад баясгалант үйл хийв. Саваагүй шивэгчинд тэр мэт тус хүргэвээс надад харин хилэгнэж зэмлэвээс би өчүүхэн ч эс уурлав. Тэр цагт миний сургаалд орсноор тэр сайн болов. Энд ч миний ямарваа тийм сургаалд орвоос сайн бус уу? хэмээн зарлиг болсноор шөнийг өнгөрүүлэв.

* * *

Бас хойд шөнө урьд шөнийн ёсоор бядан явагч Сролон тавдугаар гишгүүрийн дээр сууж:

Аяа урьд би амарлингуй зөөлөн үг ээр

Асар үндсэн төрлийг хууль болгон өгүүлэв

Агирч царайгаа уурлалгүй

Аврид мишээгч гэрийн шувуу буй би

Үнэн зальхайг тэвчиж сартваахийн тулд

Урьдын төрлийн сайн хууль өгүүлсүгэй

хэмээн шүлэглээд үлгэрийг өгүүллүүн:

Урьд цагт Энэтхэгийн өрнө зүг дэх нэгэн ойн дотор найман наст нялхын чинээт үгээгүй ядуу хөвгүүн модны жимс идсээр сууж ахуйд дэргэд нь цэрэгт хөвгүүн хүрч ирэв. Төдий удалгүй баялаг дорвилог хөвгүүн ирэв. Тэр гурвуул зохилдон найрч тоглон наадсаар ой дотор суун атал цэрэгт хөвгүүн цэргээр омог түрж цэргүүдийг авчрав. Баялагт хөвгүүн түүнд атаархаж, тансаг эд таваарыг авчрав. Үгээгүй ядуу хөвгүүнд урьд юу ч байгаагүй боловч хожим нэгэн үед таван шар, таван үнээ, таван хоньтон болоод өөр эд тавааргүйгээр тэр гурвуул наадацгаав.

Чингэж байтал хоромхон гуа үзэсгэлэн, сэтгэлд зохист тэйгэрийн охины адил гурван охин тэр ойд хүрч ирээд төдий л удалгүй өрнө зүгийн нэгэн хийдэд одов. Тэр үесэд цэрэгт хөвгүүн өгүүлрүүн:

Аяа, хоёр нөхөр минь миний үгийг сонсогтун

Адилтгашгүй гоо үзэсгэлэнт тэр гурван охиныг

Асар бид нөхөр болгон авбаас сайн

Аугаа хүчээр би авч чадах болно

гэв. Баялагт хөвгүүн хариу өгүүлрүүн:

Эд таваарыг үл таалах хэн ч үгүй тул хүч чадал хэрэглэхгүй. Олонхийг эд таваараар ирүүлж болох тул эд таваарын эрхээр би авч чадна гэв. Үтээгүй ядуу хөвгүүн өгүүлрүүн:

– Юм бүхэн урьдын заяа үйлийн барилдлагаар болдог тул хоёр нөхрийн чадал хүчин, эд таваар ч найдваргүй. Би хүчин чадал, эд таваар үгүй боловч золын зрхээр авчирч болох буй за хэмээв. Түүний үгийг хоёр нөхөр нь үл хайхран

Тийм болбоос мөрий тавьцгаая хэмээсэн тул үгээгүй ядуу хөвгүүн таван шар үхэр, таван үнээ, таван хонио мөрийд тавив.

Долоо долоо хоногт явж авчрахаар болзолдоод эн тэргүүнд цэрэгт хөвгүүн цэрэгтэйгээ яваад долоо хоног болсонд охидыг авч чадалгүй буцаж ирэв. Түүний дараа баялагт хөвгүүн ихээхэн эд таваарыг авч дуудавч авчирч чадсангүй буцаж ирэв.

Дараа нь үгээгүй ядуу хүний хөвгүүн явж хойд дэх чуулах байшингийн үүдэнд сууж байтал, хуурсандаа баригдсан гуйранч эмгэн ирээд

– Чамд юу хэрэгтэй вэ? Хүссэнээ надад өгүүлэгтүн хэмээв. Өнгөрсөн явдлуудыг тоочоод

– Би тэр тэнгэрийн охиныг нөхөр болгох хэрэгтэй ирсэн билээ хэмээсэнд

Тийм болбоос өмнө зүгт явах аваас нэгэн их найлзуур мод бий. Түүний дэргэд сууж ганцаараа шатар тоглож байтугай. Тэнгэрийн охин тэр үед дэргэд чинь ирвээс чи

– Бэлгэ, билгийн охин тэнгэр нааш ирж миний нөхөр болтугай. Би чиний баатар нөхөр болсугай хэмээн өгүүлэгтүн гэж сургав.

Тэр үгийг сонсоод найлзуур модны дэргэд хүрч шатар наадаж суухад Ёвагинийн дүрстэй, үзэсгэлэн гоо, сэтгэлд зохистой идэр залуухан нэг охин ирээд өчүүхэн ширтэн хэлээ цухуйлгаж мишээгээд буцаж одов. Даруйд урьдын гуйранч эм ирээд

– Өдгөө чиний хүсэл бүтэв үү? хэмээв. Өнгөрсөн байдлыг тоочин өгүүлсэнд эмгэн

– Чингэвээс чи энэ шөнө энэ найлзуур модны дэргэд хэвтэгтүн. Энд хоёр шувуу ирэх буй, тэр хоёрын юу өгүүлэхийг сонсогтун хэмээв. Түүний үгээр тэнд нуугдаж хэвтээд харахад тэнд хоёр том найлзуур мод байв. Нэг нь есөн алдын төдий, нөгөө нь арван найман алдын төдий буй ажгуу. Тэр мэт өндөр модны үзүүрт төдий нарны гэрэл шингэсэн цагт тачигнаад их хүнгэнэх дуун гарсанд ажиглан харваас есөн алд модны үзүүр дээр нэгэн маш том гарьд буугаад баруун зүүн этгээдэд гурвантаа бөхөсхийж суурьтай сайнаар тогтон суув. Хэсэгхэн зуур болоход арван найман алд найлзуурын үзүүрт урьдах тэр шувуунаас хоёр хувь том гарьд бууж мөн урьдахын адил суусанд анхны ирсэн гарьд,

Хуушан див та энд ирэв үү? Дорно зүгт их баялаг байна уу? Үлэмж биетний тивд сайн байна уу? хэмээсэнд сүүлд ирсэн нь

Би энд хүрч ирэв. Үлэмж биетний тивд хүн морины хүүр цаглашгүй олон байна. Идээд ходоодны мухар төдийд орж үл цадав би. Залуу очир хөвгүүн чи урьтаж энд хүрч ирэв үү? Зүг нь амгалан сайн байна уу? Идээ хоол элбэг байна уу? Найлзуур модны ёроолд хэн буйг үзэгтүн хэмээв. Зулзаган гарьд

– Найлзуур модны ёроолд нэгэн хүн байна. Юу үйлдэж байгааг үл мэднэ. Гэвч та хэдий чинээ идээгээр хэвлий чинь цадах вэ? хэмээн асуугаад чагнаваас

– Мянган зааны махаар хэвлий минь цадах буй за хэмээж байна гэв. Үүр гийхэд хоёр шувуу нисэн одов. Түүний сүүлд гуйранч эмгэн ирээд:

– Юу өгүүлэв? хэмээн асуусанд урьд ёсоор өгүүлвээс эмгэн буцаж одов. Удалгүй нэгэн үед нэгэн охин мянган том зааны махыг хүргэж ирээд найлзуур модны дэргэд тавиад буцаж одов. Тэр үдэш Хуушан див хүрч ирээд, тэдгээр зааны махыг идэж нэгэн зааны махыг үлдээн модны үзүүр дээр өлгөн ирэв. Хуушан див:

– Залуу очир ирэв үү? Чи тэр зааны махыг үтэр огтлоод модны ёроолд байгаа энэ хүнд өгөөд еөр юу хэрэгтэйг асууж, аль хүссэн түүнийг бүтээгтүн хэмээн өгүүлэв. Тэр ёсоор болгож асуусанд

Үгэзтүй ядуу хөвгүүн надад бэлгэ билгийн дагина хэрэгтэй хэмээсэн тул тэр зулзаган гарьд бууж очоод

Намайг унатугай. Чи бүү айгтун. Би чамайг дагинасын дэргэд хүргэж өгье хэмээв. Тэр хөвгүүн гарьдыг унаж баруун зүгт одсонд хөх дээвэрт цаглашгүй олон харш буй ажгуу. Тэнд нэгэн аймаг хийдийн үүдний дэргэд хүргэж буулгав. Хөвгүүн удалгүй чуулах харшийн дотор орвоос үүдний завсарт солибцон хэвтэж буй арслангууд нь аугаа хүчингүй болж, муужран буй үзэгдэв. Хэтэрч цааш орж очвоос хэн ч үгүй хов хоосон байв. Нэгэн байшингийн мухарт хэвтэж байсан нэгэн дамрыг аваад буцаж гаран гарьдаа унаж дорно зүгийн огторгуйд хүрэв. Ёвагини лугаа уулзсанд тэр дагина дамрыг нь булааж аваад одов. Тэндээс найлзуур модны дэргэд хүрч очвоос тэнд хэн ч ирсэнгүй ажгуу. Бас дахин гарьдаа хүлэглэн унаад өрнө зүгийн огторгуйгаар яван хүрэв. Мөнхүү хийдэд буугаад чуулганы байшингийн дотор орох үед үүдний завсрын солбицсон хүчингүй болсон арслангууд хүч ороод харш дотор нэвтрэн орохыг оролдохын завсар урьдын мянган том зааны махыг хүргэж ирсэн идэр охин ирээд

инээмсэглэн баясгалангийн ёсоор түүнийг дотогш авч орсонд тэнд буман дагина чуулаад тэр хөвгүүнийг «Их баатар» хэмээн эрхэмд өргөмжилж:

Баатар аа, энэ дагиныг чамд өглөө хэмээвээс тэндээсээ бэлгэ билгийн дагина лугаа хамт их риди хувилгаанаар явж урьдах сууж байсан ой дотор хүрвээс хүчит хоёр хөвгүүн өгүүлрүүн:

Бид хоёр мэтийн хүч чадал, эд баялаг ихтэй нь авчраагүй байтал чам мэтийн чадалгүй хөвгүүн тэнд очоод алжаах зүдрэхээс өөр юм олоогүй хэмээсэнд

– Би залхуу хойрго, алжаах явдлыг тэвчсэн учраас дагиныг өөрийн хань нөхөр болгон авч чадав. Гэвч миний ариун ёс нь бусдын тусыг бүтээхээс еөр зүйлгүй. Мэлзээнд тавьсан мөрийг өгвөөс сайн буй за. Мерийгөө сайн егевч хилэнцэт сэтгэлээ тэвчиж хэзээд баясан мишээж явагтун хэмээгээд шар тэргүүтэн арван таван тооны малыг буцааж шуналд автсан тэдэнд егөв. Хоромхон зуур дагина хүрч ирээд

– Надад тэр муу мөрийн юм хэрэггүй. Өдгөө энхийн оронд одъё хэмээгээд явцгаав.

– Аяа Мэкүвал аа, чи үгсийг минь сонсогтун. Үгээгүй ядуу хөвгүүн хэмээгч нь би мөн. Цэрэгт хөвгүүн нь шивэгчин мөн. Шивэгчин чи тэр үед мэлзээ тавиад намайг их муугаар энэлгэв. Баялагт хөвгүүн тэр ч Мэкүвал мөн. Охин тэнгэр нь сартваахь хувилгаан мөн тул та нар хожим гэмшилтэй болуузай, мэдэж авагтун хэмээхэд шөнө өнгөрөв.

* * *

Бас маргааш үдэш нь урьд мэт бядан явагч Сролон зургадугаар гишгүүрийн дээр суугаад ийн хэмээн өгүүлрүүн:

Үлгэрийг минь сонс. Мэкүвал, шивэгчинн хоёр оо

Өөдгүй тийм үйлээ байваас ичгүүрийг мэдсэн буй

Тийм үйлээс амрагаас хагацах болуузай

Тэр хаалган дахь хүн дотор орвоос их зэмт болмуй

Тачаангуй сэтгэлээр үл болохыг хийвээс

Дотор гэмээр гэмшиглэнт болмуй за, хатагтай аа

Авир муут нөхдийн аргад орвоос муу болмуй за

хэмээн өгүүлээд

Урьд цагт Малиа нэрт уулын ойролцоо Сарва хэмээх нэгэн хаан байжээ. Тэр хааны нэгэн эм нь эд агуурсгүй, хөвгүүн ч үгүй тул машид зовж ядарч байв. Хожим түүнээс нэгэн хөвгүүн төрж тэр нь бусад айлын мал адуулагч болж эхийгээ тэжээн асрав. Нэгэн үед нэгэн сайн оюуг олоод маш их баясаж тэр оюуг эхдээ өгвөөс эх ч баясаад хөвгүүнийг дотогш дагуулан ороод

дарсыг өгөв. Түүнийг уух гэж байтал нэгэн зөгий нисэн ирээд ууж буй дарсан дотор нь унаж үхэв. Түүний дараагаар бас нэгэн зөгий ирж «Даамал жадат» хэмээн зөгийн нэрээр дуудаж

Амьд уу, үхсэн үү, хааш одов? хэмээн сайхан муухай дуун гаргаж уйлан уйлсаар Тэр минь өдгөө үгүй болжээ» хэмээн ихэд гасалж байхыг үзээд түүнийг өрөвдөвч инээд алдав. Муу эх тэрээр ажиг авч

– Хэрэггүй атлаа чи юунд инээв хэмээн асуусанд тэр хөвгүүн нь зөгий ирсэн байдлыг үнэн шударга егүүлсэнд эх нь түүнийг худал хэмээн хааны дэргэд хүрч очоод

Аяа хаан аа, миний үгийг сонсон айлд. Ер нь би адуулагч муу хүүдээ хааны засаг цаазаас үл айн дарсыг өгвөөс хариуд хайрлаж тэтгэсэн эх намайг доромжлон инээж худал үгээр намайг хуурах болж байна. Түүнийг засаглаваас зохих ажгуу, хаан минь хэмээвээс тэр адуучныг халуун гуу дотор орхив. Түүнийг зовлонгоор энэлж байхад буудай идэгч нэгнээр (оюу зүрхт буудай идэгч болон төрсөн) адуулагчийн дээр усан болорыг хаясанд түүний сэрүүн гэрэл халуун зоорийг дүүрч сэрүүн болгосонд хаан түүнийг үзээд баясаж түүнийг дээш татан гаргав. Тэр улсад энэ үеэр ган болсонд адуулагч «Улсад тус хүргэсүгэй» хэмээн сэтгэж хур буулгаад тариа будааг арвижуулсанд тэндээс лус бээр, адуулагчийг лусын оронд залж гурван шөнө морины онгоцонд суулгаад

– Энэ газар юу ирвээс барь хэмээн өгүүлэв. Дэргэд нь мэлхий, могой, эвэрт хорхойн дүрстэн гурвуул цуварч ирсэнд сүүлчийн эвэрт хорхойг бариваас тэр нь машид гоо үзэсгэлэнт охин болов. Удалгүй лус, эд агуурс ба охиныг хамтад өгч тэр хоёрыг хүний оронд хүргэсэн ажгуу. Тэр охин их орд харшийг хувилгаанаар бариулаад, өөдгүй хамаг гэмүүдийг өөрөөсөө хариулаад энх жаргалаар суув. Тэр адууч хамаг улс гүрнийг тансаг олон хувилгаанаар номд оруулав. Аяа Мэкүвал чи миний үгсийг сонсогтун. Тэр цагийн тэр адууч нь би мөн. Хаан нь чи мөн. Адуучийн муу эх нь саваагүй шивэгчин энэ мөн. Шивэгчин чи тэр цагт бас хөвгүүн болон төрөөд үхэр адуулсны хөлсөөр тэжээсний хариуд туст сэтгэлт хөвгүүн намайг хэрэггүй халуун зооринд орхисныг бодогтун. Тэр цагийн усан болор хаягч тэр нь Оюу зүрхт бөгөөд буудай идэгч болон төрөөд намайг халуун зоориноос гаргаж туслав. Тэр үеийн лусын өгсөн охин нь тэр Оюу зүрхт мөн амой. Тэр цагт охин болж орд харш байгуулаад надад

– Сэтгэлээ бүү зовоо, бүү айгтун хэмээн сайтар захиж өөрийн ой дотор алга болсон болой. Одоо ч Оюу зүрхт олон удаа мнний сэтгэлийг сэргээж байгааг мэдтүгэй хэмээхэд шөнө өнгөрөв.

* * *

Басхүү урьд шөнийн ёсоор бядан явагч Сролон шатны долдугаар гишгүүр дээр сууж:

«Үгийг минь сонсогтун. Мэкүвал шивэгчин хоёроо

Өгүүлэвч үл уйлваас галзуу мөн буй за

Үнэнээр иймийг үзүүлэвч үл тонилох бөгөөс

Үнэхээр эм шулмас мөн нь дамжиггүй буюу

Үлэмж шивэгчин ээ, миний үгийг сонс

Өнгөрсөн явдлыг чинь өгүүлмүй би»

хэмээн өгүүлээд энэ үлгэрийг хэлрүүн

Урьд цагт нэгэн хотод хулгана яраар өвдсөн нэгэн хүн тэр хотын бэлчирт идээ хоол ч үгүй, хань нөхөр ч үгүй өвчинд энэлэгдэж, ялангуяа босож үл чадан хэвтэж байх цагт Эрдэнийн манлай хэмээгч бярман машид ариун явдалт хүрч ирээд түүнийг үзэж нигүүлсэхүй сэтгэл төрж, түүнийг үүрч аглаг оронд хүргээд идээгээр асран тэтгэж байв. Тэр мэт өвчтэйд бусад хэн ч ойртож үл очих бөгөөд хамаг бүгдээр түүнийг

«Хань үгүй, хулгана ярт» хэмээн нэрлэн дууддаг байв. Тэр бярман түүний дэргэд дахин дахин ирж их нигүүлсэхүйн зорилго ба итгэл явуулахын зорилгыг зааж өгөөд үсгүй зөөлөн дээлээр хучив. Үхээр цуст шархыг зөөлөн эелдгээр угааж, сайн эмээр ч анагаахад тэр цагийн хэрцгий муу ардууд

– Чи бярмань язгуураас шантрав хэмээн түүнийг хачлан муушааж басан доромжлов. Чи түүнийг хорлосон ч баясгасан ч тэр үл мэднэ хэмээн өгүүлэлдэв. Тэр цагт Эрдэнэсийн манлай хэмээгч нь настан бусдыг үзсэн цагт тун харамгүй өглөг өгөхийг таалж, бусдад ямар ч сайн эд таваар буй бөгөөс түүнд үл атаархан үл тачаамуй. Онц муу болбоос аргаар солихыг таалах, бусдын сэтгэлийг сахихын тулд хамаг хэрүүлийг тэвчмүй. Ямарч муу үгийг хэлэвч түүнд хүлцэнгүйгээр хүлцсэн нь Садва миний дүр явдал мөн бөлгөө. Аяа, сайтар онож мэдэв үү, саваагүй шивэгчин ээ. Эс мэдвээс би тодорхой өгүүлье. Сонсогтун. Эрдэнэсийн манлай хэмээгч бярман нь би мөн. Өвчнөөр шаналагч тэр нь чи мөн. Тэр цагт ч чиний тулд би тэсвэрлэшгүй хатуужлаар чамд тус хүргэлээ. Тийм үйлийг умарталгүй, үл баясах чинь юун. Дээрэнгүй омгоо орхиод чинээгээрээ явбаас сайн болмуй. Эгнэгт хэлсэн үгээр явбаас зцэст жаргах болмуй за. Аяа, Мэкүвал чи тэдгээрийг чихэндээ сонсож, шивэгчний хэлэх ёсыг ч огоороод, шивэгчин ч биеэ сайтар сахиваас, манлай сартваахийн хойно ирэх цагт нүүр бардам баясгалан дүүрэн баймуй хэмээн хэлснээр шөнө өнгөрөв.

* * *

Бас урьд шөнө ямар болсон тэр ёсоор хойд шөнө бядан явагч Сролон шатны наймдугаар гишгүүр дээр сууж энэ үлгэрийг өгүүллрүүн:

Урьд нэгэн цагт Цогт уулын хөмхийд аяга тахимлиг ариун сайн даяанч хэмээх бээр аглагт хатуужлаар явж байсан бөлгөө. Тэр цагт балгадад сэрэмжгүй үхэр адуулагч өдөр бүр аяга тахимлигийн дэргэд сүсэглэн хүрч ирдэг боловч самуун их дуугаар бархирах үед аяга тахимлиг

«Чи урьд үеэс ч сэрэлгүй үйлийг үйлдсэний эрхээр өдгөө үед гавьяагүй адуулагчийн биеийг авч төдий чинээ олон адгуусыг хадгалахдаа өөдгүй их бархиравч зүдрэл төдийгөөр өнгөрмүй. Өөрт өчүүхэн төдий эрхгүй, онц их бархирваас даяанд минь саад болмуй за. Үнэхээр бишрэл

төрвөөс дэргэд минь сайтар суу. Хэтэрхий чамайг ивээгч бурхан ч буй. Хэзээ бээр барагдахгүй амгалан жаргалан буй. Хэнд ч эс булаагдах сайн эдийг өгмүй би. Түүнээс бусчир аваас үүнд бүү суу. Тэртээ оронд одогтун хэмээн өгүүлэв. Адуулагч өгүүллүүн

Аяа, та толгой дээрээ оногдоогүй болохоор дагаж үл мэдэх охор сэтгэлтэй аж. Би сүсэглэж таны дэргэд хүрч ирсэн билээ. Сэмээр суухаас их дуун гарваас хилэгнэмүй. Энэ олон адгуусыг хадгалахад дуугүй сууваас тэднийг яахан хадгалж чадна. Эдгээр адгуусыг хадгалан эс чадваас энэхүү насандаа үгүйрэн ядуурч идээ хувцсыг үл олно. Амиа тэжээх үйлийн хэрэгцээг идээ дээлийг олж үл чадна хэмээн сэжигдэх тул ажлаа сайтар хийхэд минь чи чингэж бүү өгүүлэгтүн хэмээн сөргүү үгийг хэлсэнд сайн даяанч түүнийг нигүүлсэж тархаж бэлчсэн адуунуудыг даруй нэгэн агшинд түүний дэргэд хураан авчраад адуулагч муу хөвгүүнд өгүүллүүн:

– Тал тал руу гүйж тачигнасан шуугиан ил гаргав уу? Сайн даяанч би сарнисан адгуусыг чинь сайтар цуглуулж хураан авчирсныг сая чи үзсэн буюу. Хэтийн тусыг хэрэглэхээр хичээх аваас үүнтэй адил болно хэмээн хэлсэнд тэрээр үл сонсон өөр тийшээ одохын замд хөлд нь модны залтас шаагдсан учир зовж бархиран сууж авай. Тэр цагт сайн даяанч мэдэж түүний дэргэд хүрч очоод нэгэн агшинд хөлийг нь анагааваас адуулагч үл баясан

– Чамайг энд эс ирсэн ч миний хөл амар байсан юм. Одоо би өөрөө эдгээсэн тул бие сэргэж амар болоод өдгөө зохистой байна хэмээв. Тийнхүү ачийн хариуг үл сэтгэн өгүүлэвч сайн даяанч үл хилэгнэн түүнийг анагааснаар үл барам элдэв аргаар сайн төрөлд оруулжээ. «Аяа, Мэкүвал чи мэдэх буюу. Тэр үеийн сайн даяанч нь би мөн. Сэрэмжгүй адуулагч нь энэ шивэгчин мөн бөлгөө. Шивэгчин хэзээд ийм авир ёстой тул тэр үед ч бас тийм авиртай байсан бөгөөд өдгөө ч амрагийг хутгалан сарниулж байгааг мэдтүгэй» хэмээхэд шөнө өнгөрөв.

* * *

Бас маргааш нь урьд шөнийн ёсоор бядан явагч Сролон шатны есдүгээр гишгүүр дээр сууж ийн хэмээн сургав. Есөн хоног болохын цагт тэр гэрийн эзэн хоног тутам хаалганы дэргэд ирэхийн болзоонд тансаг хатагтайн чимэг есөн оюуг алдваас Оюу зүрхт нь сэтгэл баттай тул хаалгыг чандалж огторгуйд ийн тийн дэрвэн нисээд өгүүллүүн:

Удирдагч их сартваахь ирэх цаг болов

Үнэнээр найман хоногт хувилгаан шувуу нь

Үтэр тонилохыг дурдаж ном үзүүлвээ:

Асар өдгөө бээр саваагүй шивэгчнийг эс номготгов

Аяа зүрхгүй Мэкүвал хатагтай аа

Ачит миний энэ үгсийг сэтгэлдээ онож сонс

Ав аль өөрийн сайн аалиа бүү эвдэгтүн

Хэрэв гутваас муу буй, нотолвоос сайн буй

Гийгүүлэгч их сартваахийн ирсэн цагт

Гэмшиглэнт болоод балгас дахинаа элэгт болмуй

Гээж гэртээсээ гадагш гаргах болуузай.

Тэмдэгтэйеэ чин нот эс сууваас гавьяагүй болмуй.

Тэр бядан явагч шувуу бас ийн өгүүлрүүн:

«Та хоёр сонс! Сайн хуучин үгсийг өгүүлмүй

Тансгаар урьдын сайн хуулийг

Энэ өдөр есдүгээр газрын тавцан дээр

Эндүүрэлгүй та хоёрын сэтгэлд оруулан номлосугай

Эгнэгт бишрэлгүй боловч үнэн хэмээн сэтгээд

Энэ увдисыг сонсогтун, ичгүүргүй хоёр

хэмээгээд энэ үлгэрийг өгүүлэв.

Урьд цагт сэрүүн ойд үхэгсдийн ясыг дэвсгэрт дэвсэж хүүрийн дээлийг өмсөж, үхдлээр хооллон асар атгаг үгүй, өөрийн тусыг огоорч, би хэмээх үзлийг эвдэн, өөрийн дураар үхдлийн хэвтэрт оршигч Егүзэр сууж байв. Тэр цагт нэгэн улаан чоно ирж олон хүүр байсаар атал Егүзэрийг идэхээр довтолж тохуурхан хөшилдөв. Тийнхүү идэхээр завдаж байхад нэгэн улаан хүн гэнэт гарч ирээд тэр чоныг хөөв. Үхдэлд хэвтэгч Егүзэр

Аяа, их хүчит улаан хүн чн нааш иртүгэй. Мах идэгч тэр чоныг үлдэх нь зохисгүй ажгуу. Амьтанд ойр хол гэж бүү ялга. Мах идэгчийг тэнд нь орхиж асрангуйн илдээр онож цавчаад мэс хутгаа хаягтун. Энэрэн нийгүүлсэхүйн жадаар орчлонгийн амийг тасал. Мэс жадаар чонын амийг бүү тасалтугай. Эс бариваас билгийн сумаар холоос харвагтун. Гүйцэж үл баригдах тул чоныг сумаар харвахаа орхигтун. Тийн болбоос мэргэн аргын манлай мөн болой» хэмээн хэлэвч тэр улаан хүн үл зөвшөөрөн нийгүүлсэхгүйгээр нэгэн сум харвасан тул өлөгчин чоно шархдав. Тэр цагт үхдэлд хэвтэгч Егүзэр нигүүлсэж босоод түүний дэргэд одож махнаасаа огтолж өлөгчин чононд өгсөнд удалгүй шарх нь эдгэв. Түүнээс элдэв уран аргаар түүнийг мөрт оруулав. Өлөгчин чоныг бариад асар атгаг үгүй дүрээр түр оршсоноос нэгэн үе болоход тэр чоно хүний толгойгоор эрих хийж зүүсэн ба ясан чимгээр чимсэн улаан өнгөтэй, хилэгнэх ба мишээхийн дүртэн болоод, баясгалант бичгийг үйлдсээр Егүзэрийн өмнө хүрч ирээд

Аяа, үлэмж их сэжиг алдаршсан аа, би таны юу дуртайг өргөө хэмээсэн тул Егүзэр

Тийм болбоос мах идэгч үүний сүнснийг удирдагтун хэмээсэнд тэр цагт тэр зүрхээ гаргаж үзтэл хоосны гэрэлд шингэв.

Аяа, Мэкувал чи мэдэж байна уу? Сэжиггүй хүүрт хэвтэгч нь би мөн. Улаан өлөгчин чоно нь шивэгчин мөн. Сумаар харвасан улаан хүн нь Оюу зүрхт мөн. Урьдын явдлаар үзвээс энэ хэр шивэгчин тонилж болох бөгөөтөл өдгөө нисваанисын эрхэнд автаж Мэкувал чамайг ч нисваанист оруулахыг хүсэж байна. Шивэгчин чи муу үйлээ одоохон орхиж сэтгэлээ шинжил хэмээсэнд шивэгчин,

– Тэр мэт үгс нь үнэн болбоос гэмгүй сайн буй за. Тийн боловч чиний үгэнд би сэжиглэж байна. Аятайхан үлгэрийг жигдлэн эвлүүлсэн ажгуу. Тэр үнэн аваас би чиний юу өгүүлснийг дагаж явахаас замгүй. Үлэмж хатагтайн есөн сайхан оюу чимэг үл болох хүний гарт орсныг буцааж авах бэрх ажгуу. Түүгээр үл барам удирдагч их сартваахь хүрч ирээгүй тул үнэхээр энэ шөнө дураар баясалцъя. Сартваахийн байхгүй хойгуур наад нь ганцхан хоног төдий ч амгалан дэвсгэрт дураараа баясалцаж гэрээ хамгаалах хэрэгтэй хэмээсэнд бядан явагч шувуу өгүүлрүүн:

Үүр гийх үе сартваахь ирэх буй

Өдгөө үүр гийх цаг болсонд

Энх амгалант дэвсгэрийг шээсээр яахан дүүргэмүй

Магад сартваахь ирэх цагт ихэд баясах буй

Мэндээр сартваахь лугаа уулзваас ач нь тэр буй за

Мэкувал тийм тиймийг сэтгэж эеэр авагтун»

хэмээн өгүүлэхэд есдүгээр шөнө өнгөрөв.

Бас маргааш шөнө нь урьд шөнийн ёсоор бядан явагч шатны аравдугаар гишгүүр дээр суугаад ийн хэмээн өгүүлрүүн:

«Хатагтай шивэгчин та хоёр үгийг минь сонс .

Харштан ичгүүр сонжуурыг мэдэх хүмүүс

Хамаг ертөнц дахины магтагдахуйн орон болох

Ханашгүй үзэсгэлэн чимэг юуны хэрэг

Амарлингуй зөөлөн сайн үгт уран болбоос

Аяа, хамгийн сэтгэлд таалан асрагдмуй

Атгагт шивэгчний үгийг огоорогтун хатагтай аа

Аврид сайн нот сэтгэл явдлаар явгугай

Эс мэдэж үйлдвээс гэм нь өчүүхэн буй

Уран цэцэд мэдэн атал үйлдвээс хэр зохимуй

Үнэнээс тийм үйлийг хийвээс ёсноос хагацмуй

Үргэлжид чин багтай оршигтун»

хэмээн өгүүлээд энэ үлгэрийг хэлрүүн:

Урьд цагт өчүүхэн нэгэн тивд өчүүхэн нэгэн сайн хаан байжээ. Түүний хатан Төгс гэрэлт нэрт байв. Хааны хөвгүүн Бэлгэт гэрэл хэмээгч бөлгөө. Сайн нөхдөөр хүрээлүүлж цог жавхлангаар чимэглэж амар жаргалантай сууж байв. Хаан хөвгүүн Бэлгэт гэрэл нь ой дотуур наадахаар одсонд тэр ой дотор хязгаар нутгийн нэгэн хаан дайралдаж Бэлгэт гэрэл хаан хөвгүүнийг барьж аваад хөл гарыг хүлж модон дээр өлгөөд орхив. Нэгэн түшмэл хаан хөвгүүнийг эрж тэр ойд очсонд Бэлгэт гэрэл хөвгүүнийг модонд өлгөснийг үзээд гэртээ харьж хаанд айлтгаруун,

Хааны хөвгүүнийг тэртээ ой дотор хязгаар нутгийн хаан модонд өлгөж орхисон байна. Би харсан боловч эсэргэлдэж үл чадсан учир түүнийг яах билээ? хэмээн айлтгав. Тэр цагт хаан төмөр нум сум, зэс зэвийг саадагт хийж зүүгээд маш аймаар дүртэй болж тэр ойд хүрч очив. Тэнд хязгаар нутгийн хаан тоо томшгүй цэрэгтэйгээ сууж байгааг үзээд тэдний төв дунд очиж сумаа онилж нумаа дэлж тэдний том модыг харвасанд тэр мод өнхөрч ойчихдоо олон модыг дарж унагаав. Хязгаарын тэр хаан айн цочоод

– Дэнсэлгүй их хүчит чи хэн бэ? Юу таалснаа өгүүлэгтүн. Чиний юу хэлсэн ёсоор би бүтээсүгэй. Бидний амийг ивээсүгэй хэмээхэд сайн хаан,

Миний төрсөн хөвгүүнийг чи учир утгагүй юунд хүлж алахыг оролдсон бэ? Аугаа хүчнээр уулыг нурааж чадах бөгөөтөл түр уур хилэнгээ дарж уг учир шалтгааныг асуусугай хэмээсэнд хязгаар нутгийн хаан биширч ийн өгүүлрүүн «Та үлэмж их хүчтэй атал намайг энэрэх бөгөөс муу үнэг их арслантай эсэргэлдэж хэрхэн чадах вэ? Таны зарлигийг машид үнэмшиж, таны энэ хөвгүүнийг шархдуулалгүй тавиад энэ хөвгүүнд эрхэм охиноо эд таваар сэлттэй өргөө би хэмээн өчсөнд сайн хаан,

Тэдгээр надад хэрэггүй боловч асрах сэтгэлээр чиний хэлснийг сонсож мэдэв хэмээн соёрхов. Чингээд, тэднийг аливаа мэргэн аргаар дээдийн номд оруулан зохиожээ. Мөн хөвгүүн Бэлгэт гэрлийг ном хийгээд эдээр хангаж зохиов. Тэр цагт Бэлгэт гэрэл хөвгүүн нь урьдын ачийг үл сэтгэн эцгээ ийн зэмлэрүүн

Чи алах зохистойг юунд эс алав. Гавьяагүйг юунд гавьяат болгон асрав. Дэмий амьтан байна хэмээв.

Аяа, Мэкүвал чи миний үгийг сонс. Тэр цагийн бага тивийн хаан нь би бөлгөө. Төгс гэрэлт хатан нь чи мөн. Хан хөвгүүн Бэлгэт гэрэл нь шивэгчин мөн. Энэ шивэгчин нь тэр цагт ч эцэг эхийн ачийг үл сэтгэн сөргүү үг егүүлэв. Үүнд ч сайныг сайнаар үл хариулан, муу үгсээр буруушааж нөхдийг буруу замаар удирдаж байна. Аяа Мэкүвал аа, тэр цагт би хязгаар нутгийн тэр хааныг алваас хойдын амины өр төлөөс ч одоо хүртэл байх билээ. Тэр оронд олноор хямран босох аваас тэр улс дахь маш олон цэрэг хутгалдан үхвээс одоо ба хойд заяанд амины төлөөсөөр бид бүгд зовох болмуй. Тэр цагт бага хаан хатан, хөвгүүний муу үгийг анхааран аваагүй нь сайн болсон тул тэдгээрийг мэдэж авагтун хэмээн өгүүлсэнд шөнө өнгөрөв.

* * *

Бас маргааш шөнө нь урьд шөнийн ёсоор бядан явагч шувуу шатны арван нэгдүгээр гишгүүр дээр сууж ийн хэмээн өгүүлрүүн:

Залуу хатагтай шивэгчин та хоёр үгийг минь сонс

Заяатныг барилдуулах түлхүүр буй

Зальхайгүй бишрэлтнийг арвитгахын шалтгаан буй

Зардсан нөхдийг тэтгэгч увдис буй

Өтгөс ихсийн өгүүлэх шастир буй

Үзэсгэлэнт залуусын тогтоох ном буй

Урьдсын болсон хууль буй

Үлэмж мэргэн хүн уух рашаан буй

Аяа Мэкүвал аа, шөнө дэх уйтгарыг сэргээгч буй

Арван нэгдүгээр гишгүүрийн дээр сууж

Асар бядан явагч хувилгаан тэнгэр шувууны

Аврид төрөл тутамд сартваахийн

Хэзээ бээр идэгдэхүй нөхдийн манлай буй

Хязгаар дахь рашааны арцсын модонд

Гэгээн үзэсгэлэнт хувилгаан тэнгэрийн хувилгаан шувууны

Хамт ямарваа үйлийг тэд үл үйлдэх болоод

Тэнд рид хувилгаанаар амьтныг бэлбэсэн болгомуй

Тэр цагт сартваахь нь намайг нигүүлсэж

Дээд баясгалант тэр оронд

Тансаг живангарид өгмүй за, хувилгаан шувуу

Надад ялгуусны далайн эрдэнэсийн төвөөс

Ямагт олон сайн эрдэнийг олоод

Илээр сартваахийн ач тусыг хариулаад

Илт тэр цагт саваагүй шивэгчин чи бээр

Тэнгэр уулын хөмхийд тэнгэрийн шувуу бидэнд

Тэнгэрийн сартваахь болж бүрүн:

Тэмдэгтэйеэ өдгөөх үлгэрийг тэнд номломуй за

Тийм сайн үгсийг өдгөө номлосон үүнээс бээр

Сайн авьяасыг маш сайтар боловсон болгож

Саваагүй шивэгчин чамайг тэнд бас боловсон болгомуй

Сааралгүй тэндээс хамаг төрөл тутамд бээр

Сацлалгүй миний зүрхэн мэт болж л

Тэндээс хамт тонилохын мөрт оруулах болтугай.

Тэнгэр уулын хөмхийд ургасан

Тансаг сайн арцын ойтой адил

Дэлхийн өдий төдий лянхуа цэцэг оршсон

Бодьсад модны дэргэд агсан цагт

Бүгд ёс нь сайвар одсоны тэргүүнтэй адил

Бүрэн нүүрийн дээр хийд сүм дэлгэрээд

Буцалгүй тэргүүн эцэст сайн буянт

Ус нь тасрашгүй үргэлжид дуурьстугай
Үргэлжид саваагүй шивэгчин мэт номхотгогдохууныг
Уйдаахгүй сэтгэлээр удирдах минь болтугай
Үлэмж хурднаа бядан явагч шувуун би
Дөрвөн зүг зовхисын өчүүхэн төвүүдийг нэжгээд өдөрт
Түрбэлгүй хүчит бусдад тус үйлдэгч
Тунамал хоёр үнэнийг ухсан хийн хүчээр
Түгээмэл огторгуйн хязгаар тураг амьтнаа
Аяа, шувууны хүчээр номын хур болгон оруулах болтугай
Арилгагч цуврилгүй рашааны уст
Аливаа юун арван гурван усан хийгээд дор
Аврид жаргалангаар угаах болтугай
Бас зуун найман булгийн сайн усанд
Баршгүй болгон авах цагт
Ба бүрэн амьтны жаргалан нь арвидах болтугай
Бас өлзий хутаг оршсон ийм буюу
Үлэмж хөвгүүний өмнөөс хөвгүүн биед
Үзэсгэлэнт охидын өмнөөс бээр
Охидын биед үзэсгэлэн бөгөөд болж
Уран аргаар номд зохиох болтугай
Хөвгүүнгүйд хөвгүүн болон төрж
Хөөрхий эдгүй хүнд эд болон төрөх болтугай.
Хүлэг үгүй хүнд хүлэг болон төрөөд
Хөвчин их мөрөн өчүүхэн мөрөн хийгээд дор

Хэтэрхий чин бат сал гүүр нь болтугай

Хэв хэзээ номхотгогдохууны үзэгдэлд

Хэр хүссэнийг баясгалангаар жаргуулах болтугай

Гэгээн сайн буянт гэрийн эзэн болж

Ав аль аялгуу үгсэд мэргэн болоод

Асар мэдэгчийн дээд манлай нь болтугай.

Аяа их өргөн хүндлэгч

Асар тэмцэл үгүй мэргэнээс мэргэн болмуй

Түүнчлэн Мэкүвал мэргэдийн манлай болоод

Тэмцэх хамаг үйлийг сайтар тэвчиж

Тэмцэл үгүй би хийгээд намайг үнэмшээгч

Дээд манлайн гэрч нь болтугай

Оюу зүрхт намайг хийгээд удирдагч сартваахийн

Хэрэгтнийг сэтгэшгүй сайтар бүтээж

Хэтэрхийеэ мэргэнээс мэргэн болон хувилж

Хэв хэзээ ном хийгээд цог заль дэлгэрүүлсэн

Тансаг бишрэлээр тонилохын мөрт оруулах болтугай

Дэргэд минь хоцролгуй чуулагсдыг бээр

Тэдгээрийг би сайтар нигүүлсэж

Дээд манлай мөрт оруулах болтугай.

Сайн тийм үгсийг сонсогтун, хатан шивэгчин хоёр

Сайтар өгүүлэв, энэ шөне зүрхний үгсийг

Сартваахийн ирсэн цагт их ачит болмуй за.

Сааралгүй ирээдүй цаг дахь дурдах шүтээй буй

Тнийм үгс өдгөө дэх миний чин нот үгс буй. хэмээн цаст Төвдөд Зуу Адишаа заларч ирээд бурхны долоон номыг төгс дэлгэрүүлэхийн цагт тэнгэр уулын хөмхөй дэх рашаанд хамаг чуулсанд бошго үзүүлэхийн үүднээс дээдийн номыг номлосонд хатагтай шивэгчин хоёрт гайхамшиг төрөөд «Бядан явагч их богд Сролон чи дээд гүн номыг номлохдоо алжаан чилэв зэ» хэмээгээд амтат идээг бэлдээд «Үүнийг зооглогтун» хэмээгээд бядан явагчид өгөв. Тэр мэтийн юмыг номлосноор шөнө өнгөрөв.

* * *

Бас хойд шөнө нь урьд шөнийн ёсоор бядан явагч шатны арвай хоёрдугаар гишгүүр дээр сууж,

– Аяа, Оюу зүрхт чи нааш ир. Зүүн этгээдэд минь суу. Би шөнийн зүүдэлсэн зүүдийг өгүүлж, уран аргаар сэтгэлийн үзэгдлэйг сэргээе хэмээсэнд Оюу зүрхт тэнд очиж суув. Бядан явагч өгүүллрүүн

Оюу зүрхт чиний хэл эвгэйхэн, эгшэг яруу, оюун сэргэлэн, тоть бөөт, оюу хайлмал, хөхөмдөг хумх адил, шувууны биет боловч дансан орох байшингийн хаалгыг түгжиж чадах бат оюунаар хариулт үйлдэж нисваанисын хаалгыг түгжсэн тул ам, хэрүүл, тэмцэл, гэм нүгэл тэргүүтний ерөндөг болсон баясгалант харшийн хаалгыг нээж ойн дотор сууж амьтныг номд оруулахын хаалгыг нээх бэрхийг нээж энэ мэт үйлдлийг сайтар хийж чадсан чам мэт нь сайн төрөлт хүний биеийг аваад сартваахь их богд болж хамаг олонд өргөгдөж, сэтгэшгүй хүний дотроос дээд манлай болоод, даруй нэгэн агшны төдий найман түмэн дөрвөн мянган нисваани-сыг хаалгыг хааж түүний ерөндөг найман түмэн дөрвөн мянганы тэнцэж үнэлшгүй орд харшийн хаалгыг нээснээс найман түмэн дөрвөн мянган номын цогцсын охь болсон нууц гүн мөр хаалгыг нээхүйеэ бэрхийг ч нээж чадагч болох амой. Тэнгэр болон төрвөөс чи хурмаст болоод мөн тэр мэт хаалгыг хаах буюу нээж чадагч болох амой. Тэр мэт Оюу зүрхт үгийг минь сонс. Энэ шөнө, шөнө дундаас хойш үүр шарлаж эхлэхийн үеэр надад арилсан үзэгдэл ургасан нь энэ мэт бөгөөд адилтгашгүй баясгалангаар нөхдийн төв дунд бядан явагч би сууж, баясгалант төлөв үгийг хэлэхэд тэд нар миний юу ярихыг сонсон сууцгаав.

Хатагтай шивэгчин хоёр ч урьдын явдал ёсыг үл үзүүлэн мишээн сууж сартваахийн зарлигийг сонсон бишрэв.

Бид хоёр шувууг ч муу хэмээхгүй «сайн түшмэл» хэмээн нэрийдэж сайхан амтат хоол хийж дээжээр тахив. Тэр цагт би ч сэтгэл сэргэн өөдлөн баясах байдалтай болов. Тэр цагт миний оройн үс цөм боссоны завсраар салхины нэгэн хий оуугин хийсвээс шулуун сайн үгээр эгшиглэн дуулагч, шил адил цагаан өнгөт тийм нэгэн хөвгүүн гартаа бөөрөнхий цагаан чулуу бариад гарч, үлэмж хурдны хүчээр сартваахийг угтав хэмээн зүүдлэв. Бас баатрын хүчээр ирүүлсэн гэрийн эзнийг буцав хэмээн зүүдлэв. Бас над лугаа адил нэгэн бээр огторгуйд баясгалантайгаар гүйж байхыг зүүдлэв. Бас болгож найруулсан сайхан амтат идээг сайтар идэв хэмээн зүүдлэв. Маргаашаас хойд өдөрт сартваахь ирэх буй. Биендээ ч гэмгүй, эрдэнэ авч ирэх буй. Маш олон худалдаачны хөвгүүн мэт тэтгэн ирмүй. Тэдгээр нь манлай сартваахийг эх мэт өргөж ирэхийг зүүдлэв хэмээн хэлсэнд тэр цагт Оюу зүрхт өгүүллрүүн:

– Миний зүүдэнд ч урьд шөнийн үүр шарлах үед ариухан үзэгдэл энэ мэт ургав. Их сартваахь тэрээр таван зуун худалдаачны төвд тансаг чандманийг авч амгалан морилж ирэв. Тэр цагт

шивэгчин нуугдаж суухдаа хар хөлс нь цутгав. Мэжүвал баатар зориг нь шантарч баргар хар царайтай болоод бачимдан дуугүй суув. Би түүннй сэтгэлийг нь сэргээж

Энэ мэт байваас тусгүй. Бүү гэмшигтүн. Баясгалангаар явагтун хэмээн сургавч хэвээр царайгаа барайлгаж, хийсэн гэмдээ машид гэмшин байхыг зүүдлэв.

Аяа Мэжүвал аа, тэр үгсийн утгыг тэжээл болгон авагтун хэмээснээс хөдөлшгүй чин нотод хөрвөх урвахгүй хэвтэн оршив. Тэр мэтийн үгийг ярьснаар арван хоёрдугаар шөнө өнгөрөв.

* * *

Бас хойд шөнө нь урьд шөнийн ёсоор бядан явагч Сролон арван гуравдугаар шатан дээр сууж ийн хэмээн шүлэглэн өгүүлрүүн:

Тэртээх эрт гучин гурав дахь улсад

Дээд гэрэлт тэнгэрийн хөвгүүн би бээр

Тахь тэнгэрийн олон хөвгүүдээр хүрээлүүлж

Тансагт бишгүүрийн яруу эгшигт дуугаар

Шулуун сайхан үгсээр хамгийг баясуулаад

Сансар дахь далайгаас аль тэр этгээдэд гэтлээд

Сайн муу зовлонгуудын дурыг үл хаах

Саарахгүй ахуй ёст тэр билгээр

Аливаа бэрх орон сайтар барин тонилмуй

Аяа сайн төрөлт үзэсгэлэнт хөвгүүд

Асар хоромхноо жаргах тийм сайн үйлээр

Аврид ямарваа үнэний зүрхэн үгүй буй

Түүгээр мөнх бус зовлонгийн шалтгаан буй

Тэдгээр орчлонгийн зовлонг сайтар тэвчиж

Дээд тонилохын балгадад одъё

Тийн хэмээн өгүүлээд олон тэнгэрийн хөвгүүдийг

Үнэн номд оруулаад өдгөө хүний улсад

Олон хувилгааныг маш сайтар шалгуулж

Үргэлжид хамгийг жаргалангийн мөрт барилдуулэ

Омогт сэтгэлээр тийн хэмээн үл эрэмшигтүн.

Энэрэхүй ёсоор шувуу хийгээд гөрөөсний чуулган

Элдэв дүрт бие болон хувилгаж

Энэхүү ёсоор хамгийг жаргаланд оруулав

Өдгөө Мэкүвал хатагтай шивэгчин хоёр аяа минь

Маргааш удирдагч их сартваахь ирэх буй

Магад замуудын бэлчрийг арчтугай

Маш амтаг сайн идээг бэлдтүгэй

хэмээн өгүүлэв.

Үүнээс цааш нь арван гуравдугаар шатны буюу арван гуравдугаар бүлэг бөлгөө. Тэр мэт арван гурван өдөрт тэр төдий сонин зүйл ярихад зарц оюуг арван гурван удаа хүргэж өгөв. Гэрийн эзэн ч урьдын явдлыг зэмлэхийн хамт оюуг авч хуучин үлгэрийг төгсөхийн өмнөх шөнө бүр хаалганы дэргэд ирээд гадна сууж, шөнө үлгэр дуусахын үед тэр босож харимуй. Шивэгчин өгүүлэх нь,

Энэ муу шувуу урьд шөнө хэрэггүй үлгэр өгүүлсээр бидний их дуршлыг эвдээд их баясалцах үйлэнд саад болов. Тэр муу шувуу тийн эс ярьсан аваас уулзалдах учиртай хоёр учрах бөгөөд, одоо бас түр баясалцахад өлзий бус болж саад хийж байна хэмээх тэргүүтнийг өгүүлсээр олонтаа сэгсрэн дэлдвээс ч хувилгаан шувуу нь аргаар эс эндэв.

Арван гурав дахь хоногийн шөнө шивэгчин нь гэрийн эзнийг харшийн дээрээс дээсээр татахад бядан явагч шувуу байшингийн дорно өнцөгт сууж байв. Оюу зүрхт тоть өрнө өнцөгт сууж байв. Тэр цагт бядан явагч

Татагтун татагтун, дээш тат

Тасралгүй тат, муу үгсийг тат

Тасар татаад, муу нүглийг тат

Тэргүүн чинь үл хүсэвч хагармуй

хэмээвээс оюу зүрхт

Огоорогтун огоорогтун хүзүүгээ тасарму

Орхигтун орхигтун зовох амой

Үлдэгтүн үлдэгтүн, тат муу нүглийг

Тат татагтун

хэмээн өгүүлвээс тэр цагт шивэгчин ч яаран мэгдээд алжаах хилэгнэх, инээх, чадал мөхөс болох тэргүүтэн олон янз болоод татах дээс нь тасран унасан тул тэртээ доор тэргүүн хагарсан чимээг сонсоод тэр даруй бядан явагч өгүүллрүүн

«Унав, унав, муу үг унав. Үтэр хагарав, хагарав. Тэргүүн нь хагарав. Дээс тасрав тасрав. Сэтгэл нь цөхрөв үү? Өөрийн гэрт хариад эгэж ирэхгүй болов. Хи хи хи хи» хэмээн инээсэнд Оюу зүрхт:

«Гавьяагүй муу шивэгчин удирдав.

Галзуу сэтгэлээр мууг удирдаж

Гашуун зовлонт үйлд удирдав чи

Бусчир тийм үйлээр хүнийг аргадваас

Буцалгүй тийм үйлс өөрийн биед болмуй за

Богд сайн сайн

Бядан явагч аа, дайсны тэргүүн хагарав хэмээн эмгэнэмүй

Муу зочдын тэргүүн нь балбарав, шивэгчин ээ

Магад өөрийн үйлээ сайтар хадгалъя

Муу үйлсийг хойшид сайтар огооръё

Мэдэж тийм үйлсийг дотроо оруулья

Тийм гавьяагүй муу үйл өдгөө

Тэмдэгтэйеэ саваагүй шивэгчний сэдлэг буй»

хэмээн сэтгэл цэнгэн баясгалант хуримын үгийг хэлээд өнөө маргааш их тус хүргэсний ачийн хариуг өгүүлсэн болой. Түүнээс гаднахыг гадагш явуулж, дотныг дотогш оруулав. Өлзий хутаг оршсон шөнө өнгөрч, өлзий хутаг оршсон маргаашийн өдөр болоход удирдагч сартваахь таван зуун худалдаачны хамт өөрийн харшид амгалан ирсэн тэр цагт урьдын болсон шалтгааныг сартваахийн сонорт бядан явагч бээр ийн өгүүлэв.

«Сацлал үгүй хувилгааны дээд манлай удирдагч

Сартваахь одсоны хойно есөн сар болсонд

Сайн гайхах мэт гайхамшигийг үзүүлсэнд

Саарал үгүй хатагтай шивэгчин хоёр тиймийг үзэхээр одвоос

Аяа Сайнбуянт гэрийн эзнээ аргадсанд

Аргагүй хаалгыг сайтар баталж

Аргаар хуулийг сайтар номлон сахив би

Арван гурван шөнө нөгчсөний хойно мэнд хүрч ирэв чи

Төдий чинээ чимэгт оюу эрдэнэ үгүй болбоос

Дээр нигэгч шувуу би мэссийн ёсоор хэмхлэв

Тийн муу номхотгогдохууныг өдгөө бээр

Тэдгээр муу эмсийг номготгож үл чадмуй

Аглаг оронд сайтар бясалгахаар одъё

Асар чиний итгэсэн үүргээ гээж

Аврид сайн үйлсийг бүтээхээр одъё»

«Удирдагчийн ирсэнд маш сайтар баясалцав би

хэмээн лүгээ Оюу зүрхт өгүүлрүүн:

Урьдын хүнд зарлигаар энэлгэвээс бээр

Үл суун ой дотор одмуй, жигүүртэн шувуу би

Үлэмж эрдэнийн тивд алт олон боловч

Төлд алт юун тус болмуй, загас манлайд

Тун эд таваараар хотыг дүүргэвээс бээр

Тоть надад өчүүхэн ач тус үгүй болмуй за

Төлд би ямагт өдгөө аглаг ойн дотор

Үсээ өрвийлгөж үхвээс

Өчүүхэн бээр тус үгүй, дээд ном хэрэгт буй

Үлэмж хүн төрөлхтний ийм ёсыг үзвээс

Өөдгүй миний мэт адгуус хэр жаргамуй»

хэмээвээс сартваахь нулимс алдаад ийн өгүүлрүүн

«Сайн тоть оо. Та хоёрын үг чинь үнэн буй за. Сэтгэлээ бүү цөхөр. Сайтар хураан зөөсөн эдийг минь ид. Би ч та хоёрыг энэ үеэс эхлээд төрөл тутамд номын ёсоор тэтгэсүгэй. Үлэмж эцэст умар зүгийн хязгаар дахь төвд улсад та хоёр бэлгэдэж олон шавь нарыг эрдэнэт номын цог залиар хураасугай. Энх амгалангаар бядан явагч хувилгаан шувуу минь ээ. Чиний мэтийн дээдэс, сэтгэл цөхрөх бөгөөс чөлөөт гэрийн үйлийг тэвчиж, чин зорилгоор магад дамжиггүй тойн болгосугай би. Чуулсан бүгд намайг сэтгэх бөгөөс дээд төрөлхтөн бядан явагч үүнээс номыг сонс. Хуурмаггүй баясгалант рашаан гаргах нь дамжиггүй. Түүнээс ч би тойн болмуй хэмээн бядам явагчид ном номлохыг шаардах хийгээд таван зуун худалдаачин тэргүүтэн энд чуулсан бүхэнд гүн мөрийн номыг сонсохыг шаардав. Бядан ядагч өгүүлрүүн:

«Төрөх үхэх нь мөрний давалгаатай адил

Төдөлгүй дээш доош оршин амой

Төрөх үхэх нь наран гарах орохтой адил

Түрбэл үгүй тэрхүү ёсоор аху болмуй

Хамт энэ нас нь хорт далайтай адил

Гэтлэшгүй амтат болбоос нас нь охор болмуй

Гэргий тань ариун бус хорхойтой адил

Хямралт буртаг болоод яахан жаргамуй

Эс арилсан амьтны сэтгэл цөхрөхгүй

Энэрч сургаваас хэр болмуй

Эгнэгт тусалваас чийг нь үл хариулан энэлгэмүй

Эх юүгээ алгадваас дагахгүй болоод

Дайсныг ихэд энэлэгдвээс үнэн хэмээмүй

Тансаг энэ гэрээс их удирдагч сартваахь

Даруй гарч тойн болоод бадам цэцэрлэгт

Тэдгээр хамаг худалдаачны хөвгүүдийн чуулганд

Баясгалант амгалант номоор тэтгэн авар

Балмад эм хүн хоромхноо үзэсгэлэнт болоод

Баясах мэт болбоос аминд хорт болгомуй»

хэмээн өгүүлсэнд их удирдагч сартваахь нь төдий даруй гэрээс гарч тойн болоод, таван зуун худалдаачныг дээд номд оруулав. Нэрийг ч аяга тахимлиг Сайнбуян хэмээн алдаршив. Аргат Мэкувал шивэгчин хоёр ч дээд богдсын гүн нарийн номыг сонсож, өнө болтол төмрийг зүлгэн арчваас барагдах мэт. Үтэр тэр хоёр магад гансран тойн болж дээд номоор явав. Эд агуурсыг өглөг болгон өгсөн цагт тэр улс дахь хамаг бүгдээрийг эд агуурсаар баяжуулан өрнүүлэв хэмээн арван гурван гишгүүрт шатны үлгэрийн дэлгэрэнгүйгээр өгүүлэв. Бас хүүр өгүүллрүүн:

– Арван гурван гишгүүр дээр арван гурваад арван гурваад шувуу, тэр шувууд тутмын аман дотор арван гурваад арван гурваад буудай бөлгөө. Тэд бүгдийн тоог олвоос зохино хэмээсэн тул түүнийг тоолон ядсаар Наганжуна багшийн дэргэд хүрч ирэв.

Шидэт хүүрийн үлгэрээс сартваахь Сайн буян хэмээгч эрдэнэ авахаар далайд одсоны эзгүй хойгуур Сролон бядан явагч нь шатны арван гурван гишгүүрийн үлгэрийг өгүүлсэн тул Сайн амгалан явдалт хаан бээр үг алдалгүйгээр хүүрийг авч ирснээс багшид өргөсөн бүлэг лүгээ бүгдийг нийлүүлвээс гучин есөн бүлэгт мөн боловч арван гурван гишгүүрийн энэ үлгэрийг ганц бүлэг хэмээн өгүүлэх тул эцсийн бүлэг буюу хорин долдугаар бүлэг болой.

Амьтны сайн чуулганы явдал бүхэн маш дэлгэрэх болтугай.